



www.goviinoyu.mn



ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН

ТАНЫ ОРОЛЦОО - ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮНДЭС

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



2019

ТАНЫ ОРОЛЦОО
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮНДЭС

ТАНЫ ОРОЛЦОО
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮНДЭС

>>> АГУУЛГА



Удирдах зөвлөлийн даргын мэндчилгээ 3

Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан 6

Говийн Оюу хөгжлийг дэмжих сангийн засаглал 8

Сангийн Удирдах зөвлөл 8

Харилцааны хороо 9



Говийн Оюу хөгжлийг дэмжих санд хүлээн авах саналын чиглэл, шалгуур, санхүүжилт олгох үндсэн чиглэл 10

Санхүүжилт олгох үндсэн чиглэл 10

ХДС-ийн санхүүжилтийн хуваарилалтын стратеги 2018-2020 12

Санхүүжилт олгох үйл явц 13

Ирээдүй хойч үеийн төлөө сан 14

Говийн оюу-Бизнес боломж” бизнесийн бичил зээл 14

Ирээдүй хойч үеийнхэнд зориулсан хадгаламж 18

“Говийн Оюу-Оюутны тэтгэлэг” хөтөлбөр 18



Батлагдсан төсөл хөтөлбөрийн хэрэгжилт 22

ХДС-ийн Удирдах зөвлөлөөс баталсан төсөл хөтөлбөрүүд 22

НҮБ-ийн тогтвортой хөгжлийн зорилтуудад 23

ХДС-ийн оруулсан хувь нэмэр 23

Говийн Оюу хөгжлийг дэмжих сангийн санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийн мэдээ 24

ХДС-ийн 2019 онд Өмнөговь аймагт оруулсан хөрөнгө оруулалт 25

ХДС-ийн 2019 оны онцлох үйл явдал 29

Сангийн 2019 оны санхүүжилтийн эх үүсвэрийн хуваарилалт 30

Батлагдсан төсөл хөтөлбөрийн хэрэгжилт 34

Нийгмийн дэд бүтцийн чиглэлийн төслийн хэрэгжилт 34

2018 оноос он дамжин хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд 46

2019 онд санхүүжүүлж хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд 66





Санхүүжилтийн квот-2019 76

Санхүүжилтийн квот, зорилго	76
2019 онд Ханбогд суманд санхүүжилтийн квотоор хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд	77
2019 онд Манлай суманд санхүүжилтийн квотоор хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд	91
2019 онд Баян-Овоо суманд санхүүжилтийн квотоор хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд	101
2019 онд Даланзадгад суманд санхүүжилтийн квотоор хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд	113
2019 онд Сэврэй суманд санхүүжилтийн квотоор хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд	123
2019 онд Булган суманд санхүүжилтийн квотоор хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд	129
2019 онд Номгон суманд санхүүжилтийн квотоор хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд	134
2019 онд Цогт-Овоо суманд санхүүжилтийн квотоор хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд	141
2019 онд Баяндалай суманд санхүүжилтийн квотоор хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд	151
2019 онд Мандал-Овоо суманд санхүүжилтийн квотоор хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд	155



Сангийн ил тод байдал 165

Сангийн хяналт, шинжилгээ-үнэлгээ 167

Харилцагч байгууллагууд 178

Санхүүгийн тайлан 183

Төсөл хөтөлбөрүүдээс үр шим хүртэгчдийн сэтгэгдэл 187



САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ

Та бүхэнд “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн 2019 оны үйл ажиллагааг танилцуулж байгаадаа баяртай байна.

Өмнөговь аймаг, “Оюу толгой” компани хоорондын хамтын ажиллагаа жилээс жилд бэхжиж, уг хамтын ажиллагааны үр дүнд бий болсон “Говийн Оюу хөгжлийн дэмжих сан”-гийн маань үйл ажиллагаа өргөжин, Өмнөговьчуудын хөгжил дэвшилд хувь нэмэр оруулах төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэн хэрэгжүүлээд дөрөв дэх жилээ үдэж байна.

“Оюутолгой” компани “Эрдэс баялгаас эрдэм мэдлэг, ур чадвар, үнэт зүйлс бүтээлцэнэ” гэх алсын хараатайгаар Монголын говь нутагт эрдэм мэдлэг, ур чадварын уурхай босгож, эрдэс баялгаас үнэт зүйл бүтээн, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах эрхэм зорилготойгоор ажиллаж байна.

Энэхүү алсын хараа, эрхэм зорилгынхоо хүрээнд “Оюу толгой” компанийн үйл ажиллагаагаа явуулж буй нутаг болох Өмнөговь аймаг, тус аймгийн Ханбогд сумтай Хамтын ажиллагааны гэрээ байгуулсан билээ. 2015 оны дөрөвдүгээр сарын 22-нд байгуулсан энэхүү гэрээг Монгол Улсын Ашигт малтмалын тухай хууль болон хөрөнгө оруулагч “Рио Тинто” группийн олон улсад хэрэгжүүлдэг стандартын дагуу байгуулж, орон нутгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх аргачлалаа тодорхойлсон юм.

Хамтын ажиллагааны гэрээг хэрэгжүүлэх гол бүтэц “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” ТББ 2015 оны есдүгээр сард байгуулагдсанаасаа хойш Хамтын ажиллагааны гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн дүүрэн биелүүлэн ажиллаж байна. “Оюутолгой” компани Хамтын ажиллагааны гэрээгээр өгсөн амлалтынхаа дагуу жил бүр таван сая ам.доллартай тэнцэх төгрөгийг “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” -аар дамжуулан Өмнөговь аймгийн тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхэд зарцуулж байна.

Үүсгэн байгуулснаас өнөөг хүртэл уг сангаар дамжин Өмнөговь аймагт 51.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, 180 төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэн,

амжилттай хэрэгжүүлээд байна. Үүнд иргэдэд нэн хэрэгцээтэй байсан хүүхдийн цэцэрлэг, сургууль, сумдын хүн эмнэлэг, спорт заал, сумдын халаалтын уурын зуух зэрэг нийгмийн дэд бүтцийн томоохон төслүүдээс гадна иргэдийг чадавхжуулах, мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх, сургалтын болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, байгаль орчныг хамгаалах, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэсэн хөгжлийн олон хөтөлбөр багтаж буй.

ХДС-ийн 2019 онд нийгмийн дэд бүтцийн чиглэлээр санхүүжүүлсэн томоохон төслүүдийг дурдвал: Манлай суманд тавилга, тоног төхөөрөмж, тоглоом хэрэгслээр иж бүрэн хангасан 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга, Мандал-Овоо суманд 10 ортой эмнэлэг, автомашины граж бүхий эрүүл мэндийн төвийн барилга, Баян-Овоо суманд хагас автомат уурын зуухыг шинээр ашиглалтад оруулсан бол Даланзадгад суманд баригдаж буй 9.8 тэрбум төгрөгийн төсөв бүхий музейн барилга, Ханбогд сумын өвс тэжээлийн агуулах, сумын төвийг үерээс хамгаалах үерийн далан сувгийн төслүүд нь ажлын цар хүрээ, цаг хугацаанаас шалтгаалан он дамжиж ашиглалтанд оруулахаар барилга угсралтын ажил үргэлжилж байна. Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд хийсэн ажлуудаас онцлох нэг жишээ нь Өмнөговь аймгийн “Хөдөө аж ахуй, үйлдвэржилтийн жил”-тэй уялдуулан санхүүжүүлсэн олон талын оролцоотой 3 жилийн хөтөлбөр болох “Мал угаалга, хашаа хорооны ариутгал-2019” хөтөлбөр юм.

Төсөл хөтөлбөр санхүүжүүлэхээс гадна бид 4 жилийн хугацаанд “Говийн Оюу-Оюутны тэтгэлэг” хөтөлбөрийн хүрээнд Өмнөговь аймгийн 187 оюутанд 474.5 сая төгрөгийн тэтгэлэг олгож, “Говийн Оюу-Бизнес боломж” бичил зээлийн хөтөлбөрийн хүрээнд 44 бизнес эрхлэгчдэд 1.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгоод байна.

2018 онд ХДС-ийн 3 жилийн стратегийг тодорхойлон баталснаас хойш Сангийн санхүүжилтийг сумдад тэгш хүртээх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор түншлэгч болон уул уурхайгүй сумд санхүүжилтийн квот олгож, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, орон нутгийн захиргааны байгууллага хамтран сумандаа нэн шаардлагатай, нийгэмд хэрэгцээтэй төсөл хөтөлбөрийг санаачлан, сангийн дүрэм, журмын дагуу өөрсдөө сонгон шалгаруулж, хэрэгжүүлэх бололцоог олгож эхэлсэн. Санхүүжилтийн квот амжилттай хэрэгжиж зорилтот арван сумдын маань иргэд олон чухал төслийг санаачлан өөр өөрсдийнхөө сум, орон нутагтаа хэрэгжүүлж байна.

Үүнээс цухас дурдвал, Ханбогд суманд ахмад настнуудын эрүүл мэндэд чиглэсэн “Эрүүл насжилт” хөтөлбөр, Манлай суманд иргэдийн эрүүл мэндэд чиглэсэн бялдаржуулах төв байгуулах “Фитнес төхөөрөмж” төсөл, Баян-Овоо суманд ерөнхий боловсролын сургуульд мэдээлэл зүйн кабинет бий болгож тохижуулах “Шинэ сонголт” төсөл, Даланзадгад суманд хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад настай иргэдийг төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд зориулсан өргөх төхөөрөмж нийлүүлсэн “Бүгдэд ээлтэй төрийн үйлчилгээ” төсөл, Баяндалай суманд хүүхдүүдэд зориулсан спорт талбай байгуулах төсөл, Сэврэй суманд эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийг дэмжих зорилго бүхий “Гар урлалын төв” байгуулах төсөл, Номгон

суманд эрүүл мэндийн төвд зөөврийн тоног төхөөрөмж нийлүүлэх “Эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж” төсөл, Цогт-Овоо суманд эрүүл мэндийн төвийг бүрэн хянах, аюулгүй байдлыг хангах “Хяналтын камер” төсөл, Мандал-Овоо суманд яслийн анги нээн ажиллуулах “Ясли-хүүхэд хөгжил” төсөл гэх мэт тус сумдад 2019 онд нийт 87 төсөл амжилттай хэрэгжиж байна

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” маань цаашид ч Хамтын ажиллагааны гэрээгээр хүлээсэн үүргээ чандлан биелүүлж, говь нутгийн хүн ардын амьдралыг дээшлүүлэхэд дэмжлэг болж ажиллах болно. Сангийн маань үйл ажиллагаа өргөжин, орон нутаг ба “Оюу толгой” компанийн харилцан итгэлцэл, хамтын ажиллагаагаар улам хөгжиж, хамтдаа итгэл төгс урагшилна гэдэгт итгэлтэй байгаагаа өөрийн зүгээс болон сангийн Харилцааны хороо, Удирдах зөвлөлийн нэрийн өмнөөс баяртайгаар илэрхийлье.

“Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ”

“Оюутолгой” ХХК-ийн Уурхайн үйл ажиллагаа эрхэлсэн захирал,
“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн Удирдах зөвлөлийн дарга



Тим Экерсли

ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН

АЛСЫН ХАРАА

Итгэлцэлд суурилсан
сайхан ирээдүйг
Өмнөговьд бид
хамтдаа бүтээнэ



ЭРХЭМ ЗОРИЛГО



Өмнөговьчуудын сайн
сайхан амьдралыг
дэмжсэн хамтын
хөгжлийн санаачилгыг
санхүүжүүлэгч сан
байна

ЭРХЭМЛЭХ ЗАРЧИМ



1. Авилгалаас ангид байх
2. Хувийн ашиг сонирхлоос ангид байх
3. Үндэслэл, тооцоо баримт нотолгоонд суурилсан шийдвэр гаргах
4. Аливаа ялгаварлалгүйгээр нутгийн иргэдийн шударга оролцоог дэмжих, тэгш боломжоор хангах
5. Бүх төслүүд Сангийн эрхэм зорилготой уялдсан байх
6. Батлагдсан төслүүд тохиролцсон үр дүндээ хүрдэг байх

»» ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН

Өмнөговь аймаг, тус аймгийн Ханбогд сум болон “Оюутолгой” ХХК-ийн хооронд байгуулсан Хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтийг хангах үүднээс **“Говийн Оюу Хөгжлийг дэмжих сан”** Төрийн бус байгууллагыг 2015 оны 09 сарын 25-ны өдөр үүсгэн байгуулсан.

Уг гэрээний 8.3-т заасны дагуу “Оюу толгой” компани нь жил бүр 5 сая ам.доллар түүнтэй тэнцэх төгрөгийн санхүүжилтийг “Говийн Оюу ХДС”-д олгодог. “Говийн Оюу ХДС” нь эрүүл мэнд, боловсрол, сургалт, хөдөлмөр эрхлэлт, орон нутгийн бизнесийн хөгжлийг дэмжих, байгаль орчин, соёлын өвийг хамгаалах зэргээр аймгийн болон Түншлэгч сумдын тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахад чиглэгдсэн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх, тэдгээрийг үр ашигтай, зүй зохистой удирдан зохион байгуулах зорилготой ажиллаж байна.

»» САНГИЙН ЗАСАГЛАЛ САНГИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



Сангийн эрх барих дээд байгууллага болох Удирдах зөвлөл нь Өмнөговь аймаг, Ханбогд сум болон “Оюутолгой” компанийн төлөөлөл 7 хүний бүрэлдэхүүнтэй.

Сангийн хяналтын зөвлөлийн үүргийг хараат бус Итгэмжлэгдсэн зөвлөх хэрэгжүүлдэг бол Гүйцэтгэх захирлаар ахлуулсан 4 хүний бүрэлдэхүүнтэй ажлын алба өдөр тутмын үйл ажиллагааг эрхэлдэг.

Хуулийн хүрээнд байгуулсан дээрх бүтцээс гадна талууд Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд харилцан ойлголцол хамтын ажиллагааг дэмжих зохицуулах үүрэг бүхий Харилцааны хороог байгуулсан. Удирдах зөвлөлд зөвлөмж өгөх үүрэгтэй Харилцааны хороо нь “Оюутолгой” компанийн төлөөлөл 4 хүн, орон нутгийн төлөөлөл 9 хүн нийт 13 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна. “Оюутолгой” компанийн төлөөллийг хангамж, хүний нөөц сургалт, байгаль орчин, орон нутгийн харилцаа гэсэн орон нутагтай илүү хамтран ажиллах шаардлагатай хэлтэс албадаас сонгодог бол орон нутгийн зүгээс сумдын удирдлага, аймгийн салбар хариуцсан хэлтэс агентлагийн удирдлага, иргэний нийгмийн байгууллагын төлөөллөөс бүрдүүлдэг.

»» ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САНГИЙН ЗАСАГЛАЛ

“Оюу толгой” компани, Өмнөговь аймаг, Ханбогд сумын хооронд байгуулсан Хамтын ажиллагааны гэрээний дагуу талуудын оролцоог хангах зорилгоор “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөл болон Харилцааны хороо гэх хоёр бүтцээр Өмнөговь аймагт нэн тэргүүнд хэрэгцээ шаардлагатай байгаа төсөл хөтөлбөрүүдийг хэлэлцүүлэн сонгон шалгаруулж, санхүүжилт олгох бүхий л үе шатанд орон нутаг болон “Оюу толгой” компанийн төлөөлөлтэй хамтран ажиллаж байна.

»» САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Сангийн Удирдах зөвлөл нь “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-ийн эрх барих дээд байгууллага юм. Удирдах зөвлөл 7 гишүүнээс бүрдэнэ. Өмнөговь аймаг болон Ханбогд сум хамтран орон нутгийн төлөөлөл 3 гишүүнийг нэр дэвшүүлж, “Оюу толгой” компаниас 4 гишүүнийг нэр дэвшүүлэн Удирдах зөвлөлийг бүрдүүлдэг.

Сангийн удирдлагыг сайжруулах болон Хамтын ажиллагааны гэрээнд нийцэж ажиллахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Сангийн дүрмийн дагуу Удирдах зөвлөлд зөвлөгөө өгөх, дүрмийн хэрэгжилтийг сахиулах эрх бүхий хараат бус Итгэмжлэгдсэн зөвлөх томилогдон ажиллаж байгаа.

Сангийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн



Тим Экерсли
Удирдах зөвлөлийн дарга



Б.Баяр
Сангийн Итгэмжлэгдсэн зөвлөх



Х.Сугир
УЗ-ийн Гишүүн



Н.Наранбаатар
УЗ-ийн Гишүүн



Б.Эрдэнэ-Очир
УЗ-ийн Гишүүн



Лаура Томас
УЗ-ийн Гишүүн



Д.Амарбаясгалан
УЗ-ийн Гишүүн



Ш.Байгалмаа
УЗ-ийн Гишүүн

ХАРИЛЦААНЫ ХОРОО

Сангийн Харилцааны хороо нь Хамтын ажиллагааны гэрээний дагуу байгуулагдсан Өмнөговь аймаг, “Оюу толгой” компани болон сангаас хамтран ажиллах Түншлэгч сумдын харилцаа хамтын ажиллагааг зохицуулах, дэмжлэг үзүүлэх, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих зорилготой бүтэц юм. Харилцааны хороо 13 гишүүнээс бүрдэнэ. Өмнөговь аймаг болон Ханбогд сум хамтран нэр дэвшүүлж орон нутгийн 9 төлөөлөгчийг томилох бол “Оюу толгой” компаниас 4 гишүүнийг дараах байдлаар томилон ажиллаж байна.

Харилцааны хорооны бүрэлдэхүүн



Х.Батболд



Ш.Байгалмаа



Ө.Баянмөнх



Ж.Сүх-Эрдэнэ



Ү.Энхцэрал



О.Мандахбаяр



Ш.Эрдэнэжаргал



Г.Буянхүү



А.Оюунтуяа



В.Мөнхбат



М.Ариунтунгалаг



Д.Амартүвшин



Н.Эрдэнэбаяр

»» ГОВИЙН ОЮУ ХДС-Д ХҮЛЭЭН АВАХ САНАЛЫН ЧИГЛЭЛ, ШАЛГУУР, САНХҮҮЖИЛТ ОЛГОХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд талууд үүрэг, амлалт хүлээсэн. Энэ дагуу “Оюу толгой” компани нь нийгмийн дэд бүтэц, байгаль орчин, усны менежмент, үндэсний түүх соёл, уламжлалт мал аж ахуй, нийгмийн суурь үйлчилгээ, орон нутгийн бизнесийн хөгжлийг дэмжих, тэднээс бараа үйлчилгээ худалдан авах гэсэн 7 сэдэвчилсэн чиглэлээр Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахаар харилцан тохиролцсон.

“Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” дээр дурдсан нийгмийн дэд бүтэц, байгаль орчин, усны менежмент, үндэсний түүх соёл, уламжлалт мал аж ахуй, нийгмийн суурь үйлчилгээ гэсэн 6 чиглэлээр Өмнөговь аймагт хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн саналыг иргэд, байгууллагуудаас хүлээн авч Харилцааны хороо болон Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн аймагт нэн тэргүүнд шаардлагатай төсөл хөтөлбөрийг шалгаруулж санхүүжилт олгодог.


Харин Орон нутгийн бизнес хөгжил, бараа үйлчилгээ худалдан авалтын чиглэлийн төслүүдэд санхүүжилт олгохдоо бид “Хаан банк”-тай гэрээ байгуулж, бичил зээлийн үйлчилгээг хариуцуулснаар жил бүр бизнесээ шинээр эхлүүлэх болон өргөжүүлэх зорилготой Өмнөговь аймгийн бизнес эрхлэгчдэд 50 сая хүртэлх төгрөгийн сарын 1%-ийн хүүтэй хөнгөлөлттэй зээл санал болгож, төслийн уралдаан зарлан шалгаруулж байгаа.

САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ХАРИЛЦААНЫ
ХОРОО, ГОВИЙН ОЮУ ХДС, ТӨСӨЛ САНААЧЛАГЧ

ҮНДСЭН 7 СЭДЭВЧИЛСЭН ЧИГЛЭЛЭЭР ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР САНХҮҮЖҮҮЛЖ ӨМНӨГОВЬ
АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛД ХУВЬ НЭМЭР ОРУУЛНА.

АШГИЙН БУС НИЙГЭМД ЧИГЛЭСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН САНАЛ АВАХ ЧИГЛЭЛЭҮҮД


САНХҮҮЖИЛТИЙН ЧИГЛЭЛЭҮҮД



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЖИЖИГ ДУНД БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ-БИЗНЕСИЙН БИЧИЛ-ЗЭЭЛ

Орон нутгийн бизнес хөгжил & бараа үйлчилгээ худалдан авалт


»»» САНХҮҮЖИЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛ



»»» ХДС-ИЙН САНХҮҮЖИЛТИЙН ХУВААРИЛАЛТЫН СТРАТЕГИ 2018-2020

3 жилийн үндсэн чиглэл нь хүний хөгжилд чиглэсэн байна: Үнэлгээ, мэдлэг, ойлголт, ур чадвар нэмэгдүүлэх, зан төлөв, дадал зуршил өөрчлөх сургалт:

- Хөдөө аж ахуй
- Боловсрол
- Эрүүл мэнд
- Бизнес хөгжил




Зорилтот газар

- | | |
|---|-----------------------|
| 1 | ✓ ОТ Түншлэгч сумд-4 |
| 2 | ✓ Уул уурхайгүй сум-6 |
| 3 | ✓ Бусад сум-5 |

»» «ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН»-ИЙН САНХҮҮЖИЛТ ОЛГОХ ҮЙЛ ЯВЦ

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” үүсгэн байгуулагдсанаас хойш мөрдөн ажиллаж байсан санхүүжилтийн дүрэм журмуудад 2018 онд зохих өөрчлөлт оруулан сангийн санхүүжилтийн 3 жилийн стратеги, үндсэн чиглэлийг шинээр баталсантай уялдуулан 2018 оны 2-р улирлаас эхлэн сангийн стратеги үндсэн чиглэлийн дагуу төслийн сонгон шалгаруулалт хийх хэлбэрээр төсөл хөтөлбөрийг шалгаруулан санхүүжүүлж эхлээд байна.

Сан нь төсөл зарлах үйл явцаа нийгмийн дэд бүтцийн төсөл болон тогтвортой хөгжлийн хөтөлбөр гэсэн 2 хэсэгт хуваасан. Нийгмийн дэд бүтцийн шинж чанартай Өмнөговь аймагт бий болгох бүтээн байгуулалтын төслүүдийг сонгохдоо аймгийн ЗДТГ -аас зөвлөсний дагуу, судалгаа шинжилгээнд үндэслэх бөгөөд Сангаас санхүүжүүлэх нийгмийн дэд бүтцийн бүх төслүүдэд зураг төсөл, менежмент болон үйл ажиллагааны зардлыг бүрэн шийдсэн байхаар тодорхойлно. Тогтвортой хөгжлийн хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхдээ 3 жилийн стратегид тусгагдсан чиглэлийн дагуу жил бүр төслийн уралдаан зарлаж шалгуурт нийцсэн төсөл хэрэгжүүлэгчийг сонгож хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.



»» “ИРЭЭДҮЙ ХОЙЧ ҮЕИЙН ТӨЛӨӨ” САН

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь Хамтын ажиллагааны гэрээний зорилгод хүрч ажиллахын тулд Санхүүжилтийн удирдамжид заасны дагуу жилийн нийт санхүүжилтийнхээ 5%-ийг ирээдүй хойч үедээ зориулан хуваарилдаг. Энэхүү хойч үедээ зориулсан хөрөнгө нь эргэлтийн сангийн хэлбэртэй байх бөгөөд “Говийн оюу- Бизнес боломж” бизнесийн бичил зээлийн хөтөлбөр, Хадгаламж, “Говийн оюу- Оюутны тэтгэлэг” гэсэн үндсэн гурван хэлбэрээр зарцуулагдаж байна.

»» ГОВИЙН ОЮУ-БИЗНЕС БОЛОМЖ” БИЗНЕСИЙН БИЧИЛ ЗЭЭЛ



ХААН БАНК


“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь 2016 оноос хойш “Говийн оюу – Бизнес боломж” хөтөлбөрийг хэрэгжүүлж, бизнесийн бичил зээлийг Хаан банкаар дамжуулан олгож байна. 2016-2019 онд Өмнөговь аймгийн 44 бизнес эрхлэгч иргэдийг дэмжиж зээл олгосон. Одоогийн байдлаар бичил зээлийн хөтөлбөр нь 4 дэх жилдээ амжилттай хэрэгжиж нийт 1.2 тэрбум төгрөгийн зээл олгоод байна.

Зээл авсан бизнес эрхлэгчдийн харьяалал

Сум	Зээлийн тоо	Олгосон зээл- /өссөн дүнгээр/
Даланзадгад	31	918,000,000
Ханбогд	10	177,000,000
Манлай	2	45,020,000
Мандал-Овоо	1	28,000,000
Нийт	44	1,168,020,000

Олгосон бичил зээлийн зориулалт

Бизнесийн зээлийн төрөл, n=44



»»» “ГОВИЙН ОЮУ-БИЗНЕС БОЛОМЖ” ЗЭЭЛЭЭР ХЭРЭГЖСЭН ЗАРИМ ТӨСӨЛ

Төсөл хэрэгжүүлэгч “Нинж ачлал” ХХК нь 2010 оноос Өмнөговь аймгийн Даланзадгад суманд “Нинж ачлал” хүүхдийн эмнэлгийг нээн ажиллуулж байна. Тус компани нь үйл ажиллагаагаа өргөжүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээний нэр төрөл, оношилгооны чадамжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай 50,0 сая төгрөгийг зээлж, орчин үеийн стандартад нийцсэн эмнэлгийн тоног төхөөрөмж болох шээсний шинжилгээний автомат анализатор, цусны шинжилгээний бүрэн автомат гематологийн анализатор, эмнэлгийн ор, ЭХО аппарат, биоэнергомассажер зэрэг тоног төхөөрөмж худалдан авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.



Төсөл хэрэгжүүлэгч “Ганган тайж” ХХК нь Өмнөговь аймгийн Даланзадгад суманд талх нарийн боовны Анар цехийг ажиллуулдаг. Түрээсийн байранд үйл ажиллагаагаа явуулдаг тус компани 50,000,000 төгрөгийн төслийн зээлд хамрагдан, Өмнөговь аймгийн Даланзадгад сум, Зүүн сайхан 3-32 тоот хаягтай, 130 м.кв талбайтай үйлдвэрийн барилга барьсан. Цехийн барилга ашиглалтанд орсноор үйл ажиллагаа жигдэрч бүтээгдэхүүнийхээ төрлийг нэмэгдүүлсэн бөгөөд ашиг орлого нэмэгдэх төлөвтэй ажиллаж байна.

Төсөл хэрэгжүүлэгч Ж.Амартүвшин нь Өмнөговь аймгийн Даланзадгад суманд гэрэл зураг, хэвлэл, хаяг, рекламн эх бэлтгэлийн студи ажиллуулдаг ба түрээсийн байранд үйл ажиллагаагаа явуулж байгаад өөрийн өмчлөлийн ажлын байртай болох зорилгоор 35,000,000 төгрөгийн төслийн зээлд хамрагдсан. Ингэснээр ая тухтай орчинд студийн үйл ажиллагаагаа явуулах нөхцөл бүрдэж байна.





Төсөл хэрэгжүүлэгч “Хатан заяат говь” ХХК нь Өмнөговь аймгийн Даланзадгад суманд 2009 оноос эхлэн эмэгтэйчүүдийн бүх төрлийн үзлэг оношилгоо, эмчилгээнээс гадна шүдний гажиг заслын болон шүдний эмчилгээ үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлж байгаа ба 2014 оноос эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэй тусламж үйлчилгээг үзүүлэх болсон. Тус эмнэлэг нь одоогийн байдлаар хэвтэн эмчлүүлэх 15 ортой, эмэгтэйчүүдийн бүх төрлийн үзлэг оношилгоо, эмчилгээ хийдэг, нийт 10 хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд 4 их эмч, 5 сувилагч, 1 тусгай мэргэжилтэнтэйгээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэдэд хүргэж байна. Тус эмнэлэг нь цаашид өөрийн үйл ажиллагааг улам өргөжүүлэн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх үүднээс 50,000,000 төгрөгийн төслийн зээлд хамрагдан лабораторийн тоног төхөөмж, шээсний шинжилгээ, цусны ерөнхий болон дэлгэрэнгүй шинжилгээ, биохимийн шинжилгээнд ашиглах аппаратуудыг авч ашиглалтад оруулаад байна.

Төсөл хэрэгжүүлэгч харилцагч С.Шүрэнтуяа нь Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 3-р багт байрлах “Royal” төвийн 1 давхарт “Sondor fashion” оёдлын салонд монгол болон европ хувцасны захиалгат үйлдвэрлэл эрхэлж байна. Үйл ажиллагаагаа өргөжүүлэх зорилгоор 20,000,000 төгрөгийн төслийн зээлд хамрагдан шулуун оёдлын машин 2 ширхэг, 322D-241M-25 маркын 4 утастай хэрээсний машин 2 ширхэг, JR600-01CB маркын канза оёдлын машин болон бараа материал худалдан авч эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлсэн.





Төсөл хэрэгжүүлэгч Э.Цогбаяр нь Өмнөговь аймгийн Даланзадгад суманд 2012 оноос “Виктори” фитнес клубийг үүсгэн байгуулж ажиллаж байна. Иргэдэд орон нутгийн уламжлалт арга технолгиор хийдэг, ядаргаа тайлах, эрүүл мэндэд ач тустай “Говийн хийцтэй цай”-г үйлдвэрлэх зорилгоор 25,000,000 төгрөгийн төслийн зээлд хамрагдсан. Төслөөр тоног төхөөрөмж худалдан авсанаас гадна гялгар цаасаар бүрэгч, битүүмжлэн савлагч, шингэн савлагч, нунтаг савлах төхөөрөмж, мах хатаагч, ширхэгтэй бүтээгдэхүүн савлагч, огноо тавигч төхөөрөмж зэргийг худалдан авсан байна.

Төсөл хэрэгжүүлэгч “Дээрхийн адис” ХХК нь 2010 оноос хойш хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр өөрийн байрандаа үйл ажиллагаа явуулж байгаа. Тус компани нь 50,000,000 төгрөгийн төслийн зээлд хамрагдан үйлдвэрийн тоног төхөөрөмж шинэчилж, үйлдвэрийн байрныхаа дээврийг зассан. Одоогоор талх нарийн боов болон хэрчсэн гурил үйлдвэрлэж байна. Аймгийн хэмжээнд томоохон бүх супермаркетуудаар болон хүнсний дэлгүүрүүдээр бүтээгдэхүүнээ нийлүүлдэг. Мөн бууз банш хийж, бүтээгдэхүүнээ “Оюу толгой” компани туслан гүйцэтгэгч компанийн “Саппорт сервис монгол”-д нийлүүлж байгаа.



Дээрх төслийн зээлд хамрагдсан нийт харилцагчийн хувьд зээлээ зориулалтын дагуу үр дүнтэй ашиглаж, өрхийн орлогоо нэмэгдүүлж чадсан.

ХАДГАЛАМЖ


“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь Өмнөговь аймгийн хүүхэд залуучуудад зориулан жил бүрийн нийт санхүүжилтийн 2%-ийг 10 жилийн хугацаатай хадгаламжинд байршуулж байна. Уг хадгаламжийг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр нээж одоогийн байдлаар 949.2 сая төгрөг хуримтлуулаад байна.

ГОВИЙН ОЮУ-ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-аас Өмнөговь аймгийн ирээдүй хойч үеийн төлөө зориулан хэрэгжүүлдэг томоохон хөтөлбөрүүдийн нэг нь “Говийн оюу-Оюутны тэтгэлэг” хөтөлбөр юм. Уг хөтөлбөрийг 2019 онд 4 дэх жилдээ амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна.

- Өмнөговь аймгийн ЗДТГ-аас Өмнөговь аймагт хэрэгцээтэй байгаа мэргэжлийн чиглэлийг санд ирүүлсний дагуу аймгийн ЗДТГ-ын нийгмийн бодлогын хэлтэс, “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн төлөөлөл, “Говийн оюуны хөтөч” ТББ болон Өмнөговь аймагт боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудын төлөөллөөс бүрдсэн сонгон шалгаруулах хороо байгуулагдаж, 2019-2020 оны хичээлийн жилд тэтгэлэгт хамрагдах оюутнуудыг сонгон шалгаруулсан.
- “Говийн оюу-Оюутны тэтгэлэг” хөтөлбөрийн хүрээнд 2019 онд улсын болон магадлан итгэмжлэгдсэн сургуулиудад Өмнөговь аймагт дутагдалтай байгаа мэргэжлээр суралцаж байгаа 45 оюутанд тэтгэлэг олгосон.


Тэтгэлэг авсан оюутнуудыг сумдаар ангилсан байдал




“Говийн оюу-Оюутны тэтгэлэг” хөтөлбөрт 2016 онд 30, 2017 онд 57, 2018 онд 55, 2019 онд 45 оюутан тус тус хамруулсан бөгөөд 2016-2019 онд Өмнөговь аймгийн 187 оюутанд 465 сая төгрөгийн тэтгэлэг олгосон.

Жил бүр Өмнөговь аймагт шаардлагатай байгаа мэргэжлээр сурч буй оюутнуудад хөрөнгө оруулж байна.

2016-2019 онд олгосон тэтгэлэгийг мэргэжлээр ангилсан байдал, n=187



“Говийн Оюу-Оюутны тэтгэлэг” хөтөлбөрт хамрагдан төгссөн оюутнуудын ажлын байрны мэдээлэл



»» 2019 ОНД “ГОВИЙН ОЮУ-ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ” ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДСАН ОЮУТНУУД



Х.Батболд
СУИС-Медиа
Анимейшн



Г.Нандинболор
АШУУИС-Эмч



С.Аминцэцэг
ШУТИС-Цахилгааны
инженер



М.Туулайхүү
ХААИС-
Агрономич



Э.Жамцдорж
ШУТИС-
Архитектур



Э.Сүхбат
ХААИС-Барилгын
инженер



С.Чулуунцэцэг
ХААИС-Байгаль
хамгаалал



О.Уулсанаа
МУБИС-Нийгмийн
ажилтан



С.Мөнхтуяа
ШУТИС-Мэдээллийн
технологи



А.Буянравжих
Хүмүүнлэгийн УИС
Аялал жуулчлал



Д.Нандин-Эрдэнэ
МУИС-Программ
хангамж



М.Буянжаргал
ХААИС-Байгаль
орчны нөхөн
сэргээлт



Б.Насанбат
ХААИС-Барилгын
инженер



А.Алтантуяа
Хүмүүнлэгийн УИС-
Англи хэл Багш,
орчуулалгч



З.Ариунцэцэг
АШУУИС-Их эмч



А.Болороо
АШУУИС-Эх
барихуй



Х.Нарансолонго
АШУУИС- Эмч



М.Чанцаллахай
АШУУИС/Дорноговь-
Их эмч



Т.Мишээл
АШУУИС-Эмч



Э.Бүүвэй
ХАИС-Архитектур



Э.Номин-Эрдэнэ
МУБИС-Нийгмийн
ухааны багш



О.Эрдэнэцэг
МУИС-Програм
хангамж



Г.Баярмаа
ШУТИС-Цахилгааны
инженер



Э.Сугармаа
ШУТИС-Цахилгааны
инженер



Г.Дашчирэв
МУБИС-
Технологийн багш



С.Цэнд-Аюуш
ШУТИС-
Архитектур



Л.Мөнхбилгүн
ШУТИС-Уул
урхайн ашиглалт



О.Ариунзаяа
ХААИС-Аялал
жуулчлал



Ц.Батлхава
ШУТИС/Коосэн ТДС/
Механикийн инженер



Б.Тайванжаргал
ХААИС-Малын
эмч



Ц.Маам
МУБИС-Химийн
эмч



Б.Мөнхтүвшин
ШУТИС-Агаар
сэлгэлтийн инженер



Х.Жаргалмаа
МУБИС-Монгол хэл,
уран зохиолын багш



Б.Шүрэнцэгэ
АШУУИС-
Шүдний эмч



Б.Будсүрэн
Монгол анагаах ухааны
ОУС-Уламжлалтын эмч



Э.Мөнгөншагай
Сити их сургууль-
Анимейшн



У.Цэдэн-Иш
Эм зүйн шинжлэх
ухааны ИС-
Уламжлалтын Эмч



С.Удвал
Монгол анагаах
ухааны ОУС-
Уламжлалтын эмч



О.Сарнайцэгэ
АШУУИС-
Шүдний эмч



Б.Жавзандулам
ХААИС-Байгаль
орчныг хамгаалах
технологи



Э.Уранцэгэ
ХААИС-Аялал
жуулчлалын



Э.Саранцэгэ
ХААИС-Байгаль
орчныг хамгаалах
технологи



Х.Гүррагчаа
ШУТИС-Програм
хангамж, Системийн
аюулгүй байдал



И.Буянбадрах
ХААИС-Механикийн
инженер




Р.Мөнхбат
ХААИС-Байгаль
хамгаалал

УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС САНХҮҮЖҮҮЛЭХЭЭР БАТАЛСАН САНАЛУУД

2018-2021 оны 3 жилийн стратегийнхаа дагуу “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” нь 19 төсөл хөтөлбөр санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд санхүүжилтийн квотын хүрээнд зорилтот сумд болох Түншлэгч болон уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулахгүй байгаа сумд болох Ханбогд, Манлай, Баян-Овоо, Даланзадгад, Сэврэй, Баяндалай, Мандал-Овоо, Цогт-Овоо, Булган, Номгон сумдуудад 47 төсөл хөтөлбөр хэрэгжээд байна.


Говийн Оюу хөгжлийн дэмжих сангийн 2019 онд санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийг чиглэлээр нь дараах байдлаар харуулж байна.

2019 онд ХДС-д хүлээн авсан саналыг Хамтын Ажиллагааны гэрээний сэдэвчилсэн хавсралтаар ангилсан байдал



“Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн 2019 онд санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийн сумдад хуваарилсан хуваарилалтыг дараах байдлаар харуулж байна.

ХДС-ийн 2019 онд батлагдсан төсөл хөтөлбөрийн санхүүжилтийн хуваарилалт (сумд) (төгрөгөөр харуулав)



»» НҮБ-ЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУДАД ХДС-ИЙН ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО




ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ЗОРИЛТ 3

ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ЗОРИЛТ 4

ЖЕНДЕРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ЗОРИЛТ 5

БАТАЛГААТ УНДНЫ УС АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖААР ХАНГАХ ЗОРИЛТ 6

ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР БА ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ ЗОРИЛТ 8



- Чадавхжуулах сургалт,
- Тоног төхөөрөмж нийлүүлэх хөтөлбөр

- Сургууль цэцэрлэгийн тоног төхөөрөмж
- Сургалт

- Сургалт, нөлөөллийн ажил
- Хамтарсан хөтөлбөр

- Гашуунсухайт боомтын ус цэвэршүүлэх байгууламж
- Сумдад худаг гаргах ажил

- Бизнес хөгжлийг дэмжих төсөл
- Хөдөлмөр эрхлэхэд шаардалагатай тоног төхөөрөмж нийлүүлэлт

**ИННОВАЦИ БОЛОН
ДЭД БҮТЦИЙГ
ХӨГЖҮҮЛЭХ
ЗОРИЛТ 9**

**ЭЭЛТЭЙ ХОТ,
ИРГЭДИЙН
ОРОЛЦООГ ДЭМЖИХ
ЗОРИЛТ 11**

**УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН
НӨЛӨӨГ БАГАСГАХ
ЗОРИЛТ 15**

**ЭНХ ТАЙВАН,
ШУДАРГА ЁСЫГ
ЦОГЦЛООХ
ЗОРИЛТ 16**

**ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ
ТҮНШЛЭЛИЙГ БИЙ
БОЛГОХ
ЗОРИЛТ 17**



- Эмнэлэг, сургууль, цэцэрлэг, музей, спорт заалны барилга

- Сургалт, нөлөөллийн ажил


- Сумдад мод тарих

- Хүний наймааны хохирогч, шилжин суурьшигчдын эрхийг хамгаалах хөтөлбөр хэрэгжүүлсэн

- 45.8 тэрбум ₮ буюу 19.3 сая \$-ийн төсөл санхүүжүүлж 200 гаруй түнштэй болсон

»» ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САНГИЙН САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН МЭДЭЭ

ХДС-ийн 2015-2019 онд сумдад оруулсан хөрөнгө оруулалт



ХДС-ийн 2015-2019 онд сумдад оруулсан хөрөнгө оруулалт

Сумдын нэр	Хөрөнгө оруулалт	
	(Тэрбум төгрөгөөр) ₮	(Сая доллараар) \$
Ханбогд	12.5	5.3
Манлай	3.1	1.2
Баян-Овоо	2.4	1.0
Даланзадгад	16.5	7.1
Цогт-Овоо	0.15	0.06
Сэврэй	0.16	0.06
Номгон	0.15	0.06
Булган	0.15	0.06
Мандал-Овоо	1.4	0.5
Баяндалай	0.15	0.06
Бүх сумдыг хамарсан	7.6	3.1
Түншлэгч сумдыг хамарсан	0.43	0.21
Түншлэгч биш сумдыг хамарсан	1.5	0.61

№	Хамтын ажиллагааны гэрээний Сэдэвчилсэн хавсралт	Төслийн тоо 2015-2019	Төсөв	
			₮ (Тэрбум төгрөгөөр)	\$ (Сая доллараар)
1	Нийгмийн дэд бүтэц	33	30.5	13.3
2	Нийгмийн суурь үйлчилгээ	83	6	2.5
3	Байгаль орчин	11	2.9	1.2
4	Үндэсний түүх соёл, аялал жуулчлал	21	1.6	0.70
5	Усны менежмент	10	1.1	0.41
6	Уламжлалт мал аж ахуй	11	2.1	0.88
7	Бизнес хөгжил	11	1.9	0.76
	Нийт	180	46.1	19.7



ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН”-ИЙН
САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСӨЛ
ХӨТӨЛБӨР

46.1 ТЭРБУМ ₮
19.7 САЯ \$

СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГ /
СУРГАЛТЫН ОРЧИН

35 ТӨСӨЛ - 16.2 ТЭРБУМ ₮

- Ханбогд сумын 2-р сургууль 29-р цэцэрлэгийн цогцолборын барилга
- Даланзадгад сумын 25, 26, 11, Манлай сумын 15-р цэцэрлэгийн барилга
- Сумдын сургуулиудын мэдээлэл технологи, дизайн технологийн кабинетийн тохижилт

ЭМНЭЛЭГ / ЭРҮҮЛ МЭНД

19 ТӨСӨЛ - 6 ТЭРБУМ ₮

- Баян-Овоо сумын эрүүл мэндийн төвийн барилга
- Мандал-Овоо сумын эрүүл мэндийн төвийн барилга
- Өмнөговь аймгийн эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр /2018-2021/,
- Бүсийн Оношилгоо Эмчилгээний Төвийн шүдний кабинет
- Бүсийн Оношилгоо Эмчилгээний Төвийн эмнэлгийн лифт

УУРЫН ЗУУХ

4 ТӨСӨЛ - 2.3 ТЭРБУМ ₮

- Баян-Овоо, Ханбогд, Манлай сумдын уурын зуухны барилга, зуух
- Баяндалай сумын уурын зууханд нэмэлт зуух суурилуулах ажил

МОД ТАРИХ ТӨСӨЛ

5 ТӨСӨЛ - 233.4 САЯ ₮

- Ханбогд, Манлай, Сэврэй сумдын мод үржүүлгийн газар байгуулах төсөл
- Мандал-Овоо, Сэврэй сумдын мод усралтын систем суурилуулалтын ажил

МУЗЕЙН БАРИЛГА
/ ТОХИЖИЛТ

5 ТӨСӨЛ - 6.2 ТЭРБУМ ₮

- Өмнөговь аймгийн музейн барилга,
- Манлай, Сэврэй, Цогт-Овоо, Баян-Овоо сумдын музейн тохижилт

УСНЫ МЕНЕЖМЕНТ

6 ТӨСӨЛ - 943.2 САЯ ₮

- Гашуунсухайт боомтын ус цэвэршүүлэх байгууламж,
- Бэлчээр усжуулах Чандмань эрдэнэ
- Бугын худаг
- Нутгийн иргэдэд тулгуурласан усны чанарын хяналт, үнэлгээ

НИЙТИЙН ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

31 ТӨСӨЛ - 4.5 ТЭРБУМ ₮

- Ханбогд сумын үерийн далан, суваг,
- Даланзадгадын Нийтийн тээврийн үйлчилгээ,
- Мандал-Овоо, Цогт-Овоо сумдын ухаалаг худаг,
- Даланзадгад сумын гэрлэн дохио

ИРГЭДЭД НИЙТЭД ЧИГЛЭСЭН СУРГАЛТ / СУДАЛГАА

20 ТӨСӨЛ - 873.9 САЯ ₮

- Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны суурь судалгаа
- Өрхийн санхүү-Улсын санхүү,
- Бизнес хөтөч

БИЗНЕС / ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

15 ТӨСӨЛ - 3.7 ТЭРБУМ ₮

- Өмнөговь аймгийн жижиг дунд бизнесийн дэмжих хөтөлбөр,
- Оюу хүлэмж 1, 2
- Сэврэй, Ханбогд сумдад гар урлалын төв
- Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр

МАА / БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ

15 ТӨСӨЛ - 3.6 ТЭРБУМ ₮

- Бэлчээрийн менежмент сайжруулах Бэлчээр эрдэнэ,
- Нутгийн шилмэл сүрэг бүрдүүлэх Шилмэл сүрэг,
- Ариутгал- 2016
- Мал угаалга, хашаа хороо халдваргүйжүүлэлт-2019 хөтөлбөр

ТҮҮХ СОЁЛ / АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

25 ТӨСӨЛ-1.3 ТЭРБУМ ₮

- Шар цав, Хүрдэт агуйн соёлын өвийг хамгаалах
- Ботгон тэшээ бүжгийн баг, хувцас
- Цамын хувцас
- Өв соёл
- Монгол ардын дуу
- Жинчид ирлээ



ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ИЙН
САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРӨӨС ГАРСАН ҮР ДҮН

46.1 ТЭРБУМ ₮/19.7 САЯ \$



ХАРИЛЦАГЧ
БАЙГУУЛЛАГА

+300



ҮР ШИМ
ХҮРТЭГЧ

+480,000



ШИНЭ АЖЛЫН
БАЙР

394



БИЗНЕСИЙН
ХӨНГӨЛӨЛТТЭЙ

44



22 ТӨСЛИЙН
ХАМТАРСАН
САНХҮҮЖИЛТ

20.8
ТЭРБУМ ₮



ТЭТГЭЛЭГТ
ОЮУТАН

187



САНХҮҮЖИЛТИЙН
КВОТ

1.9
ТЭРБУМ ₮



ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ

54.1
ТЭРБУМ ₮

НИЙГМИЙН ДЭД БҮТЦИЙН 4 БАРИЛГА АШИГЛАЛТАНД ОРУУЛАВ

- Өмнөговь аймгийн махны үйлдвэр, Баян-Овоо сумын уурын зуух, Мандал-Овоо сумын эмнэлэг, Манлай сумын цэцэрлэг



2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД

- Хөндлөнгийн Аудит хийлгэв. 2019.05

САНХҮҮЖИЛТИЙН КВОТООР 47 ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖСЭН

- 2019.04-12 сар- Санхүүжилтийн квот байгуулсан сумдад тогтвортой хөгжлийн хөтөлбөрүүд хэрэгжсэн



ЗОРИЛТОТ СУМДАД САНХҮҮЖИЛТИЙН КВОТ ОЛГОЖ ЭХЛЭВ

- 2019.03-04 сар- Ханбогд, Баян-Овоо, Манлай, Даланзадгад, Сэврэй, Баяндалай, Номгон, Булган, Цогт-Овоо, Мандал-Овоо сумдын засаг дарга нартай санхүүжилтийн квотын гэрээ байгуулав



ГОВИЙН ОЮУ-ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ

- 2019.09 45 оюутан тэтгэлэгт хамрагдаж өссөн дүнгээр 187 оюутанд тэтгэлэг олгосон



3 ЖИЛ ҮРГЭЛЖЛЭХ ХӨТӨЛБӨР

- Мал угаалга, хашаа хорооны ариутгал, халдваргүйжүүлэлт-2019 хөтөлбөр-116.3%-ийн биелэлттэй хэрэгжсэн
- 2020 он - Өм.ЗДТГ санхүүжүүлнэ
- 2021 он - Өм.Малчид санхүүжүүлнэ



ХАРИЛЦААНЫ ХОРОО ХУРАЛ

- 2019.01.09
- 2019.06.19
- 2019.11.28



УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ

- 2019.01.24
- 2019.06.26
- 2019.12.11



ХДС-ИЙН 2018 ОНЫ ТАЙЛАНГ ХЭВЛҮҮЛЖ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАВ

- 2019.02 8000 хувь хэвлүүлж олон нийтэд түгээв



САНГИЙН 2019 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

»» САНГИЙН 2019 ОНЫ САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ ХУВААРИЛСАН ХУВААРИЛАЛТ

№	Төсөл, хөтөлбөрийн нэр	Санхүүжилт (₮)	Санхүүжилт (\$)
Нийгмийн дэд бүтэц			
1	Өмнөговь аймийн музей	2,295,000,000	871,788.25
2	Манлай сумын цэцэрлэгийн барилга	1,553,731,260	590,206.82
3	Ханбогд сумын үерийн далан	1,257,711,282	477,759.44
4	Баян-Овоо сумын уурын зуух	901,836,561	342,575.39
5	Ханбогд сумын өвс тэжээлийн агуулах	370,125,833	140,597.54
6	Өмнөговь аймгийн музейн сан хөмрөгийн өрөөний тоног төхөөрөмж, гадна шугам сүлжээ	342,520,000	130,111.07
7	Манлай сумын цэцэрлэгийн тоног төхөөрөмж	165,056,900	62,699.20
8	Ханбогд сумын цахилгаан шугамын өргөтгөл	50,000,000	18,993.21
Дэд дүн (А)		6,935,981,836	2,634,730.92
Нийгмийн суурь үйлчилгээ			
1	Өмнөговь аймгийн эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих хамтарсан хөтөлбөр	1,151,553,802	437,434.02
2	Ханбогод сумын сургууль цэцэрлэгийн цогцолборын менежмент	160,454,620	60,950.96
Дэд дүн (Б)		1,312,008,422	498,384.98
Усны менежмент			
1	Чандмань эрдэнэ	179,920,877	68,345.49
2	Бугын худаг	20,000,000	7,597.28
Дэд дүн (В)		199,920,877	75,942.77
Уламжлалт мал аж ахуй, бэлчээрийн менежмент			
1	Мал угаалга хашаа хорооны ариутгал халдваргүйжүүлэлт-2019	814,918,579	309,558.36
Дэд дүн (Г)		814,918,579	309,558.36
Үндэсний түүх соёл аялал жуулчлал			
1	Ботгон тэшээ бүжгийн хувцас	4,500,000	1,709.39
2	Батмөнх Даян хааныг алдаршуулах	11,440,000	4,345.65
3	Цамын багийн хувцас	30,000,000	11,395.92
4	Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын баримтат хөрөг нэвтрүүлэг	20,000,000	7,597.28
Дэд дүн (Д)		65,940,000	25,048.24

Орон нутгийн бизнес хөгжил			
1	Өмнөговь аймгийн жижиг дунд бизнесийг хөгжүүлэх хөтөлбөр	1,034,309,750	392,897.20
2	Оюу хүлэмж-2	290,775,305	110,455.12
Дэд дүн (Е)		1,325,085,055	503,352.32

Санхүүжилтийн квотоор хэрэгжсэн төслүүд

Ханбогд сум

2019 онд хуваарилсан санхүүжилтийн квот (Ё)	179,819,500	70,000
2018 оноос шилжиж орж ирсэн санхүүжилтийн квот	494,146	203.04
Галбын өгөөж	20,000,000	7,597.28
Монгол ардын дуу	16,730,000	6,355.13
Өнө мөнхөд өөдлөн дэвжих өв соёл минь	30,081,500	11,426.88
Өв соёл	21,770,000	8,269.64
Тог баригч	34,900,000	13,257.26
Эрүүл насжилт	26,157,365	9,936.25
Задгай театр	20,000,000	7,597.28
Эрсдэлийн сан	8,990,975	3694.4

Баян-Овоо сум

2019 онд хуваарилсан санхүүжилтийн квот (Ж)	121,683,500	50,000
2018 оноос шилжиж орж ирсэн санхүүжилтийн квот	26,362,825	10,833
Цэвэр усны үйлдвэр	35,000,000	13,295.25
Гамшиг ослын үеийн бэлэн байдал	16,980,000	6,450.09
Говийн өв	30,000,000	11,395.92
Шинэ сонголт	31,630,000	12,015.10
Өв эрдэнэ	15,000,000	5,697.96
Цэцэрлэгийн тоглоом	6,000,000	2,279.18
Эрсдэлийн сан		

Манлай сум

2019 онд хуваарилсан санхүүжилтийн квот (З)	121,683,500	50,000
2018 оноос шилжиж орж ирсэн санхүүжилтийн квот	339,165	139
Сургалтын танхимын фитнес тоног төхөөрөмж	60,365,000	22,930.50
Жинчид ирлээ	10,900,000	4,140.52
Эрүүл хүүхэд-2	9,564,000	3,633.02
Дотуур байр, тохилог орчин	15,935,000	6,053.14
Хөргүүртэй автомашин нийлүүлэх	19,000,000	7,217.42
Эрсдэлийн сан		

Даланзадгад сум		
2019 онд хуваарилсан санхүүжилтийн квот (И)	121,683,500	50,000
2018 оноос шилжиж орж ирсэн санхүүжилтийн квот	68,383,500	28,099
Өрхийн санхүү-Улсын санхүү	6,685,500	2,539.58
Бүгдэд ээлтэй төрийн үйлчилгээ	40,000,000	15,194.57
Смарт ДЗ	28,000,000	10,636.20
Гэрлэн дохио	70,000,000	26,590.49
Хог ачигч	24,900,000	9,458.62
Цахим номын сан	5,380,000	2,043.67
Эрсдэлийн сан		
Баяндалай сум		
2019 онд хуваарилсан санхүүжилтийн квот (Й)	73,010,100	30,000
2018 оноос шилжиж орж ирсэн санхүүжилтийн квот		
Хүүхдийн тоглоомын талбай, сагсны талбай	23,442,905	8,905.12
Гэрэлтүүлгийн ажил	52,997,078	20,131.69
Эрсдэлийн сан		
Сэврэй сум		
2019 онд хуваарилсан санхүүжилтийн квот (К)	73,010,100	30,000
2018 оноос шилжиж орж ирсэн санхүүжилтийн квот	8,600	3.5
Автомашин нийлүүлэх	34,950,000	13,276.25
Гар урлалын төв	7,773,000	2,952.68
Аялал жуулчлал, мэдээллийн төвийн тохижилт	34,045,000	12,932.48
Эрсдэлийн сан		
Мандал-Овоо сум		
2019 онд хуваарилсан санхүүжилтийн квот (Л)	73,010,100	30,000
2018 оноос шилжиж орж ирсэн санхүүжилтийн квот		
Ясли-хүүхэд хөгжил	9,980,000	3,791.04
Аюулгүй орчин-хүүхдийн ирээдүй	25,042,600	9,512.79
Ухаалаг худаг	20,901,480	7,939.72
Хогийн цэг	9,845,000	3,739.76
Баян төгөл	6,972,000	2,648.41
Эрсдэлийн сан	3,850,000	1,581.9
Цогт-Овоо сум		
2019 онд хуваарилсан санхүүжилтийн квот (М)	73,010,100	30,000
2018 оноос шилжиж орж ирсэн санхүүжилтийн квот	1,815,510	745.9
Хяналтын камер	5,500,000	2,089.25
Шуурхай мэдээлэл	5,180,000	1,967.70
Замын тэмдэгжүүлэлт	9,584,000	3,640.62
Музей	18,879,800	7,171.76

Зөөврийн эрчим хүч	9,973,800	3,788.69
Эко ордон-бүтээлч ирээдүй	9,810,545	3,726.67
Эрсдэлийн сан		
Номгон сум		
2019 онд хуваарилсан санхүүжилтийн квот (Н)	73,010,100	30,000
2018 оноос шилжиж орж ирсэн санхүүжилтийн квот	17,600	7.2
Хөвгүүдийн кабинетийн тохижилт	15,000,000	5,697.96
ЭМТ-ийн тоног төхөөрөмж	12,500,000	4,748.30
Төхөм багийн худгийн тохижилт	10,000,000	3,798.64
Номгон сумын төвийн гэрэлтүүлэг	30,000,000	11,395.92
Эрсдэлийн сан		
Булган сум		
2019 онд хуваарилсан санхүүжилтийн квот (О)	73,010,100	30,000
2018 оноос шилжиж орж ирсэн санхүүжилтийн квот	5,299,361	2177.5
Соёлын төвийн урлагийн хувцас	11,700,000	4,444.41
Тохилог орчин	33,891,966	12,874.34
Жишиг гудамж	27,508,450	10,449.47
Эрсдэлийн сан		
Бусад		
Хандив тусламж	256,885,000	100,000.00
Ирээдүй хойч үеийн төлөө сан	642,212,500	250,000.00
ХДС-ийн үйл ажиллагааны зардал	529,903,986	201,291.53
Дэд дүн (Ө)	1,429,001,486	551,291.53
НИЙТ ДҮН (А+Б+В+Г+.....+Ө)	13,065,786,855	4,998,309
2019 ОНООС 2020 ОНЫ САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРТ ШИЛЖҮҮЛСЭН ДҮН	4,329,890.05	1691
2019 ОНД ХҮЛЭЭН АВСАН ЭХ ҮҮСВЭР	13,070,116,745	5,000,000

»» САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС 2019 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХЭЭР БАТАЛСАН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД

2019 ОНД САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН НИЙГМИЙН ДЭД БҮТЦИЙН ТӨСӨЛ:

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН МУЗЕЙН БАРИЛГА БАРИХ ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ
БАРИЛГЫН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭГЧ:	“АГЛУТ” ХХК
ГАДНА ШУГАМЫН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭГЧ:	“ДҮЖИЙ ХАЙРХАН” ХХК
САН ХӨМРӨГИЙН ӨРӨӨНИЙ ТОХИЖИЛТЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧ:	“ТАНГАД АРАА” ХХК
БАТЛАГДСАН ТӨСӨВ:	Нийт батлагдсан дүн: 9,773,713,692 төгрөг 2018 онд батлагдсан /барилга/: 6,940,985,194 төгрөг 2019-2020 онд батлагдсан /барилга, гадна шугам сүлжээ, тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл/: 3,978,713,692 төгрөг
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	Барилга угсралтын ажил: 5,795,000,000 төгрөг Гадна шугам сүлжээний ажил: 215,344,809 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Өмнөговь аймаг нь Монгол улсын өмнөд хэсэгт байрлах үзэсгэлэнт байгальтай, говь нутгийн байгаль цаг агаарт зохицсон уламжлалт нүүдлийн соёл иргэншил, түүх соёлын арвин уламжлалтай нутаг юм. Байгалийн өвөрмөц тогтоц нь, үзэсгэлэнт газрыг түшиглэсэн аялал жуулчлал нь аймгийн эдийн засгийн тулгуур салбарын нэг юм. Монгол улсад ирж буй жуулчдын 80 гаруй хувь нь говь нутгийг үзэж сонирхохоор ирдэг. Эдгээр жуулчдад нутаг орны соёлын өв, говь нутгийн нэрийн хуудас болсон үлэг гүрвэлийн олдвор зэрэг палеонтологийн ховор нандин үзмэрүүдийг үзүүлэхэд аймгийн музейн одоогийн барилгын хүчин чадал хаана нь ч хүрдэггүй. Учир нь музейн барилга нь 1954 онд чулуугаар барьсан аймгийн анхны зочид буудал, 1969 онд аж ахуйн аргаар хоёр давхар болгосон барилга юм. Барилгад суулт өгч, хана цуурсан зэрэг эвдрэл гэмтэл нь музейн үйл ажиллагаанд тавигдах MNS 5634:2006 стандартын шаардлага хангахгүй, үзмэрүүдийн хадгалалт хамгаалалтад сөргөөр нөлөөлж байна.

Энэ нөхцөл байдлын улмаас барилгын болон галын улсын байцаагчийн дөрвөн удаагийн дүгнэлтээр үйл ажиллагааг зогсоох шаардлага тавигдаад байгаа. Иймд уг барилгыг музейн зориулалтаар цаашид ашиглах боломжгүй болсон.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Энэхүү төслийн гол зорилго нь Стандартын шаардлага хангасан, барилга архитекторын өвөрмөц шийдэл бүхий музейн барилгыг барьж ашиглалтад оруулах юм. Ингэснээр Монголын говь нутгийн соёлын өвийг хадгалж хамгаалах, хойч үедээ өвлүүлэн уламжлуулах, оюуны хөрөнгө оруулалт, танин мэдэхүйн боловсрол олгох, гадаад дотоодын аялагч жуулчдад Монголын говь нутгийг сурталчилан таниулах баян үзмэртэй жишиг музей болж улмаар аймгийн эдийн засагт хувь нэмэр оруулах ач холбогдолтой.

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 3 дугаар сарын 15- ны өдрийн 06 дугаар тогтоолоор Өмнөговь аймгийн Музейн барилга төслийг санхүүжүүлэхээр дэмжиж санхүүжилтийг батлав
- Захиалагч аймгийн ЗДТГ гүйцэтгэгчийн сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Аглут” ХХК-тай санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” гэрээ байгуулснаар барилга угсралтын ажлыг эхлүүлэв.
- Барилга угсралтын ажил 2019 оны эцсийн байдлаар 80 хувьд хүрэв.
- 2020 оны 2-р улиралд барилгын ажил болон Музейн шаардлагатай тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл нийлүүлэх ажил бүрэн дуусч ашиглалтанд хүлээлгэн өгнө.
- 2018 онд орон нутгийн зах зээлээс 246 сая төгрөгийн бараа бүтээгдэхүүн худалдан авч, 58 түр болон байнгын ажлын байр бий болсон
- 2019 онд орон нутгийн зах зээлээс 455 сая төгрөгийн бараа бүтээгдэхүүн худалдан авч, 123 түр болон байнгын ажлын байр бий болсон
- 2019 онд Өмнөговь аймгийн музейн сан хөмрөгийн өрөөний тоног төхөөрөмж,

гадна шугам сүлжээнд зориулж 342,520,000 төгрөгийн санхүүжилтийг баталсан бөгөөд 2020 онд ашиглалтанд оруулахаар ажиллаж байна.

»» ҮР ДҮН:

- Монголын говь нутгийн соёлын өвийг хадгалж хамгаалах, хойч үедээ өвлүүлэн уламжлуулах, оюуны хөрөнгө оруулалт, танин мэдэхүйн боловсрол олгоход музей чухал үүрэг гүйцэтгэнэ
- Гадаад дотоодын аялагч жуулчдад Монголын говь нутгийг сурталчилан таниулах баян үзмэртэй жишиг музей болж улмаар аймгийн эдийн засагт хувь нэмэр оруулна.

МАНЛАЙ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГА, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ: БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ:	“ВЕНТАНА КОНСТРАКШИН” ХХК
ЦЭЦЭРЛЭГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ:	“ЭЛБЭГ ТУУЛАЙ” ХХК
БАТЛАГДСАН ТӨСӨВ:	Барилгын ажилд: 1,800,000,000 төгрөг Цэцэрлэгийн тоног төхөөрөмж: 178,249,400 төгрөг
ГЭРЭЭНИЙ ДҮН:	Барилга угсралтын ажил: 1,553,731,260 төгрөг Цэцэрлэгийн тоног төхөөрөмж: 165,056,900 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Манлай сумын 15-р цэцэрлэг нь 2013 онд ашиглалтанд орсон 100 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн барилгатай. 2018-2019 оны хичээлийн жилд 8 багш, 6 ажилтантайгаар 130 хүүхэд хамруулан ажилласан байна. Гэвч энэ нь цэцэрлэгийн барилгын хүчин чадлаас хамаарч тойргийн хэмжээнд байгаа 267 хүүхдийн 50% ийг л цэцэрлэгт хамруулсан тоон үзүүлэлт юм.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Манлай сумын цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдүүд цэцэрлэгт хамрагдаж сургуулийн өмнөх боловсрол эзэмших бололцоотой болно. Мөн тооны эцэг эх, асран хамгаалагч нар үр хүүхэддээ санаа зовох зүйлгүй ажил эрхэлж орлого олж ахуй амьдралаа дээшлүүлэх бололцоо бүрдэнэ.

»» ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

- Манлай сумын 15-р цэцэрлэгийн барилгатай өргөтгөл байдлаар хүзүүвчээр холбогдох 100 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн 2 давхар барилгыг батлагдсан зураг төсвийн дагуу барьж улсын комисст хүлээлгэн өгч ашиглалтанд оруулах.
- Манлай сумын 100 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай 15 дугаар шинэ цэцэрлэгт 153 нэр төрлийн 2054 ширхэг тоног төхөөрөмж, тавилга, хэрэгсэл нийлүүлнэ.

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2019 оны 02-р тогтоолоор Манлай сумын 15-р цэцэрлэгийн дэргэдэх 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга барих төслийг санхүүжүүлэхээр батлав.
- Говийн оюу хөгжлийг дэмжих сан нь захиалагч аймгийн ЗДТГ болон захиалагчийн шалгаруулсан барилгын гүйцэтгэгч “Вентана констракшин” компанитай санхүүжилтийн гэрээ байгуулснаар барилга угсралтын ажил эхлүүлэв.
- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2019 оны 07-р тогтоолоор “Манлай сумын цэцэрлэгийн тоног төхөөрөмж” хөтөлбөрийг санхүүжүүлэхээр батлав.
- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь захиалагч аймгийн ЗДТГ болон захиалагчийн шалгаруулсан тоног төхөөрөмж нийлүүлэх гүйцэтгэгч “Элбэг туулай” компанитай санхүүжилтийн гэрээ байгуулснаар тоног төхөөрөмж нийлүүлэх хөтөлбөрийн ажил эхлүүлэв.
- 2019 оны 12 сарын 19 ны өдөр шинэхэн цэцэрлэгийн нээлтийн ёслолын үйл ажиллагаа болж Өмнөговь аймгийн ИТХ-ын дарга Х.Сугир, “Оюутолгой” ХХК-ийн үйл ажиллагаа хариуцсан захирал бөгөөд “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн дарга Тим Экерсли, Орон нутгийн харилцааны Ерөнхий менежер Г.Сугар, Манлай сумын удирдлагууд, тус цэцэрлэгийн багш сурган хүмүүжүүлэгчид, эцэг эхчүүд оролцож цэцэрлэгийн авьяаслаг бяцхан багачууд ая дууныхаа дээжээр шинэхэн цэцэрлэгээ мялаав.

»» ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Зориулалтын хоолны болон урлаг, биеийн тамирын заалтай стандарт хангасан байранд сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа явуулах хэвийн нөхцөл бүрдүүлсэн
- Сургалтын өмнөх боловсрол олгох үйлчилгээ явуулахад шаардлагатай тавилга, тоног төхөөрөмжөөр иж бүрэн хангагдаж хүүхдүүдэд ая тухтай орчинд сурч боловсрох боломжтой болсон
- Хамран сургах тойргийн хүүхдүүд сургуулийн өмнөх боловсрол эзэмших нөхцөл бүрдсэн
- Шинээр арав гаруй ажлын байр бий болсон.
- Өмнөговь аймгийн Манлай сумын 130 гаруй хүүхэд цэцэрлэгт хамрагдаж, эцэг эхчүүд хүүхдэдээ санаа зовохгүйгээр ажил хөдөлмөр эрхлэх, ахуй амьдралаа дээшлүүлэх боломж бүрдэв.

ХАНБОГД СУМЫН ҮЕРИЙН ДАЛАН, СУВАГ БАРИХ ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	“АРЦ СУВАРГА” ХХК
БАТЛАГДСАН ТӨСӨВ:	1,354,397,747 төгрөг
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	1,257,711,282 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Ханбогд сумын төвийн газарзүйн байршил нь нам дор ба сумын төвийн баруун болон урд уулнаас үерийн ус их буудаг. 2015 онд дуу цахилгаантай аадар бороо 30 минут орох төдийд сумын төв бүхэлдээ усанд автаж төрийн болон иргэдийн өмч хөрөнгө ихээр эвдэрч сүйдсэн, айлуудын бохир хальж иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах нөхцөлд сөргөөр нөлөөлсөн зэрэг аюул тохиож байсан юм.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Энэхүү төслийн гол зорилго нь сум, орон нутгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчинд ээлтэй, байгалийн унаган тогтоцыг хөндөхгүй, стандартын шаардлага хангасан үерийн далан, суваг байгуулж, байгалийн гэнэтийн, давагдашгүй хүчин зүйл болох үер усны гамшгаас ард иргэдээ хамгаалах, сумын төвийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-ийн 2019 оны 1 дүгээр сарын 24- ний өдрийн 02 дугаар тогтоолоор Өмнөговь аймгийн Ханбогд суманд үерийн далан, суваг барих төслийг санхүүжүүлэхээр дэмжиж төслийн санхүүжилтийг батлав
- Захиалагч аймгийн ЗДТГ гүйцэтгэгчийн сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Арц суварга” ХХК-тай санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” гэрээ байгуулснаар барилга угсралтын ажлыг эхлүүлэв.

- Барилга угсралтын ажил 2019 оны эцсийн байдлаар 80 хувьд хүрэв.
- 2020 оны 2-р улиралд барилгын ажил бүрэн дуусч ашиглалтанд хүлээлгэн өгнө.

»» ҮР ДҮН:

- Сумын төвд оршин суудаг 5500 орчим иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөл бүрдэнэ.
- Байгалийн гэнэтийн, давагдашгүй хүчин зүйл болох үер усны аюулаас иргэдийн амьдрах орчин, амь нас, өмч хөрөнгийг хамгаална.
- Төслийн хугацаанд орон нутагт 10-25 ажлын байр бий болно.

“БАЯН-ОВОО СУМЫН УУРЫН ЗУУХ” ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	“ШҮТЭЭН-ЭРДЭНЭ” ХХК
БАТЛАГДСАН ТӨСӨВ:	1,000,000,000 төгрөг
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	901,836,561 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Баян-Овоо сумын төвд 600 гаруй иргэд оршин суудаг. Сүүлийн жилүүдэд эмнэлэг, спорт заал, соёлын төв, нутгийн удирдлагын ордон зэрэг томоохон барилгууд шинээр баригдсан бөгөөд 2018 онд сумын төвийн дулааны шугамыг бүрэн шинэчилж гол шугамын диаметрийг ф108мм байсныг ф273мм, ф219мм болгож томсгосон зэргээс шалтгаалж уурын зуухны хүчин чадал сумын төвийн одоо байгаа барилгуудаа дулааны эх үүсвэрээр хангахад хүрэлцээгүй болсон. Үүний улмаас хүйтний улиралд сумын төвлөрсөн дулааны шугаманд холбогдсон барилга байгууламжийн дотор шугам сүлжээ хөлдөх өндөр эрсдэлтэй байсан. Мөн одоогийн байдлаар төвлөрсөн дулаанд холбогдох боломжтой 50 гаруй айл хэрэглэгчтэй. Дээрх шалтгааны улмаас тус сумын уурын зуухыг шинэчилж хүчин чадал сайтай зуухыг холбогдох барилга байгууламжийн хамт барих төслийн саналыг аймгийн ЗДТГ-аас санаачилсан

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Баян-Овоо суманд дээрх нөхцөл байдлын улмаас үүссэн халаалтын доголдлыг залруулах, байгууллага, айл өрхийг нэгдсэн дулаан хангамжаар хангах, иргэд сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг нийтийн үйлчилгээг ая тухтай дулаан орчинд авах нөхцөлийг бүрдүүлэх, шинэ техник технологи нэвтрүүлэх, агаарын бохирдол бууруулах, байгаль орчин, хүний хөдөлмөрлөх нөхцөлд ээлтэй орчин бүрдүүлэх зорилготой төсөл юм.

»» ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

ОХУ-д үйлдвэрлэсэн хагас автомат уурын зуух, нүүрсний автомат конвер бүхий 2 зуухтай, батлагдсан зураг төслийн дагуу барих барилга бүхий иж бүрэн уурын зуухыг барьж ашиглалтанд оруулсан.

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

Өмнөговь аймгийн ЗДТГ-аас санаачилсан төслийг Сангийн ажлын алба хүлээн авч Харилцааны хороогоор хэлэлцэн дэмжсэний дагуу Сангийн Удирдах зөвлөлийн 2019-01-24 ний 02 -р тогтоолоор уг төслийг 1,0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан.

Захиалагч аймгийн ЗДТГ-аас төслийн гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг хуулийн хүрээнд зохион байгуулснаар Өмнөговь аймгийн “Шүтээн-Эрдэнэ” ХХК шалгарсан. Санхүүжүүлэгч “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь захиалагч аймгийн ЗДТГ, Гүйцэтгэгч “Шүтээн-Эрдэнэ” ХХК-тай “Баян-Овоо сумын уурын зуух барих” төслийн санхүүжилтийн гэрээг 2019-08-09 өдөр байгуулснаар төслийн үндсэн ажил эхэлсэн.

»» ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

ОХУ-д үйлдвэрлэсэн Сталь-20 маркын гангаар үйлдвэрлэсэн хагас автомат 2МВт-ийн 2 ширхэг усан халаалтын тогоотой, зураг төслийн дагуу баригдсан иж бүрэн барилга байгууламж бүхий шинэ уурын зуух ашиглалтанд орсон. Тогоо нь нүүрс дамжуулагч автомат конвер, галын хотлын нүүрс тэжээгч, шидэгчээр тоноглогдсон. Энэ нь ажилчдын ажиллах нөхцөлийг сайжруулж, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлсэн

- Нэг тогооны нүүрс зарцуулалт 24 цагт 5-6тн
- Уурын зуухны барилга, нүүрсний байр, 400 метр хашаа шинээр барьсан
- Сумын төвийн төвлөрсөн дулаан хангамжийн хүчин чадал 3 дахин нэмэгдсэн.
- Хувийн орон сууцтай айл өрх, аж ахуйн нэгж байгууллагууд төвлөрсөн дулаан хангамжийн системд холбогдох боломжтой болно
- Шинэ уурын зуухын ашиглалтанд орохоос өмнө хангалттай халаалт авч чаддаггүй байсан сургууль, цэцэрлэг, эмнэлэг, төрийн үйлчилгээний барилга байгууламжуудын халаалт эрс сайжирч иргэд хэвийн нөхцөлд нийтийн үйлчилгээ авах, ая тухтай орчинд ажиллаж амьдрах нөхцөл бүрдсэн.

Гүйцэтгэгч “Шүтээн-Эрдэнэ” ХХК цаг хугацаандаа ажлаа бүрэн гүйцэтгэж улсын комист хүлээлгэн өгснөөр Баян-Овоочуудын гал голомт болсон шинэ уурын зуухны нээлтийн ёслол 2019-12-23 ны өдөр болсон. Энэхүү уурын зуух нь Оюутолгой компанийн хөрөнгө оруулалттай “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-аас санхүүжүүлж ашиглалтанд оруулж буй 3 дахь уурын зуух юм. Өмнө нь тус сангаас Манлай, Ханбогд сумдад шинэ уурын зуух барих төслийг санхүүжүүлэн ашиглалтанд оруулж байсан.

ХАНБОГД СУМЫН ӨВС ТЭЖЭЭЛИЙН АГУУЛАХ БАРИХ ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	“ЛОГМОН” ХХК
БАТЛАГДСАН ТӨСӨВ:	390,524,820 төгрөг
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	370,125,833 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Сүүлийн арван жилд Ханбогд сумын малын тоо толгой эрчимтэй өсч, өнгөрсөн жилийн мал тооллогоор 170 мянга гаруй мал тоологдсон нь сумын бэлчээрийн даацад сөргөөр нөлөөлж байна. Мөн тус суманд 4-5 жилийн давтамжтай ган, зуд болдог, Улаанбаатар хот, Сүхбаатар аймаг зэрэг 1000 гаруй километрийн зайтай газраас өвс, тэжээлээ татдаг зэрэг нь стандартын шаардлагад нийцсэн нөөцийн өвс, тэжээлийн агуулахтай болох нэн шаардлагатайг харуулж байна.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Энэхүү төслийн гол зорилго нь Ханбогд суманд стандартын шаардлага хангасан өвс тэжээлийн агуулах барьж, байгалийн гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл болох ган, зудын гамшгаас мал сүргээ хамгаалах цаашлаад малчин иргэдийн амьдралын баталгаа сайжруулах

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-ийн 2019 оны 1 дүгээр сарын 24- ний өдрийн 02 дугаар тогтоолоор Өмнөговь аймгийн Ханбогд суманд Өвс тэжээлийн агуулах барих төслийг санхүүжүүлэхээр дэмжиж төслийн санхүүжилтийг батлав

- Захиалагч аймгийн ЗДТГ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Логмон” ХХК-тай санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” гэрээ байгуулснаар барилга угсралтын ажлыг эхлүүлэв.
- Барилга угсралтын ажил 2019 оны эцсийн байдлаар 80 хувьд хүрэв.
- 2020 оны 2-р улиралд барилгын ажил бүрэн дуусч ашиглалтанд хүлээлгэн өгнө.

»» ҮР ДҮН:

- Ханбогд сум стандартын шаардлагад нийцсэн өвс, тэжээлийн агуулахтай болно
- Байгалийн давагдашгүй хүчин зүйлээс мал аж ахуйг хамгаалахад дэмжлэг болно
- Малчдын амжиргаанд эерэг нөлөө авчирна

“ХАНБОГД СУМЫН ЦАХИЛГААН ШУГАМЫН ӨРГӨТГӨЛ” ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ
БАТЛАГДСАН ТӨСӨВ:	50,000,000 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Ханбогд сумын төвийн Жавхлант баг Шар дов хороололд 278 өрхийн 800 гаруй иргэд оршин суудаг бөгөөд одоогийн байгаа цахилгааны шугамын хүчин чадал, гэмтэл доголдлоос шалтгаалан цахилгааны хэрэглээ хязгаарлагдмал, найдваргүй байдаг.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Энэхүү төслийн гол зорилго нь иргэдийн амьдралын ая тухтай байдлыг хангах цаашлаад цахилгааны эх үүсвэрийн гэмтэл, доголдлоос шалтгаалж иргэдийн амь нас, эд хөрөнгө сүйдэх эрсдэлээс хамгаалах, бууруулах юм.

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-ийн 2019 оны 6 дугаар сарын 26-ний өдрийн 07 дугаар тогтоолоор Өмнөговь аймгийн Ханбогд сумын цахилгааны шугамын өргөтгөл төслийг санхүүжүүлэхээр дэмжиж төслийн санхүүжилтийг батлав
- Ханбогд сум гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер зарлана.

»» ГАРАХ ҮР ДҮН:

- Сумын төвд оршин суудаг 5500 орчим иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөл бүрдэнэ.
- Цахилгааны эх үүсвэрийн хүчдэлийн өөрчлөлт, хэлбэлзлээс шалтгаалсан иргэдийн амьдрах орчин, амь нас, өмч хөрөнгийг хамгаална.

2018 ОНООС ОН ДАМЖИН ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД:

“МАХ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН БАРИЛГА БАРИХ” ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	“ГҮҮД РҮҮТ ИНТЕР ТРЕЙДИНГ” ХХК
ТӨСЛИЙН ТӨСӨВ:	4,861,000,000 төгрөг
ГОВИЙН ОЮУ ХДС-ИЙН САНХҮҮЖИЛТ ТӨСӨВ:	975,000,000 төгрөг
ГҮҮД РҮҮТ ИНТЕР ТРЕЙДИНГ ХХК-ИЙН САНХҮҮЖИЛТ	3,886,000,000 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Өмнөговь аймагт мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр байхгүй учир орон нутгийн иргэд, байгууллага, уул уурхайн байгууллагуудын ажилчдын хүнсний эрүүл ахуйн нөхцөл хангагдахгүй байгаагаас гадна малчид малаа орон нутагтаа зах зээлийн жишиг үнээр борлуулах, орон нутгийн энэ чиглэлийн бизнес эрхлэгчдэд эрүүл ахуйн стандартад нийцсэн мах хөлдөөж, хадгалах агуулах шаардлагатай байгаа. Мөн Өмнөговь аймгийн нийт хүн амын 38,1% буюу 25016 хүн Даланзадгад сумын төвдөө амьдарч байна. Нэг хүний махны хэрэглээг жилийн 84 кг-аар тооцож үзвэл жилдээ 2,101,344 тонн махны хэрэглээтэй байх боломжтой. Дотоодын зах зээлд хэрэглэж байгаа нийт махны 3%-ийг үйлдвэрийн аргаар боловсруулж хэрэглэж байна.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Энэхүү төслийн гол зорилго нь аймгийнхаа онцлогт тохирсон үйлдвэрлэлийг хөгжүүлэн орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах, малчдаа дэмжин хамтран ажиллаж өрхийн орлогыг нь нэмэгдүүлэх, өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлдвэрээс гарсан бүтээгдэхүүнийг шинээр нь нутгийн иргэд, хэрэглэгч аж ахуй нэгжүүдэд нийлүүлэх юм.

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2017 оны 10 дугаар сарын 02- ны өдрийн 15 дугаар тогтоолоор Өмнөговь аймгийн Даланзадгад суманд Нядалгааны цэг бүхий мах ангилан ялгах, хадгалах үйлдвэр барих төслийг санхүүжүүлэхээр дэмжиж төслийн санхүүжилтийг батлав
- Захиалагч аймгийн ЗДТГ төсөл сонгон шалгаруулж, хэрэгжүүлэгчийг сонгон гэрээ байгуулсны дагуу захиалагч аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Гүүд рүүт Интер Трейдинг” ХХК-тай санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” гэрээ байгуулснаар барилга угсралтын ажлыг эхлүүлэв.
- Гүйцэтгэгч, хамтран санхүүжүүлэгч “Гүүд рүүт Интер Трейдинг” ХХК гэрээний дагуу төлөвлөгөөт хугацаанд ажлаа гүйцэтгэж ашиглалтанд оруулах техникийн болон улсын комисс ажилласнаар уг төсөл амжилттай хэрэгжлээ.

»» ҮР ДҮН:

- Өмнөговь аймагт нядалгааны цэг бүхий мах ангилан ялгах, хадгалах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх цогцолбор үйлдвэрийн орчин бий болно.
- Аймгийн малчидтай хамтарч ажиллах, эрүүл ахуйн шаардлага хангасан мах нийлүүлсэн малчинд жилийн эцэст ногдол ашиг хуваарилах ажлыг хоршоогоор дамжуулан гүйцэтгэнэ
- Мах худалдаалах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллага, иргэд 400тн багтаамжтай, бүрэн тоноглогдсон гүн хөлдөөх, сэврээх агуулахаар үйлчлүүлэх боломж бүрдэнэ
- Орон нутгийн иргэдэд тогтвор суурьшилтай ажиллах 15-20 ажлын байр шинээр бий болсон
- Зэргэлдээ орших аймаг, сум болон уул уурхайн томоохон компаниудын хүнсний хэрэгцээнд мах, махан бүтээгдэхүүн нийлүүлэх боломжтой болно.

“МАНДАЛ-ОВОО СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ШИНЭ БАРИЛГА БАРИХ” ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	“ХОС БОР МОРЬ” ХХК
БАТЛАГДСАН ТӨСӨВ:	1,740,806,062 төгрөг
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	1,199,126,939 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Мандал-Овоо сумын хүн эмнэлэг нь 1979 онд ашиглалтад орсон, чулуун суурьтай, тоосгон ханатай, модон хучилттай, ашиглалтын шаардлага хангахаа больсон нэг давхар барилгатай байсан.

Барилгын төмөр дээвэр олон жилийн эдэлгээ, зэврэлтийн улмаас цоорч, дээврийн найдвартай байдал алдагдсан, цас борооны ус байнга нэвчдэг, барилгын дам нуруу, хучилт зөвшөөрөгдөх хэмжээнээс илүү хотойсон, модон хучилтын бамбай цөмөрч унасан зэрэг асуудал нь эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд хүндрэл учруулдаг.

Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх стандарт хангагдаагүйгээс халдвар дамжих, барилга ашиглалтын явцад иргэдийн эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд аюул учрах өндөр эрсдэлтэй. Энэ байдлыг харгалзан 2017 онд Мэргэжлийн хяналтын байгууллагаас уг барилгыг ашиглалтын шаардлага хангахгүй гэсэн дүгнэлт гаргасан. Иймд эмнэлгийн стандарт, магадлан итгэмжлэлийн шалгуур хангахгүй болсон тул тус сумын иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хэвийн нөхцөлд үзүүлэх бололцоог бүрдүүлэхийн тулд стандартад нийцсэн эмнэлгийн барилга барих шаардлага тулгарсан.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Мандал-Овоо сумын хүн амд үзүүлдэг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх орчин үеийн стандарт шаардлага хангасан эмнэлгийн барилга барьж ашиглалтанд оруулах.

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн Удирдах зөвлөлийн 2018 оны гуравдугаар сарын 15-ны өдрийн 06 дугаар тогтоолоор Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын эрүүл мэндийн төвийн шинэ барилга барих төслийг санхүүжүүлэхээр дэмжиж санхүүжилтийг батлав
- Захиалагч аймгийн ЗДТГ гүйцэтгэгчийн сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу Захиалагч аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Хос бор морь” ХХК-тай санхүүжүүлэгч “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” санхүүжилтийн гэрээ байгуулсан
- Улмаар барилга угсралтын ажлыг стандарт норм дүрмийн дагуу гүйцэтгэж Улсын комисст хүлээлгэн өгснөөр 2019 оны 09 сарын 18 ны өдөр Мандал-Овоочууд шинэхэн эмнэлгийнхээ нээлтийг хийж ашиглалтанд хүлээн авсан юм.

»» ҮР ДҮН:

- Мандал-Овоо сумын эрүүл мэндийн төв стандарт шаардлага хангасан шинэ барилгатай болж орон нутгийн иргэд болон явуулын хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг, чанартай хүртээмжтэй хүргэх бололцоо бүрдсэн

“ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЖИЖИГ ДУНД БИЗНЕСИЙГ ХӨГЖҮҮЛЭХ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:	GERMANY OLAN ULSYN KHAMTYN AJILLAGAANY NIYGEMLEГ
ХДС-ААС ОЛГОСОН САНХҮҮЖИЛТ	1,626,050,000 төгрөг
GERMANY OLAN ULSYN KHAMTYN AJILLAGAANY NIYGEMLEГИЙН САНХҮҮЖИЛТ:	1,946,936,000 төгрөг

»» ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

2017 онд “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” IRIM судалгааны хүрээлэнтэй хамтран Өмнөговь аймгийн иргэд, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, холбогдох мэргэжлийн байгууллагын төлөөллийг оролцуулан Хамтын ажиллагааны гэрээний сэдэвчилсэн хавсралт бүрээр олон талт хэлэлцүүлгийг зохион байгуулж “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн 2018-2021 онд баримтлах үндсэн чиглэл”-ийг боловсруулан сангийн Харилцааны хороо, Удирдах зөвлөлийн хурлуудад танилцуулан батлуулсан. Дээрх “Орон нутгийн жижиг, дунд бизнесийн хөгжил олон талт хэлэлцүүлэг”-ийн тайланд болон Өмнөговь аймгийн жижиг, дунд бизнесүүдийг дэмжих, чадавхжуулах, орон нутгийн шинэ бренд бүтээгдэхүүнүүдийг бий болгох зэрэг хэрэгцээ шаардлагад үндэслэн хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

»» ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

- Өмнөговь аймаг, Говийн бүсэд нийгмийн хөгжил, эдийн засгийн төрөлжилт, өсөлтийг урт хугацаанд хангах
- Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, орлогын тогтвортой эх үүсвэрийг бий болгох
- Орон нутаг, бүс, үндэстний түвшинд жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх
- Орон нутгийн хөгжлийн урт хугацааны стратегийг боловсруулж, хэрэгжүүлэхэд оролцогч талуудын оролцоо, чадавх, өрсөлдөх чадварыг сайжруулах

»» ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

“Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг хамтарсан санхүүжилтээр Даланзадгад суманд “Өмнөговь аймгийн жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх” хөтөлбөрийг 3 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн хүрээнд:

- Даланзадгад сумын төвд байгуулах Бизнесийн инноваци, хөгжлийн төвийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, менежментийн тогтолцоо зэргийг тодорхойлон төвийг төрийн бус байгууллага байхаар холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд үүсгэн байгуулна.
- АЗДТГ, “Оюу толгой” компани, хөтөлбөрийн хамтран санхүүжүүлэгч байгууллагуудын төлөөлөл, бие даасан эдийн засагч нарыг оролцуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй Удирдах зөвлөл төвийн үйл ажиллагааг удирдан чиглүүлнэ.
- Төвийн үйл ажиллагааг хөтөлбөрийг хэрэгжүүлэгч GIZ /Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг/-с удирдан хэрэгжүүлнэ.
- Төвөөс үйлчилгээ авахаар бүртгүүлсэн компаниудад урьдчилсан үнэлгээ, дүн шинжилгээ хийж түвшнийг нь тогтоох бөгөөд компанийн удирдлагатай санал солилцон тохирох чадавхжуулах сургалтуудыг зохион байгуулна.
- Чадавхжуулах сургалтууд нь төлбөртэй, 1-3 хоног үргэлжлэх бөгөөд дараах сэдвүүдээр зохион байгуулагдана. Үүнд:
 - ◇ Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал
 - ◇ Бизнесийн нэгдмэл байдал ба дүрэм журмыг мөрдөх нь
 - ◇ Санхүүгийн боловсрол
 - ◇ Хүний нөөцийн удирдлага
 - ◇ Компанийн удирдлага менежмент
 - ◇ Худалдан авалт, ложистик, нийлүүлэлтийн сүлжээний менежмент, кластерын хөгжил
 - ◇ Чанарын удирдлага
 - ◇ Үйлдвэрлэлийн үр ашиг, бүтээмжийн менежмент, аж үйлдвэр
 - ◇ Хууль эрх зүй, гэрээний менежмент
 - ◇ Дижитал технологи ба хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах
 - ◇ Борлуулалт, маркетинг
 - ◇ Инновацийн менежмент
 - ◇ Байгаль орчин тогтвортой байдал
- Сургалтуудыг дараах техник үйл ажиллагаануудтай хослуулж зохион байгуулна. Үүнд:
 - ◇ Түншлэл тогтоох: Аж үйлдвэрийн үзэсгэлэн худалдаа, аялал, танилцах аялал, ажлын байран дээрх сургалт
 - ◇ Худалдан авагч, борлуулагчийн хооронд уулзалт, семинар зохион байгуулах
 - ◇ Онлайнаар бизнесийг холбох платформ, вэбсайт, мэдээллийн бааз байгуулж, түүнд бизнесийн түнш хайж байгаа эсвэл туслан гүйцэтгэгч компаниуд бүртгүүлж болохоор зохион байгуулах.
 - ◇ Кластерын хөгжил /Кластер болон салбарын түвшинд уулзалт зохион байгуулах/

- ◇ Аймгийн ЗДТГ-т эдийн засгийн бодлого, зохицуулалтыг сайжруулахад ялангуяа жижиг, дунд үйлдвэрлэлийн чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлнэ

»» ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- “Оюу толгой” компанийн одоогийн ханган нийлүүлэгч, болохоор ажиллаж байгаа компаниудад ЖДҮ-ийг сургаж, чадавхжуулах бөгөөд үүний үр дүнд тухайн компанийн гүйцэтгэл, үйл ажиллагаа сайжирна
- Өмнөговь аймаг, цаашлаад улс даяарх ЖДҮ-үүд эхлээд орон нутагтаа дараа нь бүс, үндэсний түвшинд, улмаар олон улсын түвшинд хүрч ажиллах чадавх аажмаар нэмэгдэнэ
- Төсөлд хамрагдсан ЖДҮ-үүд уул уурхайн бусад компанийн ханган нийлүүлэгч болох боломж нэмэгдэнэ.

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

2019 онд:

- 2018 оны есдүгээр сард Даланзадгад суманд Бизнес инноваци хөгжлийн төвийг үүсгэн байгуулсан. Тус төв нь 2019 оны тавдугаар сараас орон нутгаас шийдвэрлэсэн байранд үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Бизнес инноваци хөгжлийн төвд төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг бөгөөд гарааны бизнес эрхлэгч, залуу бизнес эрхлэгч нарт зориулан дундын оффис үйлчилгээ явуулж байна.
- “Оюу толгой” компанийн ханган нийлүүлэгчдийг чадавхжуулах Багц 1, 2 / Ханган нийлүүлэгч ба бизнесийн ил тод байдал, ХАБ, эрүүл ахуй, байгаль орчин/ сургалтанд 29 бизнес эрхлэгчдийг хамруулсан
- ЖДҮ-ийг чадавхыг бэхжүүлэх хамтарсан хөтөлбөрийн үндсэн сургалт болох “Байгууллагын соёл-харилцааны ур чадвар” сэдэвт сургалтанд орон нутгийн 5 байгууллагын 65 ажилтан хамрагдсан.
- Монголын хоршооллын сургалт, мэдээллийн төвтэй хамтран Даланзадгад, Ханбогд, Баян-Овоо, Манлай, Булган сумдын 30 хоршоог алсын хараа, засаглал, бизнесийн хөгжил, санхүүгийн менежмент гэсэн дөрвөн үзүүлэлтээр үнэлэн 11 хоршоог чадавхжуулах шаардлагатай, 4 хоршооны зах зээл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд хөрөнгө оруулалт шаардлагатай гэж үнэлсэн. 2019 оны арваннэгдүгээр сараас хоршоодыг чадавхжуулах сургалт, зөвлөх үйлчилгээний ажлуудыг зохион байгуулж байна. Энэ ажил 2020 оны тавдугаар сар хүртэл хэрэгжих юм.
- Өмнөговь аймгийн бренд бүтээгдэхүүнийг хөгжүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд бренд бүтээгдэхүүн шалгаруулах уралдаан зарласан бөгөөд 19 бизнес эрхлэгч оролцож, 9 бизнес эрхлэгч бүтээгдэхүүнээ танилцуулснаас эхний гурван байрыг шалгаруулж нийт 50,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Энэ ажил цаашид орон нутгийн бренд бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх, олон нийтэд таниулах, сурталчлах, бизнесийн боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллана.

- Өмнөговь аймгийн жижиг, дунд үйлдвэрлэгчдэд “ЖАЙКА-ийн хөнгөлөлттэй зээл” авахад дэмжлэг үзүүлэх зорилгоор гурван шатны сургалт, зөвлөх үйлчилгээний ажлыг зохион байгуулж байна.
- Гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан эхний шатны сургалтанд 21 оролцогч хамрагдсан бөгөөд үүнээс 8 оролцогч төслийн санал ирүүлсэн. Эдгээрээс гурван оролцогчийг шалгаруулан санхүүгийн дэмжлэг үзүүлэх юм.
- Европын холбооны “Монголын худалдааг дэмжих” /EU TRAM/ төсөлтэй хамтран Өмнөговь аймгийн Цогт-Овоо, Сэврэй, Ханхонгор, Булган, Мандал-Овоо сумдын малчдыг хамруулан үйлвэрлэлийн чиглэлээр нийлүүлэх тором ноослох сургалт зохион байгуулж тэднийг торомны ноосоо борлуулах үндэсний үйлдвэрүүдтэй холбох, энэ чиглэлийн хоршоодыг бий болгох, дэмжих ажлуудыг зохион байгуулж байна. Төслөөс энэ ажлыг 2020 оныг дуустал зохион байгуулна.
- Тогтвортой хөгжил/Ногоон хөгжил, Тогтвортой хөгжлийн зорилтуудыг сурагчдад таниулан сурталчлах, Өмнөговь аймгийн орон нутгийн хөгжлийн 2030 он хүртэлх төсөөллийн хүрээнд Даланзадгад сумын 4 сургуульд хог хаягдал, ус ариун цэврийн байгууламж, тогтвортой хэрэглээ гэсэн сэдвүүдээр 2019 оны 09 сараас 12 сар хүртэл зорилтот төсөл хэрэгжүүлсэн. Уг төслийн хүрээнд 20 удаагийн арга хэмжээ зохион байгуулж 43 сургагч хүүхдүүд бэлтгэгдэж, Даланзадгад сумын ард иргэд, ЖДҮ эрхлэгчид, сургуулийн сурагчид, эцэг эхчүүд нийт 5800 хүнд түгээн дэлгэрүүлжээ. Зорилтот төсөлд амжилттай оролцсон 4-н сургууль тус бүрд /орон нутгийн ЖДҮ эрхлэгчтэй хамтран НХ, ТХ-ийн чиглэлээр төсөл хэрэгжүүлэх/ 3.0 сая төгрөгийн эрхийн бичгээр шагналаа.
- 2019 оны 11 дүгээр сарын 08-11 ний хооронд Өмнөговь аймгийн ЗДТГ болон холбогдох байгууллагуудтай хамтран “Говийн аялал-Цогц үйлчилгээ” аялал жуулчлалын салбарын зөвлөгөөнийг зохион байгуулсан.
- 2019 оны 12 дугаар сарын 06-нд Даланзадгад суманд “Ногоон эдийн засаг, эко Өмнөговийн төлөө бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн санаачилга-2019” форумыг зохион байгуулсан.
- ISO стандартаар баталгаажуулах чиглэлээр урьдчилсан судалгаа хийж, Өмнөговь аймгийн старт-апын эрэлт, хэрэгцээнд дүн шинжилгээ хийлээ
- Өмнөговь аймгийн БИГ төвд 2019 оны 1-5 сард 10 удаагийн сургалт зохион байгуулж нийт 105 хүнийг сургалаа.
- 5 сард зохион байгуулсан ЖДҮ-ийн үзэсгэлэн худалдааны үеэр “Хүний нөөцийн менежмент”, “Бүтээмжийн менежмент” сэдвээр сургалт зохион байгуулж, 60 хүнийг сургалаа.

Бусад

- 2019 оны 4 дүгээр сард БНХАУ-ын Гуандун мужийн Гуанжоу хотноо зохион байгуулагдсан “Canton fair-2019” бизнес аялалд 25 хүн оролцуулсан
- “Улаанбаатар түншлэл-2019” үзэсгэлэн худалдаа- “Ханбогд индастри” ХХК, “Баян уул” ХХК, “Өнөд өвлөх урлахуй” ХХК зэрэг компаниудын үйлдвэрийн танилцах аялал зохион байгуулсан.
- “ХАА салбарын хөгжил” сэдэвт ХБНГУлсад туршлага судлах аялалд 2 хүн оролцуулсан

- Беларусь, Казакстан улсуудад ХАА-н салбарын туршлага судлах аялалд 5 хүн оролцуулсан
- GIZ-ийн “ЭТИС” хөтөлбөртэй хамтран Сэлэнгэ, Увс, Баянхонгор, Орхон, Дорнод, Дундговь аймгуудын ЖДҮ, хоршоод, бизнес эрхлэгчдэд зориулсан сургалтууд
- “Илүү сайхан ирээдүйн төлөө” бизнес эмэгтэйчүүдийн чуулган-10 хүн
- “Дисковер Монголий 2019” олон улсын арга хэмжээ
- “Нэн түрүүнд ХАБ-2019” бага хурал
- “Оюу толгой” компанийн Нээлттэй өдөрлөг /Ханбогд, Манлай, Баян-Овоо сумд/
- Үндэсний хөгжлийн газрын Нээлттэй хаалганы өдөрлөг

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЭМЭГТЭЙЧҮҮД ЗАЛУУЧУУДЫН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ХАМТАРСАН ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ХАМТРАН САНХҮҮЖҮҮЛЭГЧ:	МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, АВСТРАЛИЙН ЗАСГИЙН ГАЗАР, ДЭЛХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА, НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮҮХДИЙН САН, НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮН АМЫН САН
НИЙТ ТӨСӨВ:	5,008,000,000 төгрөг
ГОВИЙН ОЮУ ХДС-ИЙН САНХҮҮЖИЛТ:	4,268,657,180 төгрөг /олгосон/
НҮБ-ЫН ХҮН АМЫН САНГИЙН САНХҮҮЖИЛТ:	2,993,414,100 төгрөг
НҮБ-ЫН ХҮҮХДИЙН САНГИЙН САНХҮҮЖИЛТ:	778,774,400 төгрөг
ДЭЛХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮЖИЛТ:	496,468,680 төгрөг
АВСТРАЛИЙН ЗАСГИЙН ГАЗРЫН САНХҮҮЖИЛТ:	1,216,835,000 төгрөг
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН САНХҮҮЖИЛТ:	2,433,670,000 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Өмнөговь аймагт нийт 60,675 байнгын оршин суугч хүн амын гуравны нэг нь 15 хүртэлх насны иргэд, гуравны хоёр нь 15-60 насны иргэд байна. 15-34 насны залуучууд нийт хүн амын 35 хувийг, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд мөн хүн амын гуравны нэгийг эзэлдэг. Хөдөлгөөнт хүн амын тоо их, оршин суугчидтайгаа бараг тэнцүү буюу ойролцоогоор 60,000 байгаа нь хүн амын тоон хурдацтай өсөлтөнд нөлөөлж байна.

Сүүлийн арваад жилд Монгол улсын эрүүл мэндийн гол үзүүлэлтүүд сайжирч, сүрьеэ өвчлөлөөс бусад эрүүл мэндтэй холбоотой Мянганы хөгжлийн зорилт (МХЗ)-уудад бүгдэд нь хүрсэн. Гэсэн хэдий ч ядуу, эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийг сайжруулахад бэрхшээл байсаар байна. Өмнөговь аймагт эхийн эндэгдэл 100,000 амьд төрөлтөд 212.9, үр хөндөлт 1,000 амьд төрөлтөд 301 байгаа нь улсын дунджаас өндөр үзүүлэлт юм.

Өсвөр насны охидын төрөлт 2016 онд 1,000 амьд төрөлт тутамд 24 байсан. Тус аймагт халдварт болон халдварт бус өвчлөл аль аль нь өндөр байгаа юм. БНХАУ-ын хилийн боомт руу өдөр бүр нүүрс тээвэрлэх 6,500 ачааны машин зорчдог. Холын тээврийн зам дээрх осол гэмтлийн улмаас зам тээврийн осол гэмтэл, нас баралт өндөр байна.

Умайн хүзүүний хорт хавдар нь эмэгтэйчүүдийн дунд түгээмэл тохиолддог хоёр дахь хавдар юм. Умайн хүзүүний хорт хавдрын үзлэг, оношилогоо Өмнөговь аймагт доогуур үзүүлэлттэй буюу оршин суугчдын ойролцоогоор 30 хувийг хамарч байна. Жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ), гэр бүлийн хүчирхийлэл (ГБХ) зэрэг нь улсын хэмжээнд түгээмэл, өргөн тархсан бөгөөд уул уурхайн үйл ажиллагааны оргил үед хамгийн өндөр байдаг. Нийгэм, эдийн засгийн үйлчилгээний төвлөрлийг сааруулах бодлогын хэрэгжилт эхний үе шатандаа явж байгаа бөгөөд орон нутгийн чадавхыг хөгжүүлэх, орон нутгийн түвшин дэх хөрөнгө нөөцийн дутагдалтай байдлыг шийдвэрлэх хэрэгцээ шаардлага их байна.

Санал болгож буй Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуучуудыг дэмжих НҮБ-ын байгууллагуудын нэгдсэн хөтөлбөр нь Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Зорилт 2030, Өмнөговь аймгийн хөгжлийн стратеги, түүнчлэн НҮБ-ын хөгжлийн тусламжийн хүрээ (НҮБХТХ)-ний Үр дүн 2 (нийгмийн хамгааллыг сайжруулах, чанартай, тэгш хамруулсан нийгмийн үйлчилгээг хүргэх) болон Үр дүн 3-ыг (иргэдийн дуу хоолойг дэмжих, хариуцлагатай байдлыг бэхжүүлэх) хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах юм.

Улсын хэмжээнд эхийн эндэгдэл (MMR) 2016 онд 100,000 амьд төрөлтөнд 48 байна. Гэсэн хэдий ч жирэмслэхээс хамгаалах арга хэрэгслийн хэрэглээний хувь гэр бүлтэй эмэгтэйчүүдийн дунд 2003 онд 69 хувь байсан бол 2013 онд 54.6 хувь болж буурсан. Үүнтэй адилаар, гэр бүл төлөвлөлтийн хангагдаагүй хэрэгцээ 2003 онд 4.6 хувь байснаа 2013 онд 16 хувь болж нэмэгдсэн ба 15-19 насны эмэгтэйчүүдийн дунд хамгийн өндөр (36.4%) байна. Ялангуяа үр хөндөлтийн түвшин 2008 онд 1,000 амьд төрөлтөд 169 байснаа эрс өсч 2013 онд 1,000 амьд төрөлтөд 205 ногдож байгаа нь санаа зовоож байгаа юм. Мөн өөр нэг санаа зовоож буй асуудал бол тэмбүүгийн тохиолдол 15-24 насныхны дунд 10,000 залуу хүн амд 60.4, 25-49 насныхны дунд 10,000 хүн амд 32 байгаа явдал юм.

Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, өсвөр насныхан, залуучуудын эрүүл мэндийн асуудлыг онцгойлон анхаарах шаардлагатай байгаа юм. 2016 онд эхийн эндэгдэл 100,000 амьд төрөлтөнд 212.9, ба үр хөндөлт 1,000 амьд төрөлтөнд 301 байгаа нь улсын дунджаас хамаагүй өндөр байгаа юм. Өсвөр насны охидын төрөлт 1,000 амьд төрөлтөд 24 байна.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО/ҮР ДҮН:

Нэгдсэн хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд дараах үр дүнгүүд гарсан байна.

Үүнд:

1. Эмэгтэйчүүд, залуучууд, өсвөр насныханд чиглэсэн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанар сайжирсан.
2. Бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ), умайн хүзүүний хорт хавдрын гаралт буурсан.
3. Умайн хүзүүний хорт хавдар зэрэг халдварт бус өвчнүүдийн илрүүлэг, эмчилгээ, зам тээврийн осол гэмтлийн үеийн эмчилгээ сайжирна.
4. Орон нутгийн түвшний засаглал бэхжиж, эрүүл мэндийн үйлчилгээний эрэлт бий болгох, хүн амд хүрч үйлчлэх тал дээр сайжирсан.
5. Залуучууд, өсвөр насныхан эрх мэдэлжиж, залуучуудын асуудлаарх бодлого, шийдвэр гаргах үйл явцад оролцдог болсон байна.
6. Жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах ажлыг чангатгасан.

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

Үр дүн 1: Эмэгтэйчүүд, залуучууд, өсвөр насныханд чиглэсэн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанар сайжирсан.

- Зорилт 1.1: Эмэгтэйчүүдэд зориулсан нөхөн үржихүйн эрүүл мэндийн чанартай, үйлчлүүлэгч-төвтэй үйлчилгээг дэмжиж ажилласан
 - o Гэр бүл төлөвлөлт, зөвлөх үйлчилгээ үзүүлэх зорилгоор Өмнөговь аймгийн БОЭТ-ийн амаржих газарт, Нөхөн үржихүйн эрүүл мэндийн цогц үйлчилгээний нэгж байгуулж үйл ажиллагааг жигдрүүлэн 112 хүнд үйлчилсэн.
 - o “Мари Стопс Интернэйшил”-тэй хамтран сургалт зохион байгуулж, их эмч, эх баригч, мэргэжилтэн нийт 24 хүнд гэр бүл төлөвлөлт, жирэмслэлтээс хамгаалах орчин үеийн арга, туршлагаудыг таниулж ур чадварыг нь дээшлүүлэв.
 - o Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газар, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль хамтран Өмнөговь аймгийн 12 сумын Сумын эрүүл мэндийн төв, Сум дундын эмнэлэг, БОЭТ, Эрүүл мэндийн газрын 27 их эмч, эх баригч, сувилагчдад сургалт зохион байгуулж ажлын байран дээрх дадлагын сургалт зохион байгуулсан.
 - o Эрүүл мэндийн ажилтнуудын IV их хурал болж нийслэлийн 350, аймаг, орон нутгийн 450 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүд оролцож эх хүүхдийн эрүүл мэндийг сайжруулахад чиглэсэн зөвлөмж гаргасан.
 - o Өмнөговь аймгийн БОЭТ болон сумдын эрүүл мэндийн төвүүдийн чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор эхо аппарат, биохимийн анализатор, нярайн дулаацуулах ширээ, ургийн доплер, хяналтын монитор, хүчилтөрөгч өтгөрүүлэгч, инкубатор, нярайн шарлагын аппарат, хэмжигч, компьютер томограф нийлүүлсэн.

- Люксембургийн Засгийн газартай хамтран 1.2 сая Америк долларын хөрөнгө оруулалтыг гаргаж үндэсний түвшний сургалтын 2 лаборатори, аймгийн түвшний 22 загварчилсан сургалтын өрөө, 24 телемедицины шууд дамжуулалтын нэгж байгуулж сургалтыг өөрсдийн танхимаар дамжуулан гүйцэтгэж зайн оношлогоо, зөвлөгөөг шууд хүлээн авах боломжтой болсон.
- Зорилт 1.2: Үйлчлүүлэгч төвтэй, залуучуудад ээлтэй бэлгийн, нөхөн үржихүйн, сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээг залуучууд, өсвөр насныханд үзүүлдэг болсон.
 - Өмнөговь аймгийн сумдын өсвөр үеийн кабинетийн нөхцөл байдлыг судалж кабинетуудын нөхцөлийг сайжруулж тусгаарлалтын ханыг байрлуулан үйлчлүүлэгчдийн нууцлалыг хангах ажил хийсэн
 - Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв болон Халдварт өвчин судлалын үндэсний төвтэй хамтран Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газрын өсвөр үе, залуучуудын эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн, нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэргэжилтэн болон Даланзадгад, Ханбогд сумын өсвөрийн үеийн эмч, зөвлөхүүдэд 2 шатны сургалт зохион байгуулсан.
 - Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт болон эрүүл харилцааны талаар өсвөр үеийнхэн мэдээлэл авч болохуйц цахим орчныг Ханбогд, Даланзадгад сумдын өсвөр үеийн кабинетуудад боловсруулж өгсөн.
 - Өмнөговь аймгийн хэмжээнд 145 эмч, нийгмийн ажилтан болон бусад холбогдох мэргэжилтнүүдийг өсвөр үеийн сэтгэцийн эрүүл мэнд ба мансууруулах бодис урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтанд хамруулав.
 - Эрүүл мэндийн хөгжлийн төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран өсвөр насны сэтгэцийн эрүүл мэндийн асуудлын талаар тархалтыг тодорхойлох суурь судалгаа хийсэн.
 - 2019 оны байдлаар нийт 317 залуус, өсвөр үеийн кабинетаар үйлчлүүлсний 90.7 хувь нь 15-19 нас, 9.3 хувь нь 20-24 насныхан байсан бөгөөд 301 нь зөвлөгөө авч, 16 нь БЗДХ-ын эмчилгээнд хамрагдсан ба 124 өсвөр үе, залуучуудад жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэл түгээсэн.
 - Залуучуудын үе тэнгийн боловсролын үндэсний сүлжээгээр дажуулан орон нутгийн 3 Y-Peer клубын үйл ажиллагааг дэмжиж ажилласан. Даланзадгад, Ханбогд, Цогтцэций сумдын залуучуудын хөгжлийн төвүүд нийт 91 үе тэнгийн сургагч нартай хамтран өсвөр үе, залуучуудад нөхөн үржихүйн боловсрол, мэдээлэл өгч ажилласан
- Зорилт 1.3: Үйлчлүүлэгч төвтэй, залуучуудад ээлтэй бэлгийн, нөхөн үржихүйн, сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээг залуучууд, өсвөр насныханд үзүүлдэг болсон.
 - Монгол улсын хэмжээнд сумдын эмнэлгүүдэд зайн оношилгооны сүлжээг Өмнөговь анх удаа нэвтрүүлж уг сүлжээгээр сумдын эмнэлгийн

мэргэжилтнүүд БОЭТ-өөс сургалт, арга зүйн зөвлөгөөг цаг алдалгүй авах боломж бүрдсэн.

- Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн зүгээс зайн оношилгоогоор дамжуулан хүргэх сургалтын нэгдсэн хөтөлбөрийг боловсруулсны дагуу аймаг тус бүрээс эх баригч, эмэгтэйчүүд болон нярайн эмч, эрүүл мэндийн ажилтнуудыг оролцуулан нийт 42 хүнд үйл ажиллагааны стандарт журмыг түгээсэн.
 - Зайн оношилгооны сүлжээнд сум дундын гурван эмнэлгийг холбож шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгсэл, програм хангамжийн худалдан авалт, нийлүүлэлтийг хийсэн
 - Оношилгоонд шаардлагатай дижитал дүрсийг гаргадаг, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн экспертүүдийн холбогдсон зайн оношилгооны сүлжээний DICOM модулийн лицензийг орон нутагт олгож Ханбогд, Цогтцэций, Гурватэс сумдыг холбосон бөгөөд уг сумд БОЭТ-тэй холбогдон 29 тохиолдолд нарийн мэргэжлийн зөвлөгөө авсан байна.
 - Эх барихуйн ур чадварын сургалтын кабинетийн холбогдох тоног төхөөрөмжийг Өмнөговь аймгийн БОЭТ-д өгсөн.
- **Зорилт 1.4: Эрүүл мэндийн технологи, явуулын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөжүүлэн сайжруулна.**
 - Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчид болон үйлчлүүлэгчдэд зориулсан mHealth гар утасны програмыг боловсруулж Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн мэдээллийн технологийн хэлтэст хүлээлгэн өгсөн.
 - Эх барих, эмэгтэйчүүдийн болон нярайн эмч нарын лекцүүдийг хуулбарлан дээрх зайн сургалтын цахим хаягт байршуулсан
 - **Зорилт 1.5: Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм хэрэгслийн баталгаатай байдал,(чанар, ханган нийлүүлэлт, түгээлтийн тогтолцоо, эргэх хяналт) хангагдсан байна.**
 - Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм хэрэгслийн ханган нийлүүлэлтийн тасралтгүй байдлыг хангах зорилгоор үндэсний түвшинд нөлөөллийн ажил хийсний үр дүнд 2019 оны улсын төсөвт жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслийн хангамжинд зарцуулах 1.8 тэрбум төгрөг зарцуулахаар багтаасан. Өмнөговь аймгийн хэмжээнд нийт 43 сая төгрөгийн санхүүжилтээр жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэл худалдан авч нийлүүлсэн.
 - Өмнөговь аймгийн өсвөр үеийн кабинет болон сумын бүх эмнэлгүүд жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн таван төрлийн арга хэрэгслээр (бэлгэвч, уух эм, ерөндөг, тариа, суулгац) үйлчилгээ үзүүлэх боломжтой болсон.
 - “Мари Стопс Интернэйшнл”-тэй хамтран Даланзадгад хотод “Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт” сэдвээр сургалт хийж, орон нутгийн эмч, эх баригч нарын чадварыг сэргээж, мэргэжлийн арга техникт сургасан.

- Зорилт 1.6: Үндэсний болон аймгийн түвшинд эмэгтэйчүүд, залуучууд, өсвөр үеийнхний нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хуваарилж буй төсвийг нэмэгдүүлсэн байна.
 - Австрали улсад эрүүл мэндийн салбарын туршлага судлах аялалыг зохион байгуулж Мельбурн, Бендиго, Эчука хотуудын эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдтэй танилцсан. Энэ нь эрүүл мэндийн салбарын засаглал, удирдлага зохион байгуулалт, санхүүгийн хариуцлага болон яаралтай тусламж, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний талаар судлах боломж олгосон. Өмнөговь аймгийн БОЭТ, Эчука бүсийн эмнэлэг хооронд харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж цаашдаа туршлага судлан хамтран ажиллах боломж бүрдсэн.
 - Залуучууд хөгжлийн төвийн үйлчилгээний өртөг тооцох аргачлалыг боловсруулсан. Урьдчилсан дүнгээс харахад улсын төсвийн 3 хувь, Өмнөговь аймгийн төсвийн 29.2 хувь нь залуучуудын бодлого хөтөлбөрт хуваарилагдсан байна.

Үр дүн 2: Бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ), умайн хүзүүний хорт хавдрын гаралт буурсан байна.

- Зорилт 2.1: БЗДХ-аас урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон эмчилгээг сумын эмнэлгүүд дээр хийдэг болсон байна.
 - Өмнөговь аймгийн БОЭТ-ийн Бэлгийн замын кабинетэд орон нутгаас тусгайлсан эмч томилон ажиллуулж эхэлсэн бөгөөд уг кабинетийг бүрэн ашиглаж эхэлсэн. БЗДХ-ын кабинет болон Ханбогд, Цогтцэций сумдын Сум дундын эмнэлэгүүдийн БЗДХ-ыг илрүүлэн амчлэх тогтолцоог сайжруулахаар техник болон менежментийн дэмжлэг үзүүлэв.
 - Өмнөговь аймгийн иргэдийн дунд БЗДХ, эмэгтэйчүүдийн болон нөхөн үржихүйн архаг өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоо хийх эхний үйл ажиллагаа Гурвантэс, Ханбогд, Цогтцэций сумдад зохион байгуулагдсан. Урьдчилан сэргийлэх үзлэгт нийт 3208 иргэн (1027 эрэгтэй, 2181 эмэгтэй) хамрагдсан бөгөөд нөхөн үржихүйн насны 5044 (15-49 нас) эмэгтэйчүүдээс 1294 (25.7%) нь БЗДХ-ын шинжилгээ болон эмэгтэйчүүдийн үзлэгт хамрагдсан. Эрчүүдийн 11.1% буюу нийт 756 хүнийг үзлэгт, БЗДХ-ын шинжилгээнд хамруулжээ.
 - 2019 онд Даланзадгад болон 14 сумын нийт 40 лабораторийн эмч, эрүүл мэндийн ажилтнуудад нөхөн үржихүйн замын халдварын оношилгоо, эмчилгээний чадавхийг нэмэгдүүлэх сургалтыг зохион байгуулсан.
- Зорилт 2.2: Эхээс хүүхдэд халдах тэмбүү, ХДХВ, гепатит В-ын халдварыг устгасан байна.
 - Эхээс хүүхдэд тэмбүү, ХДХВ, гепатит В вирусын халдвар дамжихыг таслан зогсоох гуравласан устгалын үндэсний удирдамжийн төслийг боловсруулж бүс нутгийн жирэмсний үеийн тусламж үйлчилгээний бодит, энгийн алгоритмуудтай уялдуулсан. ЭМЯ нь дээрх төслийг хянан батлуулахаар ажиллаж байна
 - Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвөөс БОЭТ-ийн болон сумын ЭМТ-

үүдийн нийт 22 эмч, эх баригч нарт тэмбүү, ХДХВ, гепатитын халдвараас урьдчилан сэргийлэх тухай ажлын байран дээрх системчилсэн сургалтыг зохион байгуулсан.

- o Үе тэнгийн сургагч багш бэлтгэж сургалтанд шаардлагатай багаж тоног төхөөрөмж нийлүүлж кабинет тохижуулан хүлээлгэн өгсөн.

• **Зорилт 2.3: Умайн хүзүүний хорт хавдрын анхдагч урьдчилан сэргийлэлт, илрүүлэг, эмчилгээний мэдээлэл харилцааны стратеги боловсруулж хэрэгжүүлсэн байна.**

- o “Умайн хүзүүний хорт хавдраас урьдчилан сэргийлэх, хянахтай холбоотой хүн ам, нийгмийн идэвхийг сайжруулах ухуулга нөлөөлөл, харилцаа холбооны багц стратеги” болон хяналт, үнэлгээний төлөвлөгөөг тус тус боловсруулсан бөгөөд ЭМЯ-ны зүгээс энэ бичиг баримтыг 2020 оны нэгдүгээр сард батлуулах төлөвлөгөөтэй байгаа.
- o “Умайн хүзүүний хорт хавдраас урьдчилан сэргийлэх, хянахтай холбоотой хүн ам, нийгмийн идэвхийг сайжруулах ухуулга нөлөөлөл, харилцаа холбооны багц стратеги”-ийг таниулах 5 өдрийн сургалт, семинарыг зохион байгуулж 48 эмч, эрүүл мэндийн ажилтнуудыг хамруулж 50 багц тараасан.
- o ДЭМБ-аас умайн хүзүүний хорт хавдрыг эрт илрүүлэх зорилгоор хүний хөхөнцөр вирусн шинжилгээг улсын нэгдсэн үзлэгийн хөтөлбөрт оруулахаар зөвлөж байгаа. Үүнтэй холбоотойгоор ЭМЯ болон ХӨСҮТ-ээс хүний хөхөнцөр вирусн шинжилгээг 2019 оноос Улаанбаатар хотод нэвтрүүлж эхлээд байгаа бөгөөд Өмнөговь аймагт уг шинжилгээг хийж эхэлсэн анхны аймаг болж 35-45 насны нийт 120 эмэгтэйг шинжилгээнд хамруулаад байна.

• **Зорилт 2.4: БЗДХ-ын (тэмбүү, заг хүйтэн, хламид) тандалтын тогтолгоог бий болгоно.**

- o Дорнод, Говь-Алтай, Төв, Өмнөговь аймгуудын холбогдох эмч, мэргэжилтнүүд болон Улаанбаатар хотын БЗДХ-ын кабинетийн эмч, ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын тандалт, судалгааны албаны эмч, тархвар судлаачдыг оролцуулан БЗДХ-ын тандалтын тогтолцооны нөхцөл байдал, урагшлах арга замуудын талаар зөвлөлдсөн.
- o ХӨСҮТ 2 удаагийн хяналт шалгалтыг Өмнөговь аймгийн төв болон сумдад хийсэн.
- o ЭМЯ Хятадын БЗДХ-ын Үндэсний төвтэй бодлогын хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд Монгол улсын сонгогдсон аймаг, нийслэлийн бүсүүдэд гонококкийн нянгийн тэсвэрлэлт болон тэмбүүгийн тархалтыг хянах бүтэц бий болгохоор зөвшилцөв.

Үр дүн 3: Умайн хүзүүний хорт хавдар зэрэг халдварт бус өвчнүүдийн илрүүлэг, эмчилгээ, зам тээврийн осол гэмтлийн үеийн эмчилгээ сайжирна.

- **Зорилт 3.1: Умайн хүзүүний хорт хавдрыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.**

- Умайн хүзүүний хорт хавдраас шалтгаалсан өвчлөл, нас баралтыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх орон нутгийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах хэлэлцүүлэг зохион байгуулж ЭМГ-аас умайн хүзүүний хорт хавдраас шалтгаалсан өвчлөл, нас баралтыг бууруулах орон нутгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг эцэслэн боловсруулсан.
- Зорилт 3.2: Өмнөговь аймагт эх хүүхдийн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт, халдварт, халдварт бус өвчнүүдийг багтаасан эрүүл мэндийн цогц үйлчилгээ үзүүлэхэд явуулын эрүүл мэндийн технологийг эрүүл мэндийн анхан шатанд ашигладаг болсон байна.
 - Анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж буй эмч, мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэх “Хэнийг ч үл орхих” зарчмын дагуу хүн төвтэй эрүүл мэндийн төвүүдэд чадавх бэхжүүлэх үе шаттай сургалтуудыг зохион байгуулж хяналт үнэлгээ хийсэн. Сургалтанд 10 сум болон аймгийн ЭМГ-ын нийт 60 эмч, мэргэжилтнүүд хамрагдан явуулын эрүүл мэндийн технологи ашиглан анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг төлөвлөх, удирдах, тоног төхөөрөмж ашиглалт, түргэвчилсэн шинжилгээ хийх аргагүй, мэдээлэл цуглуулах, ашиглах зэрэгт суралцсан.
 - “Өрх болон сумын эрүүл мэндийн төвүүдээр үзүүлэх зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээ” нэртэй нийт 8 модулиас бүрдсэн 562 хуудас гарын авлага хэвлүүлж эрүүл мэндийн ажилтнуудад хүргүүлэв.
- Зорилт 3.3: Зам тээврийн аюулгүй байдлыг хангах, осол гэмтэлд хариу арга хэмжээ авах үндэсний болон аймгийн түвшний үйл ажиллагаа эрс сайжирч, Сум дундын эмнэлгүүд, уул уурхайн тээвэрлэлт дагасан сумын эмнэлгүүдийн яаралтай тусламж үзүүлэх чадавхи сайжирсан байна.
 - 2019 онд ДЭМБ-ын удирдлага дор БОЭТ болон Ханбогд, Цогтцэций, Номгон сумдын СДЭ-ийн анхан шатны болон мэс заслын тусламж үзүүлэх багийнхны чадавхыг бэхжүүлэх сургалтыг Өмнөговь аймагт зохион байгуулсан.
 - ДЭМБ түргэн тусламжийн эмнэлгийн хэрэгсэл, сургалтын тоног төхөөрөмжийг худалдан авч Өмнөговь аймгийн ЭМГ, БОЭТ-д хүлээлгэн өгсөн.

Үр дүн 4: Орон нутгийн эрүүл мэндийн салбарын засаглал, чадавх бэхжсэн байна

- Зорилт 4.1: Эмэгтэйчүүд, залуучууд, өсвөр үеийнхний эрүүл мэндийн асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн засаглал, шийдвэр гаргагчдын манлайллыг сайжруулсан байна.
 - Орон нутгийн засаглал, манлайллыг дэмжих зорилгоор хүүхдэд ээлтэй орон нутаг агуулга бүхий сургалт зохион байгуулж аймгийн холбогдох удирдлага, мэргэжилтнүүд, төрийн алба хаагчид, бүх сумдын удирдлага, боловсрол, эрүүл мэнд, хүүхэд, гэр бүл залуучуудын газар, хэлтсийн дарга, сургуулийн захирлууд, нийгмийн ажилтнууд гэсэн бүрэлдэхүүнтэй 110 хүнийг хамруулсан.

- Хүүхдэд ээлтэй орон нутаг стратегийг амжилттай хэрэгжүүлж байгаа Хөвсгөл аймгаас туршлага судлах аялал зохион байгуулж 25 хүнийг хамруулан практик туршлага судалсан.
 - Эмнэлгээр үйлчлүүлж байгаа иргэдийн сэтгэл ханамжийг сайжруулахад чиглэсэн санаачилгыг нэвтрүүлж олон нийтийн оролцоотойгоор орон нутгийн засаглал, хариуцлагыг бэхжүүлж, эрүүл мэндийн зохистой үйлчилгээг хүргэхэд эмнэлгүүдийн чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн
 - Нууцлаг үйлчлүүлэгч хөтөлбөрийн асуумж аргачлал боловсруулсан. Үйлчлүүлэгч болон тэдний гэр бүлийн гишүүдийн эрх үүргийг томъёолон хэвлүүлж судалгааны асуумжийн хайрцгуудын хамт эмнэлэг тус бүрт хүргүүлсэн.
- **Зорилт 4.2: Эмэгтэйчүүд, залуучууд, өсвөр насныханы асуудлаарх мэдээлэл харилцааны үйл ажиллагаа явагдсан байна.**
 - Засгийн газрын 163 тоот тогтоолын дагуу Осол гэмтлээс сэргийлэх Өмнөговь аймгийн зөвлөлийг байгуулж анхны хуралдаанаас аймгийн хэмжээнд зам тээврийн осол гэмтлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлж байна.
 - Иргэд ухаалаг утсаа ашиглан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ болон эмчилгээний талаар үндсэн мэдээлэл авах, эмнэлгээр үйлчлүүлэх цаг авах боломж бүхий аппликейшнийг нэвтрүүлэх ажил 80%-тай явж байна.
 - Монгол Австралийн эмч нарын хамтарсан баг өөр өөр зэргийн түлэгдэлттэй нийт 13 хүүхдэд амжилттай мэс засал хийв. 70 хүнд үзлэг хийж арьс нөхөн сэргээх үйлчилгээг 6 хүнд үзүүлэв

Үр дүн 5: Залуучууд, өсвөр насныхан эрх мэдэлжиж, залуучуудын асуудлаар бодлого, шийдвэр гаргах үйл явцад оролцдог болсон байна.

- **Зорилт 5.1: ЕБС, МБСБ-аар дамжуулан Бэлгийн цогц боловсрол олгож, залуучуудын хөгжлийн төвөөр дамжуулан амьдрах ухааны чадварууд эзэмшүүлсэн байна.**
 - 2019 онд эрүүл мэндийн хичээлийн номыг боловсруулж, хэвлүүлэн 21 аймгийн ЕБС-ийн 4-12 дугаар ангийн нийт сурагчдад түгээсэн.
 - Багшийн мэргэжил дээшлүүлэх институтээс дамжуулан бүх аймгийн багш, арга зүйч нарт эрүүл мэндийн хичээл заах талаар сургалт зохион байгуулж, 121 үндэсний сургагч багшийг бэлтгэсэн.
 - 2019 оны байдлаар улсын хэмжээнд нийт 377,932 сурагч, Өмнөговь аймгийн 22 ЕБС-ийн 7000 гаруй сурагчид бэлгийн боловсрол, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалтанд хамрагдаад байна
 - БСШУСЯ Өмнөговь болон бусад 7 аймгийн нийт 35 ЕБС-ийн эрүүл мэндийн хичээлийн хэрэгжилтэнд хяналт үнэлгээ хийсэн.

- Зорилт 5.2: Өмнөговь аймгийн залуучуудын хөгжлийн төвүүдийг хөгжүүлэн бэхжүүлж шинэ төвүүд байгуулан өргөжүүлсэн байна.
 - Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хүрээнд Даланзадгад, Ханбогд, Цогтцэций сумдын залуучууд хөгжлийн төвүүдийн үйл ажиллагааг Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яамны дэргэдэх гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн агентлагаар дамжуулан улсаас санхүүжүүлдэг болсон.
 - 2019 онд залуучууд хөгжлийн төвүүдээр дажуулан орон нутгийн 15-34 насны залуус, түүний дотор ажилгүй, сургууль завсардсан, хөгжлийн бэрхшээлтэй залуус болон гэрт суугаа залуу ээж нарт зориулан амьдрах ухааны сургалтууд зохион байгуулж зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд илгээх хуудсаар өсвөр үеийн кабинет зэрэг бусад нийгмийн үйлчилгээний газруудад илгээх, дэмжих бүлгийн болон сонирхлын клубуудын үйл ажиллагаанд хамруулах ажлыг зохион байгуулсан
 - 15-34 насны 2003 хүүхэд, залуус Өмнөговь аймгийн залуучууд хөгжлийн төвөөр үйлчлүүлсэн. Амьдрах ухааны сургалтын нийт 522 хүүхэд, залууст хийсэн ба 141 хүүхдийг өсвөр үеийн кабинет уруу илгээжээ.
 - Өмнөговь аймгийн ЗДТГ, болон ГБХЗХГ хамтран зөвшилцөж Булган, Номгон, Гурвантэс сумдад залуучууд хөгжлийн төв байгуулахаар шийдвэрлэсэн.
- Зорилт 5.3: Залуучуудын гарааны бизнес, залуу малчдын бүлгийг дэмжсэн байна.
 - Залуучуудын гарааны бизнесийг дэмжих төслийн хүрээнд Ханбогд сумын залуу малчид, залуучуудын бизнес эрхлэх чадавхыг нэмэгдүүлэхээр зорин ажиллаж байна. Ханбогд суманд зохион байгуулагдсан Start-up weekend арга хэмжээнд амжилттай оролцсон багуудад нийгэмд ээлтэй бизнес бий болгож үйл ажиллагаагаа тогтвортой үргэлжлүүлэх санхүүжилт олгож байна.
 - Бизнес эрхлэх хүсэл зорилготой залууст зориулж 13 бизнесийн сургалт, 2 бие даах сургалт зохион байгуулсан. 12 төрлийн анхан шатны бизнес зөвлөгөөг төслийн 30 оролцогчдод өгсөн.
 - “Залуучуудын Нийгмийн Энтрепренёршип Форум”-ыг Даланзадгад суманд зохион байгуулсан. Арга хэмжээнд 140 хүн оролцсоноос Ханбогд сумаас 18, Цогтцэций сумаас 12 залуу тус тус оролцсон. Форумын мини үзэсгэлэнгээр 20 залуу бизнес эрхлэгч нийт 980,000 төгрөгийн борлуулалт хийсэн.
- Зорилт 5.4: Өсвөр насныхныг чадавхжуулах, нийгэм сэтгэл зүйл чадвар эзэмшүүлэх чиглэлээр ЕБС-ийн хичээлээс гадуурх үйл ажиллагааны чанар, хүртээмжийг сайжруулсан байна.
 - Миний гэр бүл, Миний ертөнц хөтөлбөрийн амьдрах ухааны сургалтын агуулгад орох өөрчлөлтийг боловсруулахад техникийн дэмжлэг үзүүлэн ажиллаж шинэчлэн найруулсан удирдамжийг түгээсэн. Сургалтын дасгал ажлын товхимлуудыг Өмнөговь аймгийн сургуулийн 10-17 насны бүх хүүхдэд өгнө.

Үр дүн 6: Жендерт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах ажлыг чангатгасан байна.

- Зорилт 6.1: Аймаг болон сумын түвшинд ЖСХ-д хариу арга хэмжээ авах салбар дундын механизмыг байгуулсан байна.
 - Аймгийн хэмжээнд салбар дундын зохицуулалтын хороо/хамтарсан багийг байгуулах замаар жендерт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлд хариу арга хэмжээ авах бүтцийг бий болгож хороодын гишүүдийг Гэр бүлийн хүчирхийлэлд тэмцэх тухай хуульд мэдрэг байхаар суралцуулсан.
 - Хүчирхийллийн эсрэг үндэсний төвөөс Даланзадгад суманд шинээр байгуулагдсан Нэг цэгийн үйлчилгээний төвийн ажилчдад ажлын байрны сургалт зохион байгуулж хүчирхийлэлд өртсөн хүмүүст үйлчлэх, тэдэнтэй ажиллахад шаардагдах ур чадварыг эзэмшүүлсэн
- Зорилт 6.2: Өмнөговь аймагт ЖСХ болон гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод зориулсан Нэг цэгийн үйлчилгээний төвүүд байгуулсан байна.
 - Өмнөговь аймаг нь гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд үйлчилгээ үзүүлэх Нэг цэгийн үйлчилгээний төвийг байгуулсан ба 2019 онд төвөөр дамжуулан 10 эмэгтэйд хамгаалалт, хууль эрх зүйн болон бусад нийгмийн үйлчилгээг үзүүлсэн байна.
 - Төвийг байгуулахад орон нутгийн төсвөөс 200 орчим сая төгрөгийн санхүүжилтийг гаргаж байрыг худалдан авч засвар хийсэн. НҮБХАС-аас мөн техник, санхүүгийн дэмжлэг үзүүлж тохижилт, тоног төхөөрөмж, засварын ажилд 87 сая төгрөг зарцуулж төвийн ажилчдыг Баянхонгор, Говь-Алтай, Завхан аймгуудад туршлага судлах хөтөлбөрт хамруулсан.
- Зорилт 6.3: ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх боловсрол олгох болон Аюулгүй сургууль аргачлалыг Өмнөговь аймагт өргөжүүлсэн байна.
 - Өмнөговь аймгийн “Эрдмийн гэгээ” сургуулийн сайн туршлага, үр дүнд үндэслэн аймгийн хэмжээнд 7 ЕБС-ийг сонгон Аюулгүй сургууль аргачлалыг нэвтрүүлэхээр аймгийн БСУГ-тай зөвшилцсөн.
 - Аюулгүй сургууль аргачлалаар жендерт суурилсан хүчирхийллээс сэргийлэх зорилгоор MONFEMNET үндэсний сүлжээ аймгийн боловсролын газартай хамтран 3 өдрийн сургалтаар 210 боловсрол, нийгмийн ажилтан, 1368 сурагч, эцэг эхэд хүрч ажилласан.

2019 ОНД САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ХӨТӨЛБӨРҮҮД:

ЧАНДМАНЬ ЭРДЭНЭ ТӨСӨЛ



САНААЧЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР
ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	“ЗАГИЙН ХУДАГ” ХХК, “БОЛОР УС” ХХК, “БАЯН ДИНОЗАВР” ХХК, “ХИШИГ ЮНИВЕРС” ХХК
БАТЛАГДСАН ТӨСӨВ:	2018 ОНД: 400,000,000 ТӨГРӨГ 2019 ОНД: 421,600,000 ТӨГРӨГ
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	784,890,968 ТӨГРӨГ

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Ханбогд, Манлай, Баян-Овоо, Цогт-Овоо сумдад бэлчээрийн худаг, уст цэг дутагдалтай шалтгаанаар ашиглагдахгүй байгаа бэлчээрийн эдэлбэр газар харьцангуй их байна. Нийт малын тоо толгой, нэг малчин өрхөд ногдох малын тоо толгой жил тутам өсөн нэмэгдэж байгаа одоогийн нөхцөлд бэлчээрийг усжуулах, газрын доорх уст цэгийг хайгуул судалгааны аргаар олж тогтоох, эвдэрч гэмтсэн худгуудыг сэргээн засварлах зэргээр бэлчээрийн ус хангамжийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, сайжруулах нэн шаардлагатай байна.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Ханбогд, Манлай, Баян-Овоо, Цогт-Овоо сумын 15 багийн газар нутагт бэлчээрийн усжуулалтыг сайжруулан усан хангамжийн дутагдалтай, алслагдсан нутгийн бэлчээрийн ашиглалт, эргэлтийг нэмэгдүүлэх, бэлчээрийн даацыг тохируулан ашиглах, тухайн бүс нутгийн ан амьтныг усны дутагдлаас хамгаалах.

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ

- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн 2018.03.15 ны өдрийн № 06, 2018.07.04 ний өдрийн № 11, 2019.01.24-ний өдрийн № 02 тус тус тогтоолоор “Чандмань эрдэнэ” төслийг санхүүжүүлэхээр дэмжиж төслийн санхүүжилтийг батлав
- Захиалагч аймгийн ЗДТГ төслийн гүйцэтгэгчдийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Болор ус” ХХК, “Загийн худаг” ХХК, “Хишиг юниверс” ХХК, “Баян динозавр” ХХК-тай санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” санхүүжилтийн гэрээг тус тус байгуулан төслийг хэрэгжүүлсэн.
- Ханбогд, Манлай, Баян-Овоо, Цогт-Овоо сумын нутагт 84,5 мянган га бэлчээрийг шинээр усжуулж, 125 мянган га бэлчээрийг сэргээн усжуулсан
- Төслийн үр дүнд 37 худаг шинээр гаргаж, 40 худаг сэргээн засварласан
- 1466 малчин өрхийн 5000 гаруй иргэд, 622000 мянган мал сүрэг төслийн үр шимийг хүртэнэ

»» ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ

2018 онд:

“Болор ус” ХХК нь Өмнөговь аймгийн зүүн бүсийн сумд болох Баян-Овоо, Манлай, Ханбогд сумдын нутагт ан амьтанд зориулсан инженерийн хийцтэй 3 ширхэг худаг шинээр гаргах, Баян-Овоо, Манлай, Ханбогд, Цогт-Овоо сумдын нутаг дэвсгэрт инженерийн хийцтэй 4 ширхэг худгийг сэргээн засварлаж ашиглалтанд шилжүүлж байна.

“Загийн худаг” ХХК нь Ханбогд, Баян-Овоо, Манлай, Цогт-Овоо сумдын нутагт тус бүр 5 ширхэг буюу нийт 20 ширхэг энгийн худаг шинээр гаргах, мөн тус сумдын нутагт тус бүр 10 ширхэг буюу нийт 40 ширхэг худаг сэргээн засварлаж ашиглалтанд шилжүүлж байна.

2019 онд:

Хишиг-Юниверс ХХК нь Ханбогд, Манлай, Баян-Овоо, Цогт-овоо сумдын 7 багийн 10500 га орчим бэлчээрийг хамарсан усан хангамжийн дутагдалтай, уст цэгээс алслагдсан бэлчээрийн нутагт инженерийн хийцтэй бэлчээрийн худаг 9, ан амьтанд зориулсан нэг худаг шинээр гаргаж ашиглалтанд шилжүүлсэн.

Баян динозавр ХХК нь Өмнөговь аймгийн ЗДТГ-т “Чандмань эрдэнэ” төслийн хүрээнд худаг гаргах болон сэргээн засварлах зориулалттай гидравлик экскаватор, карго кран тус бүр нэг ширхэгийг нийлүүлсэн.

БУГЫН ХУДАГ ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	"БАЯНГОВЬ УС" ХХК
БАТЛАГДСАН ТӨСӨВ:	20,000,000 ТӨГРӨГ
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	20,000,000 ТӨГРӨГ

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Гурван сайхан уул нь нэн ховордсон олон зүйлийн ургамал, ан амьтнаар баялаг, чулуулгийн өвөрмөц тогтоц бүхий газар нутаг юм. Анх 2008 онд Гурван сайхан ууланд нэгэн согоо өөрөө ирж нутагшсан байна. Үүний дараа аймаг орон нутгийн хүсэлтээр Өмнөговь аймгийн унаган иргэн, Хустайн нурууны байгалийн цогцолборт газрын захирал доктор Н.Банди, МУИС-ийн доктор, багш Суран нар буга нутагшуулах төслийн судалгааг хийж Гурван сайхан ууланд халиун буга нутагших бүрэн боломжтой гэж тогтоосноор 2016 онд Баруун сайхан ууланд 10 бугын нутагшуулсан бөгөөд одоогоор 16-17 тоо толгой болж өссөн судалгаа байна. Хур тунадас багатай жил болон цас багатай хаврын улиралд бугын бэлчээрт усны хангамжыг шийдвэрлэх шаардлага гарсан.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Булган сумын Хавцгайт багийн нутаг дахь 20 буганд ан амьтанд зориулсан худаг гаргаж бэлчээрийн усжуулалтыг сайжруулна.

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-гийн 2019 оны 06 дугаар сарын 26-ы өдрийн 07 тогтоолоор Бугын худаг төслийг санхүүжүүлэхээр дэмжиж төслийн санхүүжилтийг батлав
- Захиалагч аймгийн ЗДТГ гүйцэтгэгчийн сонгон шалгаруулж гэрээ байгуулсны дагуу захиалагч аймгийн ЗДТГ, гүйцэтгэгч “Баянговь ус” ХХК-тай санхүүжүүлэгч “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” гэрээ байгуулснаар барилга угсралтын ажлыг эхлүүлэв.
- Улсын тусгай хамгаалалтын бүс нутаг болох Баруун сайхан уулан дахь онцгой хамгаалалтын бүсэд /25км*9км/ ан амьтанд зориулсан нарны энергээр ажиллах худагтай болсон
- Ан амьтны ундны усны хангамжийг сайжруулнаар тэдний амьдрах таатай нөхцөл, өсөлт үржилтэнд нөлөөлж улмаар байгаль орчны экологийн тэнцвэрт байдалд эерэгээр нөлөөлнө

»» ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Булган Хавцгайт багийн нутаг дахь 20 буганд ан амьтанд зориулсан нарны энергийн эх үүсвэрээр ажилладаг худаг гаргаж /худгийн цооног өрөмдөх, тоноглох, худгийн байшин, усан сан, буга услах онгоц/ ашиглалтанд хүлээлгэж өгсөн.

“МАЛ УГААЛГА, ХАШАА ХОРООНЫ АРИУТГАЛ-2019” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР
БАТЛАГДСАН ТӨСӨВ:	814,918,579 ТӨГРӨГ
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	796,337,999 ТӨГРӨГ

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Өмнөговь аймаг 2018 оны жилийн эцсийн байдлаар 15 сум 59 багт 5951 өрхийн 5551 хашаа хороо, 2,3 сая бог мал тоолуулсан. 2016 онд Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн санхүүжилтээр хэрэгжсэн “Ариутгал-2016” төслийн хүрээнд 15 сумын 51 багийн 5417 өрхийн 4617 өвөлжөө, хаваржааг ариутган халдаргүйжүүлсний үр дүнд 2016-2017 онуудад паразит өвчлөлийн гаралт 2 дахин буурсан. Гэвч 2018 оноос малын өвчлөлийн тоо буцан нэмэгдэж нийт мал сүргийн 70%-80%-д паразит өвчин түүний дотроос эктопаразит /хүрд, ширх, бэлчээрийн хачиг, хамуу, гуур/ зэрэг өвчлөл гарч, малын хорогдлын 70%-80%-ийг паразит эзэлсээр байсан. Өмнөговь аймгаас 2019 оныг Хөдөө аж ахуй, үйлдвэржилтийг дэмжих жил болгон зарлан төслийн саналыг боловсруулан ирүүлсэн.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Хөтөлбөрийн үндсэн зорилго нь мал сүргийг паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх арга хэмжээний салшгүй чухал хэсэг болох мал угаалга, хашаа хорооны ариутгал, халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг үе шаттай

хэрэгжүүлэн хүн амын нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, малын гаралтай хүнсний аюулгүй байдлыг хангах, малын ашиг шимийг нэмэгдүүлэх, малчид, иргэдэд хүрч үйлчлэх, мал эмнэлгийн чанар хүртээмжийг дээшлүүлэхэд оршино.

»» ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

Малын шимэгч хорхойн өвчин үүсгэгч устгах, өвчний дэгдэлт эрс буурах, малаас авах ашиг шим нэмэгдэх, түүхий эдийн чанар сайжрах, малчдын орлого нэмэгдэх, хүн амын хүнсний аюулгүй байдал, нийгмийн эрүүл мэнд, эдийн засагт эерэгээр нөлөөлөх зэрэг үр дүн гарна.

»» ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Өмнөговь аймгийн 15 сумын 5951 малчин айл өрхийн 5473 хашаа хороог ариутгаж, 2,578,455 толгой бог малыг угааж сум бүрт мал угаалгын суурин ванн /21ванн/ барьж ашиглалтанд хүлээлгэж өгсөн.

“ОЮУ ХҮЛЭМЖ-2” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	МӨНХ НОГООН ТАЛ ХХК
БАТЛАГДСАН ТӨСӨВ:	300,951,000 ТӨГРӨГ
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	290,775,305 ТӨГРӨГ

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Хүлэмжийн аж ахуй эрхлэх замаар хэрэглэгчдийн хэрэгцээнд нийцсэн экологийн цэвэр, шинэ ургацын ногоог зах зээлд нийлүүлж, аймгийн тариалан эрхлэгчдийн өрхийн орлогыг нэмэгдүүлж, ажлын байр шинээр бий болгох, хүн амын хүнсний ногооны хэрэгцээт хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 2016 онд Говийн оюу ХДС-ийн санхүүжилтээр “Оюу хүлэмж” төслийг хэрэгжүүлэн ажилласан ба 2017 онд 50, 2018 онд 23, 2019 онд 10, нийт 83 хүлэмжийг орон нутгийн газар тариалан эрхлэгч иргэн аж ахуй нэгжид 60 хувийн хөнгөлөлттэй үнээр олгож, урьд оны төлөлтийн 40 хувиар дараа оны хүлэмжийн санхүүжилт болгон хэрэгжүүлж байна. 2015 онд Өмнөговь аймгийн хэмжээнд 195 хүлэмжийн 15883 м.кв талбайд тариалалт хийсэн ба 2016 онд “Оюу хүлэмж” төсөл хэрэгжсэнээр 2018 оны эцэст 296 хүлэмжийн 25415 м.кв талбайд тариалалт хийснээр 0,9 га талбайгаар хамгаалагдсан хөрсний талбайн хэмжээ нэмэгдсэн дүнтэй байна. Орон нутгийн газар тариалан эрхлэгч өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин газар тариалангийн эрчимжилтийг хангах зайлшгүй нөхцөл шаардлагатай байна.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Хөтөлбөрийн үндсэн зорилго нь орон нутагт хамгаалагдсан хөрсний тариалалтыг хөгжүүлэх бодлогын хүрээнд газар тариалан эрхлэгчид болон өрхийн үйлдвэрлэгчдийг дэмжихэд оршино.


»» ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

Хүлэмжийн тариалан эрхлэх замаар хэрэглэгчдийн хэрэгцээнд нийцсэн экологийн цэвэр, шинэ ургацын ногоог зах зээлд нийлүүлж, аймгийн тариалан эрхлэгчдийн өрхийн орлогыг нэмэгдүүлж, ажлын байр шинээр бий болгох зэрэг үр дүн гарна.

»» ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Өмнөговь аймгийн ЗДТГ-т 97 ширхэг нийлэг хальсан хүлэмж нийлүүлнэ.

СОЁЛЫН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ
БАТЛАГДСАН ТӨСӨВ:	73,840,000 ТӨГРӨГ

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Өмнөговь аймгаас 2019 оныг “Соёлыг дэмжих жил” болгон зарлан, тус чиглэлээр төлөвлөсөн ажил, арга хэмжээ, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд аймгийн ЗДТГ, соёлын салбарын мэргэжлийн байгууллага, агентлаг, төрийн бус байгууллагууд хамтран ажиллаж хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийг санаачилсан.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Хөтөлбөрийн үндсэн зорилго нь дээр дурдсан бага хурлыг хийснээр үндэсний түүх соёл, аялал жуулчлалын чиглэлээр урт хугацааны тогтвортой хөгжил, төрийн бодлого, төлөвлөгөөний талаар Хамтын ажиллагааны гэрээний Хавсралт 7-д заасан Талуудын баримталж байгаа нэгдсэн алсын харааг дэмжин ажиллахад оршино.

»» ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

Соёлын биет болон биет бус өвийг сэргээх, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, залуу хойч үед өвлүүлэх, үндэсний уламжлалт урлагаа хадгалах, хөгжүүлэх зэрэг олон үр дүн гарах юм.

»» ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

- ✓ Батмөнх даян хааныг алдаршуулах:
 - Батмөнх даян цэцэн хаан- эрдэм шинжилгээ, судалгаа сэдэвт бага хурал зохион байгуулсан /Гэрээний дүн- 6,4 сая төгрөг, Хэрэгжүүлэгч: Монголын баг, сумдын үндэсний холбооны Өмнөговь аймаг дахь салбар/

- Өмнөговь хаадуудын мөрөөр ном бүтээсэн /Гэрээний дүн-5,0 сая төгрөг, Хэрэгжүүлэгч: “Өвт говь” ТББ/
- Даян хааны харъяат зургаан түмэн Монголын магтаал туурвиж байна. /Гэрээний дүн-12,4 сая төгрөг, Гүйцэтгэгч: Говь гурван сайхан уран бүтээлчдийн холбоо ТББ, Батмөнх даян хааны үеийн Монголыг магтан дуулсан 5 минутын клип хийнэ/
- ✓ Ботгон тэшээ бүжгийн баг, хувцас хийх
 - Ботгоны дээл -30ш, хүүхдийн дээл-30 ш хийнэ. /Гэрээний дүн-4.5 сая төгрөг, Гүйцэтгэгч: Говь хангайн андууд ХХК/
- ✓ Цамын хувцас багийг иж бүрэн хийх
 - Гомбо бурхан 4 дагуултай нь, Цагаан өвгөн 4 хүүхэдтэй нь нийт 10 ширхэг / баг, дээл, гутал/ цамын бүжгийн хувцас хийж байна. /Гэрээний дүн- 30,0 сая төгрөг, Гүйцэтгэгч: Өмнөговь цам сан/
- ✓ Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын баримтат, хөрөг нэвтрүүлэг хийнэ /Батлагдсан дүн-20,0 сая төгрөг/

САНХҮҮЖИЛТИЙН КВОТ-2019

»» САНХҮҮЖИЛТИЙН КВОТ, ЗОРИЛГО

Тогтвортой хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдэд олгох жилийн нийт санхүүжилтийн тодорхой хэсгийг Түншлэгч болон уул уурхайгүй сумдад (хамтад нь “Зорилтот сумд” гэх) квот тогтоон хуваарилах замаар сумдын удирдлага, иргэдийн оролцоонд тулгуурлан тэдгээр сумдын болон Өмнөговь аймгийн нийгмийн эмзэг бүлэг болон гишүүдийг, тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настнууд, тусгай дэмжлэг шаардлагатай хүмүүсийн амьдрал ахуй, биеийн эрүүл мэнд болон эдийн засгийн сайн сайхан байдлыг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдэд зарцуулах, хуваарилахыг эрмэлзэнэ.

Тухайн жилд Түншлэгч болон уул уурхайгүй сумдад дээрх зорилгоор хуваарилах санхүүгийн дэмжлэгийн хэмжээг дараах байдлаар тогтооно:

- Ханбогд сум 70,000 ам.доллартай тэнцэх төгрөг буюу 179,819,500 ₮
- Манлай, Баян-Овоо, Даланзадгад сумд 50,000 ам.доллартой тэнцэх төгрөг буюу 128,442,500 ₮
- Уул уурхайгүй сумд тус бүр 30,000 ам.доллартай тэнцэх төгрөг буюу 77,065,500 ₮

№	Зорилтот сумын нэр	Өмнөх онд зарцуулаагүй үлдэгдэл санхүүжилт	2019 онд ХДС-аас хуваарилсан санхүүжилт	2019 онд нийт хуваарилах боломжтой санхүүжилт	Зарцуулсан санхүүжилт	Үлдэгдэл санхүүжилт
1	Ханбогд сум	494,146	179,819,500	180,919,646	169,638,865	10,674,781
2	Манлай	339,165	128,442,500	128,781,665	122,186,125	6,595,540
3	Баян-Овоо	26,362,825	128,442,500	154,805,325	134,610,000	20,195,325
4	Даланзадгад	68,383,500	128,442,500	196,826,000	174,965,500	21,860,500
5	Баяндалай	-	77,065,500	77,065,500	76,439,983	625,517
6	Сэврэй	77,600	77,065,500	77,143,100	76,768,000	375,100
7	Булган	5,299,361	77,065,500	82,364,861	73,100,416	9,264,445
8	Номгон	17,600	77,065,500	77,083,100	71,350,000	5,733,100
9	Цогт-Овоо	1,815,510	77,065,500	78,881,010	62,835,595	16,045,415
10	Мандал-Овоо	-	77,065,500	77,065,500	72,741,080	4,324,420

2019 ОНД ХАНБОГД СУМАНД КВОТЫН САНХҮҮЖИЛТЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД:

1. “ЭРҮҮЛ НАСЖИЛТ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ ХАНБОГД СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	ХАНБОГД СУМЫН АХМАДЫН ХОРОО
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	26,157,635 төгрөг

»» ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Ханбогд сумын ахмадын хороо нь 400 гаруй ахмадыг эгнээндээ багтаан тэдний эрх ашиг, нийгмийн баталгааг хангахад тодорхой хувь нэмэр оруулан ажилладаг. Гэвч ахмадуудын насжилттай холбоотой өвчин эмгэг, хөдөлгөөний дутагдал зэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн үйл ажиллагаа явуулах нөхцөл боломж муутай байдаг.

»» ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Эрүүл насжилтыг дэмжих нөхөн сэргээх тусламж үйлчилгээг ахмадуудад онцгойлон үзүүлж тэдний амьдралын чанарыг дээшлүүлэх, идэвхтэй урт удаан наслалт, нийгэм, гэр бүл дэх оролцоог нэмэгдүүлэхэд оршино.

»» ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Иргэдийн эрүүл мэндийг сайжруулахад чиглэсэн 34 ширхэг дасгалын тоног төхөөрөмж, хэрэгсэл нийлүүлж мэргэжлийн эмч туслах ажилтны хамт 6 сарын хугацаанд /нэг сард 3 удаа/ иргэдэд сургалт зохион байгуулсан.

»» ХӨТӨЛБӨРИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Ханбогд сумын Ахмадын хороо нь иргэдийн эрүүл мэндийг сайжруулахад чиглэсэн 34 ширхэг тоног төхөөрөмж, хэрэгслээр хангагдсан.
- Сумын 400 гаруй иргэд, ахмад мэргэжлийн эмчийн заавар зөвлөмжийн дагуу дасгал хөдөлгөөн хийж байна.
- Ахмадууд эрүүл мэндээ сайжруулан чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлж байна.

»» ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн Удирдах зөвлөлийн 2019 оны нэгдүгээр сарын 24-ний өдрийн хурлын 3 тоот тогтоолоор батлагдсан Зорилтот сумдад жил бүр олгох санхүүжилтийн квотын хүрээнд “Эрүүл насжилт” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн
- Ханбогд сумын ЗДТГ нь “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх удирдамж”, “Говийн оюу хөгжлийг дэмжих санд ирүүлсэн саналыг хянан үзэх, үнэлэх, шийдвэр гаргах проткол”-д нийцүүлэн эрэмбэлэх, сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийн шийдвэрээр төслийг сонгон шалгаруулсан
- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь захиалагч Ханбогд сумын ЗДТГ болон хөтөлбөрийн хэрэгжүүлэгч Ханбогд сумын Ахмадын хороотой санхүүжилтийн гэрээ байгуулсан.
- Ханбогд сумын засаг даргын захирамжаар байгуулагдсан ажил хүлээлцэх комиссын шийдвэрээр төслийн ажлыг хүлээж авсан
- Ханбогд сумын Ахмадын хороо нь дасгалын тоног төхөөрөмжүүдээр хангагдан иргэд, ахмадууд мэргэжлийн эмчийн заавар зөвлөмжийн дагуу дасгал хөдөлгөөн хийж эрүүл мэнддээ анхаарах, сайжруулах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх эерэг үзүүлэлтүүд бий болсон.

2. “ТОГ БАРИГЧ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	“СИ АЙ ТИ” ХХК
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	34,900,000 төгрөг

»» ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Сум дундын 50 ортой эмнэлэг нь 2015 онд ашиглалтанд орсон.

Тус эмнэлэг нь сумын албан ёсны бүртгэлтэй 7437 хүн, хөдөлгөөнт 20000 гаруй хүн амд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг. Үүнээс гадна зарим тохиолдолд Манлай, Баян-Овоо мөн Дорноговь аймгийн Хатанбулаг, Мандах зэрэг сумдын иргэдэд үйлчилж байна. Хүн амын нягтаршилт ихсэхийн хэрээр иргэдийн өвчлөл нэмэгдэх, нүүрсний зам, хилийн боомт, нүүрс тээвэрлэлтийн гол дамжин өнгөрөх цэг Цагаан хад баг зэрэг газруудаар машины аваар осол их гарч байна. Рентгений зураг авах яаралтай тохиолдолд Оюу толгой SOS эмнэлэгт ханддаг.

2017 онд эмнэлгийн рентгений өрөөг зоорийн давхартаа шийдэж орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар өрөөний засвар үйлчилгээг бүрэн хийж дуусгасан ба 2019 онд шинэ технологийн рентген аппаратыг суурилуулсан. Дээрх рентген аппаратны хэвийн ажиллах орчин нөхцөлийг хангах, хүчин чадалд нь тохирсон тог баригч суурилуулах шаардлагатай байсан.

»» ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, найдвартай байдлыг сайжруулах

»» ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Ханбогд сумын сум дундын эмнэлэгт 60кВа тог тохируулагчтай тог баригч нийлүүлэн комисст хүлээлгэн өгч ашиглалтын зааварчилгаа өгсөн.

»» ХӨТӨЛБӨРИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Ханбогд сумын суурин 7437 хүн ам, хөдөлгөөнт 20000 хүн ам төслийн үр шимийг хүртэнэ
- Эмнэлгийн үйлчилгээний цахилгааны эх үүсвэрээс шалтгаалсан эрсдэл буурна.
- Осол, бэртлийн зургийг цаг алдалгүй авч, эмчилгээ хийх боломж бүрдсэн
- Өвчтөнд хүлээлгэлгүй үйлчлэх, зөөвөрлөхгүй байх боломж бүрдсэн
- Рентген аппаратаар урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ хийж байна.

»» ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн Удирдах зөвлөлийн 2019 оны нэгдүгээр сарын 24-ний өдрийн хурлын 3 тоот тогтоолоор батлагдсан Зорилтот сумдад жил бүр олгох санхүүжилтийн квотын хүрээнд “Тог баригч” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн
- Ханбогд сумын ЗДТГ нь “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх удирдамж”, “Говийн оюу хөгжлийг дэмжих санд ирүүлсэн саналыг хянан үзэх, үнэлэх, шийдвэр гаргах проткол”-д нийцүүлэн эрэмбэлэх, сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийн шийдвэрээр төслийг сонгон шалгаруулсан
- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь захиалагч Ханбогд сумын ЗДТГ болон төслийн гүйцэтгэгч “Си Ай Ти” ХХК-тай санхүүжилтийн гэрээ байгуулсан.
- Ханбогд сумын засаг даргын захирамжаар байгуулагдсан ажил хүлээлцэх комиссын шийдвэрээр төслийн ажлыг хүлээж авсан
- Гүйцэтгэгч “Си Ай Ти” ХХК нь төслийн гэрээний ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэн комисст хүлээлгэн өгснөөр Өмнөговь аймгийн Ханбогд сумын сум дундын эмнэлэгт цахилгааны эх үүсвэрээс шалтгаалсан эрсдэлгүй болж эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмж дээшлэхэд эерэг дэмжлэг болсон.

3. “ГАЛБЫН ӨГӨӨЖ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	“ГАЛБЫН ӨГӨӨЖ” ХОРШОО
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	20,000,000 төгрөг

»» ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

2012 онд Ханбогд суманд газар тариалангийн жишиг талбайг байгуулах зорилгоор 10 га газрыг тариаланчдад гаргасан. 2016 оноос “Галбын өгөөж” хоршооны 9 өрх уг талбайд хүнсний ногоо тариалж байна. Мөн сумын хэмжээнд нийтдээ 2 хоршооны 40 гаруй өрх хүнсний ногоо тариалдаг бөгөөд тэдний 20 өрх тэтгэврийн насныхан, 10 өрх уул уурхайн нөлөөллийн бүсэд амьдарч байна. Иймд дээрх хүнсний ногоо тариалдаг иргэдэд дэмжлэг өгөх зорилгоор хөтөлбөрийг санаачилсан.

»» ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Ногоочдын өрхийн орлогыг нэмэгдүүлэх, иргэд, аж ахуйн нэгж байгууллагад шинэ, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хүнсний ногоогоор хангах

»» ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Ханбогд сумын “Галбын өгөөж” хоршоонд бүхээгтэй, хүнс тээвэрлэх зориулалтаар тоногдсон хөргүүртэй Киa Бонго-3 автомашин нийлүүлсэн.

»» ХӨТӨЛБӨРИЙН ҮР ӨГӨӨЖ:

Ханбогд сумын төвийн хүнсний ногоо тариалдаг хоёр хоршооны 28-30 өрх, нөлөөллийн бүсийн 8-10 өрхийн тариаланчид хүнсний ногоогоо стандартын шаардлагад нийцсэн хөргүүртэй автомашинаар тээвэрлэн “Оюу толгой” компани болон бусад хэрэглэгчдэд нийлүүлэх боломжтой болсон. Ингэснээр ногоочдын өрхийн орлого нэмэгдэх, иргэд, аж ахуйн нэгж байгууллага шинэ, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хүнсний ногоогоор хангагдах эерэг үзүүлэлтүүд гарсан.

»» ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн Удирдах зөвлөлийн 2019 оны нэгдүгээр сарын 24-ний өдрийн хурлын 3 тоот тогтоолоор батлагдсан Зорилтот сумдад жил бүр олгох санхүүжилтийн квотын хүрээнд “Галбын өгөөж” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн
- Ханбогд сумын ЗДТГ нь “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх удирдамж”, “Говийн оюу хөгжлийг дэмжих санд ирүүлсэн саналыг хянан үзэх, үнэлэх, шийдвэр гаргах проткол”-д нийцүүлэн эрэмбэлэх, сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийн шийдвэрээр төслийг сонгон шалгаруулсан
- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь захиалагч Ханбогд сумын ЗДТГ болон хөтөлбөрийн хэрэгжүүлэгч “Галбын өгөөж” хоршоотой санхүүжилтийн гэрээ байгуулсан
- Ханбогд сумын засаг даргын захирамжаар байгуулагдсан ажил хүлээлцэх комиссын шийдвэрээр хөтөлбөрийн ажлыг хүлээж авсан
- Ханбогд сумын “Галбын өгөөж” хоршоонд бүхээгтэй, хүнс тээвэрлэх зориулалтаар тоногдсон хөргүүртэй “Киа Бонго-3” автомашин нийлүүлэх төслийн гэрээний ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэн комисст хүлээлгэн өгснөөр Өмнөговь аймгийн Ханбогд сумын хүнсний ногоо тариалдаг 36-40 өрхийн орлого нэмэгдэх, иргэд, аж ахуйн нэгж байгууллага шинэ, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хүнсний ногоогоор хангагдах эерэг үзүүлэлтүүд гарч байна.

4. “МОНГОЛ АРДЫН ДУУ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	ИРГЭН Х.АМБАА
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	16,730,000 төгрөг

»» ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Өмнөговь аймаг 2019 оныг “Соёлыг дэмжих жил” болгон зарласан, ирээдүй хойч үе болох хүүхэд, залууст чиглэгдсэн ардын урлагын сургалт, үйл ажиллагаа дутмаг, ардын дуу сонирхогч иргэдийн хүсэлт зэрэгт үндэслэн “Монгол ардын дуу” хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлага гарсан.

»» ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Соёлын биет бус өв болох Монгол ардын уртын болон богино дууг хүүхэд, залуус, сонирхогчдод зааж сурган сурталчилж, мартагдаж байгаа дуунуудыг сэргээн түгээн дэлгэрүүлэх, залуу хойч үед өвлүүлэх зэргээр үндэсний уламжлалт урлагаа хадгалахад хувь нэмрээ оруулах.

»» ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭЖ БҮЙ АЖИЛ:

Ханбогд суманд цэцэрлэг, сургуулийн хүүхэд, ардын дуу сонирхогч иргэд, ардын авьяастнуудыг хамруулан 12 сарын хугацаанд Монгол ардын дууны сургалт зохион байгуулж, сургалтанд хамрагдсан иргэд, хүүхдүүдийг оролцуулан ардын дууны тоглолтыг 6 удаа, Монгол ардын дууны тэмцээн 4 удаа зохион байгуулахаар ажиллаж байна

»» ХӨТӨЛБӨРИЙН ҮР ӨГӨӨЖ:

Соёлын биет бус өв болох Монгол ардын уртын болон богино дууг иргэдэд заах, уралдаан тэмцээн зохион байгуулах зэргээр түгээн дэлгэрүүлж үндэсний уламжлалт урлагаа хадгалахад хувь нэмэр болох юм.

»» ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн Удирдах зөвлөлийн 2019 нэгдүгээр сарын 24-ний өдрийн хурлын 3 тоот тогтоолоор батлагдсан Зорилтот сумдад жил бүр олгох санхүүжилтийн квотын хүрээнд “Монгол ардын дуу” хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.
- Ханбогд сумын ЗДТГ нь “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх удирдамж”, “Говийн оюу хөгжлийг дэмжих санд ирүүлсэн саналыг хянан үзэх, үнэлэх, шийдвэр гаргах проткол”-д нийцүүлэн эрэмбэлэх, сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийн шийдвэрээр төслийг сонгон шалгаруулсан
- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь захиалагч Ханбогд ЗДТГ болон хөтөлбөрийн хэрэгжүүлэгч иргэн Х.Амбаатай санхүүжилтийн гэрээ байгуулсан
- Хэрэгжүүлэгч иргэн Х.Амбаа хөтөлбөрийн гэрээний ажлыг хугацаанд нь чанартай хэрэгжүүлснээр соёлын биет бус өв болох Монгол ардын уртын болон богино дууг иргэдэд заах, уралдаан тэмцээн зохион байгуулах зэргээр түгээн дэлгэрүүлж үндэсний уламжлалт урлагаа хадгалахад хувь нэмэр болох юм.

5. “ӨНӨ МӨНХӨД ӨӨДЛӨН ДЭВЖИХ ӨВ СОЁЛ МИНУ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	ИРГЭН Д.ГАНБАТ
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	30,081,500 төгрөг

»» ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Монголчууд бид эрдэмтэн мэргэд, алдартай уран дархчуудынхаа ур ухаан хөдөлмөр шингэсэн гар урлалын бүтээлүүдийг олон зууны туршид ахуй амьдралдаа хэрэглэж ирсэн ард түмэн билээ. Ханбогд суманд үе дамжсан уран дархчууд, сийлбэрч, үйлчин, барималч зэрэг уран гартан олонтой байсан бөгөөд тэдний ур ухаанаар бүтээгдсэн ахуй болоод гоёл чимэглэлийн эдлэлүүд соёлын үнэт дурсгал болон үлджээ. Гэтэл сүүлийн үед ялангуяа 1990-ээд оноос хойш нутгийн ийм сайхан уламжлал ур хийц цөөрч биет болоод биет бус соёл өв залгамжлал тасарч мартагдаж бүдгэрсээр байгаа тул уг төслийг санаачлан хэрэгжүүлэх болсон.

»» ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Монголын уран дархдын мартагдах дөхсөн өв уламжлал, биет бус өв соёлыг судлах орон нутгийн хэмжээнд залуу хойч үеийнхэнд зааж сургах, өвлүүлэн үлдээх өв соёлыг бүтээгч залуу үеийг бий болгоход оршино.

»» ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭЖ БҮЙ АЖИЛ:

Ханбогд суманд Насан туршийн боловсролын төвийн харьяалалтай гар урлалын төвийг байгуулан сургалтын хэрэглэгдэхүүн, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж, хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргасан иргэдэд 10 сарын хугацаатай үргэлжлэх модон эдлэл, сийлбэр, алт мөнгөний дархан, зээгт наамал зэрэг чиглэлээр ажлын байран дээрх сургалтанд хамруулах, Ханбогд сумын соёлын өв тээгч уран гартнуудын уран бүтээлийг судлах, тэдгээрийн хийц, аргачлалыг хойч үеийн залууст өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх, хөтөлбөрийн хүрээнд хийсэн ажлаар үзэсгэлэн, ном, CD гаргах ажлууд хийгдэж байна.

»»» ХӨТӨЛБӨРИЙН ҮР ӨГӨӨЖ:

Ханбогд суманд техник хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжөөр хангагдсан төвтэй болж гар урлал хийж худалдах замаар өрхийн орлогоо нэмэгдүүлэх сонирхолтой иргэд ажлын байран дээр сурч дадлагажих, сумын соёлын өвийг тээгч уран гартнуудын уран бүтээлийн хийц, аргачлалыг хойч үеийн залууст өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх зэрэг нөлөөтэй.

»»» ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн Удирдах зөвлөлийн 2019 нэгдүгээр сарын 24-ний өдрийн хурлын 3 тоот тогтоолоор батлагдсан Зорилтот сумдад жил бүр олгох санхүүжилтийн квотын хүрээнд “Өнө мөнхөд өөдлөн дэвжих өв соёл мину” хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.
- Ханбогд сумын ЗДТГ нь “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх удирдамж”, “Говийн оюу хөгжлийг дэмжих санд ирүүлсэн саналыг хянан үзэх, үнэлэх, шийдвэр гаргах проткол”-д нийцүүлэн эрэмбэлэх, сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийн шийдвэрээр төслийг сонгон шалгаруулсан
- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь захиалагч Ханбогд сумын ЗДТГ болон хөтөлбөрийн хэрэгжүүлэгч иргэн Д.Ганбаттай санхүүжилтийн гэрээ байгуулсан
- Хэрэгжүүлэгч иргэн Д.Ганбат хөтөлбөрийн гэрээний ажлыг хугацаанд нь чанартай хэрэгжүүлснээр Өмнөговь аймгийн Ханбогд сумын гар урлалын бүтээл хийх сонирхолтой иргэд ажлын байран дээр сурч дадлагажих, өрхийн орлогоо нэмэгдүүлэх, сумын соёлын өвийг тээгч уран гартнуудын уран бүтээлийн хийц, аргачлалыг хойч үеийн залууст өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх зэрэг үзүүлэлтүүд бий болох юм.

6. “ӨВ СОЁЛ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	ИРГЭН Д.ХҮДЭРБАТ
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	21,770,000 төгрөг

»» ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Өмнөговь аймаг 2019 оныг “Соёлыг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан Ханбогд сумын нутаг дахь улс, аймаг, сумын хамгаалалтанд байдаг түүх, соёлын дурсгалт газрын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлж мэдээллийн самбар байрлуулах, Галба музейн үзмэрүүдээр каталоги гаргах, улсын хамгаалалтад байдаг түүх, соёлын дурсгалт газруудыг кадастрын зурагт оруулах, судалгаа, тайлан, мэдээллийг цуглуулах, бүртгэлжүүлэх, хадгалах, гэрээт харуулуудыг урамшуулах зэрэг ажлуудыг хийхээр төслийг санаачилсан.

»» ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Ханбогд сумын нутаг дахь улс, аймаг, сумын хамгаалалтанд байдаг түүх, соёлын дурсгалт газрын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох мэдээллийн сан бий болгох, тэдгээрийн харуул хамгаалалтыг сайжруулах, тэмдэгжүүлэх

»» ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭЖ БҮЙ АЖИЛ:

Ханбогд сумын нутаг дахь улс, аймаг, сумын хамгаалалтанд байдаг түүх, соёлын 54 дурсгалт газрын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлж мэдээллийн сан бий болгох, мэдээллийн самбар байрлуулах, Галба музейн үзмэрүүдээр каталоги гаргах, улсын хамгаалалтад байдаг түүх, соёлын дурсгалт 8 газрыг кадастрын зурагт оруулах суманд нь хүлээлгэж өгөх, тухайн сумын нутагт хийгдсэн түүх соёлын дурсгалт газруудын талаарх судалгаа, тайлан, мэдээллийг цуглуулах, бүртгэлжүүлэх, хадгалах, гэрээт харуулуудыг урамшуулах ажлууд хийгдэж байна.

»» ХӨТӨЛБӨРИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Ханбогд сумын нутаг дахь улс, аймаг, сумын хамгаалалтад байдаг түүх, соёлын 54 дурсгалт газрын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлон тэмдэгжүүлж байна.
- Улсын хамгаалалттай түүх, соёлын дурсгалт 8 газарт кадастрын зураг хийж байна.
- Ханбогд сумын түүх, соёлын дурсгалт газар болон улсын хамгаалалттай түүх, соёлын дурсгалт газрын мэдээллийн сан бий болгож байна
- Түүх, соёлын дурсгалт газруудын харуул хамгаалалтыг сайжруулах ажил хийгдэж байна.
- Ханбогд сумын музейн үзмэрүүдээр каталоги гарган олон нийтэд таниулах ажил хийнэ

»» ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн Удирдах зөвлөлийн 2019 нэгдүгээр сарын 24-ний өдрийн хурлын 3 тоот тогтоолоор батлагдсан Зорилтот сумдад жил бүр олгох санхүүжилтийн квотын хүрээнд “Өв соёл” хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.
- Ханбогд сумын ЗДТГ нь “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх удирдамж”, “Говийн оюу хөгжлийг дэмжих санд ирүүлсэн саналыг хянан үзэх, үнэлэх, шийдвэр гаргах проткол”-д нийцүүлэн эрэмбэлэх, сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийн шийдвэрээр төслийг сонгон шалгаруулсан
- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь захиалагч Ханбогд ЗДТГ болон хөтөлбөрийн хэрэгжүүлэгч иргэн Д.Хүдэрбаттай санхүүжилтийн гэрээ байгуулсан
- Хэрэгжүүлэгч иргэн Д.Хүдэрбат хөтөлбөрийн гэрээний ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэн комисст хүлээлгэн өгснөөр Өмнөговь аймгийн Ханбогд суманд соёлын биет өв болох түүх, соёлын дурсгалт газруудыг хамгаалах, олон нийтэд таниулах, нэгдсэн мэдээллийн сантай болох зэрэг үр дүн гарах юм.

7. “ЗАДГАЙ ТЕАТР” ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	“МӨНХ НОГООН ГАЛБА” ТББ
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	20,000,000 төгрөг

»» ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Ханбогд сумын Жавхлант багийн Дунд гол гэдэг газар Монгол Улсын түүх соёлын өвд бүртгэлтэй Галбын гурван хийдийн нэг Цагаан толгойн хийд байрладаг юм. Тус хийдийн дэргэд “Саран хөхөө” дуурийг тоглуулах зорилгоор 1919 онд VII ноён хутагт Агваанлуvsсандамбийжанцангийн санаачлан бариулсан задгай театрын туурь байдаг. Өмнөговь аймгаас 2019 оныг “Соёлыг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан дээрх Задгай театрын барилгыг сэргээн барих төслийг хэрэгжүүлэх шаардлага гарсан.

»» ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Үндэсний уламжлалт соёлын өвийг сэргээн босгож ард иргэдэд таниулах, хамгаалах, ашиглах, аялал жуулчлалын чиглэлээр хөгжүүлэх зорилготой.

»» ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Говийн оюу хөгжлийг дэмжих сан болон Ханбогд сумын “Мөнх ногоон галба” ТББ хамтран санхүүжүүлж тус сумын Жавхлант багийн Дунд гол гэдэг газарт Задгай театрыг сэргээн барьсан.

»» ХӨТӨЛБӨРИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Үндэсний онцлогтой, устах аюулд орсон соёлын өвийг сэргээх, хамгаалах, олон нийтэд таниулах, уламжлуулах ажил хийгдсэн
- Орон нутгийн аялал жуулчлалын хөгжилд эерэг дэмжлэг болно
- Соёлын арга хэмжээг үндэсний хэв маягт уялдуулан зохион байгуулах боломж бүрдсэн
- Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 15-р зүйлийн 1.6-р заалтын хэрэгжилт хангагдсан

»» ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн Удирдах зөвлөлийн 2019 нэгдүгээр сарын 24-ний өдрийн хурлын 3 тоот тогтоолоор батлагдсан Зорилтот сумдад жил бүр олгох санхүүжилтийн квотын хүрээнд “Задгай театр” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн
- Ханбогд сумын ЗДТГ нь “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх удирдамж”, “Говийн оюу хөгжлийг дэмжих санд ирүүлсэн саналыг хянан үзэх, үнэлэх, шийдвэр гаргах проткол”-д нийцүүлэн эрэмбэлэх, сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийн шийдвэрээр төслийг сонгон шалгаруулсан
- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь захиалагч Ханбогд ЗДТГ болон хөтөлбөрийн хэрэгжүүлэгч “Мөнх ногоон галба” ТББ-тай санхүүжилтийн гэрээ байгуулсан
- Ханбогд сумын засаг даргын захирамжаар байгуулагдсан ажил хүлээлцэх комиссын шийдвэрээр төслийн ажлыг хүлээж авсан
- Хэрэгжүүлэгч “Мөнх ногоон галба” ТББ гэрээний ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэн комисст хүлээлгэн өгснөөр Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дахь үндэсний онцлогтой, устах аюулд орсон соёлын өв болох Задгай театрын барилга сэргээн баригдсан.

2019 ОНД МАНЛАЙ СУМД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ХӨТӨЛБӨР:

1. СУРГАЛТЫН ТАНХИМЫН ФИТНЕСС ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ШИНЭЧЛЭХ ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	МАНЛАЙ СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	МАНЛАЙ СУМЫН ҮНДЭСНИЙ БӨХИЙН ХОЛБОО
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	60,365,000 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Орчин үеийн амьдралын хэв маяг, ажлын байран дахь суугаа орчин зэргээс хамааран иргэдийн 62.4 хувь нь хөдөлгөөний дутагдалд орсон бөгөөд энэ нь зүрх судасны өвчин, чихрийн шижин зэрэг халдварт бус өвчнөөр өвдөх эрсдэлийг нэмэгдүүлж, иргэдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна. Тиймээс сумын иргэдийг идэвхитэй хөдөлгөөнд уриалах, зөв дадал суулгах хэрэгцээ шаардлагад тулгуурлан энэхүү хөтөлбөрийг сонгон хэрэгжүүлсэн.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Нийтийн биеийн тамирыг хөгжүүлж, иргэдийг хөдөлгөөний дутагдал, таргалалт, зүрх судасны өвчлөлөөс урьдчилан сэргийлэх.

»» ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

- Сургалтын танхимд биеийн тамир, бялдаржуулах урлагаар хичээллэх тоног төхөөрөмж хэрэгсэл суурилуулах,
- Сумын спортын төвд бөхийн ногоон дэвжээ суурилуулах

»» ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

60 ам метр сургалтын танхимын тоног төхөөрөмжийг бүрэн шинэчилж 7 хоногийн 7 өдөр сумын иргэдэд тогтмол сургалт явуулж, бие бялдарын зөв хүмүүжил олгох, цаашлаад сум орон нутгаас мэргэжлийн тамирчид бэлтгэн гаргах.

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- 14 нэр төрлийн тоног төхөөрөмж, толь суурилуулж, сургалтын танхимыг тохижуулж ашиглалтанд оруулсан.
- Сумын спортын төвд 300 ам метр дэвжээ суурилуулсан.
- Мэргэжлийн дасгалжуулагч багш уг төвийг ажиллуулан иргэдэд сургалт зөвлөгөө өгч хичээллүүлж байгаа.

2. ЖИНЧИД ИРЛЭЭ ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	МАНЛАЙ СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	"ГОВИЙН ЯРУУ ЭГШИГЛЭН" ХХК
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	10,900,000 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Өмнөговь аймаг нь 2019 оныг “Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлтийг дэмжих жил”, салбарын хүрээнд “Соёл урлагийн салбарыг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан соёлын биет болон биет бус өвийг хойч үедээ өвлүүлэх, хадгалж хамгаалах аяныг эхлүүлээд байна. Энэ аяны хүрээнд Манлай сумын соёлын биет болон биет бус өвийг хадгалан хамгаалах, хойч үедээ таниулах, өвлүүлэх ажлуудыг хийж байна.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Өмнөговь аймгийн Манлай сумын соёлын биет бус өв болох “Жинчид ирлээ” нутгийн ардын дууг шинэчлэн найруулж, дуу бичлэг хийж, дүрсжүүлэх ба говь нутаг, Монгол улсдаа төдийгүй дэлхийд сурталчлах, мөн соёлын биет бус өвийг хадгалан хамгаалах, хойч үедээ таниулах, өвлүүлэн үлдээх зорилготой.

»» ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

- “Жинчид ирлээ” дууг шинэчилсэн найруулгаар дуу бичлэгийн студид бичүүлэх,
- Дууг дүрсжүүлэх, клипжүүлэх
- Олон нийтэд түгээж, таниулах

»» ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

Говь нутгийн ардын дууг нийт ард иргэдэд хүргэх ба ийнхүү соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах, хойч үедээ өвлүүлэн үлдээнэ. Мөн хүүхэд багачуудыг урлагийн сонирхох, ардын дуундаа дуртай болоход нөлөөлөх, цаашлаад говь нутаг, тэмээн сүргээ сурталчлан бүс нутгийн аялал жуулчлалд тодорхой хувь нэмэр оруулна.

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Ардын дууг шинэчлэн найруулан дуу бичлэгийн студид бичүүлсэн.
- Ингэснээр говь нутгийн соёлын нэгэн үнэт өв хамгаалагдсан



3. ЭРҮҮЛ ХҮҮХЭД-2 ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	МАНЛАЙ СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	“ЭРҮҮЛ НАСЖИЛТ” ТББ
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	9,564,000 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Монгол улсын Эрүүл мэндийн яамнаас хүүхдийг эхний 6 сар зөвхөн хөхөөр хооллохыг зөвлөдөг. Хүүхэд 4-6 сартайдаа нэмэлт хоол идэхэд бэлэн болдог бөгөөд энэ үед нь шим тэжээлтэй хоолоор хооллох нь чухал юм. Энэ үед нь хүүхдийг хангалттай хооллохгүй, эсвэл хооллосон ч шим тэжээл багатай бол хүүхдийн өсөлтөнд сөргөөр нөлөөлдөг.

Хүүхдийг эрүүл чийрэг, өсөлтийг дэмжих зорилгоор Манлай суманд 2018 онд “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан”-ийн дэмжлэгээр “Эрүүл хүүхэд” хөтөлбөрийг хэрэгжүүлж сумын төвийн 6 сараас 1 нас хүртэл насны 45 хүүхдийг хамруулсан. Хөтөлбөрт хамрагдсан иргэдийн дунд хэлэлцүүлэг хийж, судалгаа авсан ба хөтөлбөрийн үр дүнд сэтгэл хангалуун байгаа, хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийг хүссэн, саналаа илэрхийлсэн.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Эрүүл хүүхэд хөтөлбөрийн хүрээнд 6 сараас 1 насны хүүхдүүдэд сүү, тарагаар хангаж байсан бол Эрүүл хүүхэд-2 хөтөлбөрийн хүрээнд 6 сараас 1 нас 6 сар хүртэлх хүүхдүүдийг хамруулан зорилготой байна.

»» ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

Манлай сумын хүүхдүүдийг өдрийн 250мл үхрийн сүү, тарагаар хангана.

»» ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Нэмэгдэл хоолонд орж буй хүүхдүүдэд олгож буй сүү, тараг нь хоол тэжээлийн дутагдлаас сэргийлнэ.
- Хүүхдийн өсөлт хэвийн явагдахад дэмжлэг үзүүлнэ.
- Суурь өвчлөлөөс сэргийлэхэд дэм болно.
- Орон нутгийн фермерийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Манлай суманд фермерийн аж ахуй эрхэлж буй иргэдээс үнээний цэвэр сүү авч тараг бүрэн зорилтот насны хүүхдүүдэд нэмэлт хоолны төрлийг нэмэн олгож байна.
- Ингэснээр хүүхдүүд эрүүл чийрэг өсч бойжих нөхцөл бүрдэн зорилтод бүлгийн ээжүүдэд хүүхдээ өсгөхөд дэмжлэг болсон

4. ДОТУУР БАЙР-ТОХИЛОГ ОРЧИН ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	МАНЛАЙ СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	Х.СОДБАЯР
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	15,935,000 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Манлай сумын сургуулийн дотуур байрны хөнжил, гудасны даавуу, орны бүтээлэг цагаан хэрэглэлүүд эдэлгээний хугацаанд шинэчилж солиогүй, одоог хүртэл хэрэглэж байгаа ба хүүхдүүд хэрэглэх боломжгүй болсон тул шинээр солих хэрэгтэй байна. Одоогийн хуучирсан хэрэглэлүүд нь эрүүл ахуйн шаардлага хангахгүй болсон.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Дотуур байрны хүүхдийн цагаан хэрэглэлийг шинэчлэн сайжруулж тав тухтай, гэртээ байгаа мэт орчинг бүрдүүлэх.

»» ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

Сумын дотуур байрны хүүхдүүдийн хэрэглэх цагаан хэрэглэл, хөнжил, орны бүтээлэг нийлүүлнэ.

»» ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Хүүхдийн амьдрах, амрах, тав тухтай эрүүл орчин бүрдэнэ.
- Хүүхдийн эрүүл ахуйн шаардлага хангагдана
- Дотуур байрны тохижилт, өнгө үзэмж сайжирна
- Халдварт өвчнөөс сэргийлнэ
- Дотуур байранд амьдрах хүүхдийн тоо нэмэгдэнэ
- Тав тухтай орчин бүрдэж байвал хүүхдийн сурлагад эергээр нөлөөлнө.

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Хөнжлийн углаа даавуу, гудасны углаа даавуу тус бүр 130 ширхгийг нийлүүлсэн.
- Хөнжил, орны бүтээлэг тус бүр 65 ширхгийг нийлүүлсэн.
- Дотуур байранд амьдарч буй хүүхдүүдийн тав тухтай байх орчин бүрдсэн.

5. ХӨРГҮҮРТЭЙ МАШИН ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	МАНЛАЙ СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	Б.БУЖИДМАА
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	19,000,000 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Өмнөговь аймгийн Манлай суманд газар тариалан эрхэлдэг иргэн, аж ахуй нэгжүүдийн тарьж ургуулсан хүнсний ногоо, жимсийг чанар стандартын шаардлагын дагуу зориулалтын хөргүүртэй авто машинаар сумын ард иргэд болон зэргэлдээх сумдын хэрэглэгчид, уул уурхайнуудад хүргэж үйлчлэхээс гадна иргэдийг хүнсний ногоо тариалалд сургах, энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэх боломжоор хангахад энэхүү хөтөлбөр дэмжлэг үзүүлэх юм.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

- Тариалан эрхлэх сонирхолтой болон тэтгэврийн насны иргэдийг ажлын байраар хангах, тэдний орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх,
- Сум орон нутагтаа борлуулалт хийж сумын иргэдийг эрүүл хүнсээр хангах

»» ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

- Зориулалтын хөргүүртэй чингэлэгтэй автомашин худалдан авах
- Зуны хүлэмж авах

»» ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Газар тариалан эрхэлдэг өрх, аж ахуй нэгжүүдийн амжиргааны түвшин нэмэгдэж, сумын иргэд эрүүл хүнсээр хангагдана.
- Орон нутагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний тоо нэмэгдэж бусад сум, уул уурхайнуудад бүтээгдэхүүн нийлүүлнэ.
- Ажлын байр нэмэгдэнэ.

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Бонго 3 загварын хөргүүртэй автомашин авсан.
- Шинээр 1 ажлын байр бий болсон.
- Орон нутгийн ногоочид ургуулсан хүнсний ногоогоо хугацаа алдахгүйгээр зах зээлд чанарын шаардлага хангасан тээвэрлэлтээр нийлүүлснээр тэдний орлого нэмэгдэх боломж бүрдсэн.

2019 ОНД БАЯН-ОВОО СУМД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ХӨТӨЛБӨР:

1. ДЭН УС ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	БАЯН-ОВОО СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	ГОВИЙН ГУРВАН БАГ ХОРШОО
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	35,000,000 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Баян-Овоо сумын иргэдийн ахуйн хэрэглээндээ ашигладаг ус нь хатуулаг ихтэй, эрдэстэй байдаг учир ундны усны хэрэглээнд зохимжгүй, удаан хугацаанд хэрэглэснээр эрүүл мэндэд эрсдэл учруулж болзошгүй. Тиймээс сумын иргэдийг цэвэршүүлэн шүүсэн усаар хангаснаар дээрх эрсдэлээс урьдчилан сэргийлэх юм.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Баян-Овоо сумын иргэдийн хэрэгцээнд нийцүүлэн газрын гүний усыг тусгай шүүлтүүрээр шүүж савлан сумын иргэдэд нийлүүлэх юм.

»» ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

Сумын тариалангийн талбайд байрлах гүний усны цооногийг түшиглэн цэвэр усны үйлдвэр байгуулан усыг цэвэршүүлэн савласан цэвэр ус үйлдвэрлэнэ.

»» ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Сумын 606 өрхийн 1758 иргэн ундны цэвэршүүлсэн усаар хангагдана.
- Цэвэр усны үйлдвэр байгуулагдсанаар орон нутаг дахь хоршооны бааз бэхжиж, үйлдвэрлэл эрхлэх боломжоор хангагдана.

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Баян-Овоо сумын ногооны талбайн гүний усны цооногт түшиглэн цэвэр усны үйлдвэр байгуулсан. Уг үйлдвэр нь цагт 1 тонн усыг цэвэршүүлэх хүчин чадалтай. Цэвэршүүлсэн усаа 19 литрийн савалгаатайгаар үйлдвэрлэж байна.
- 1 ажлын байр шинээр бий болсон.
- Сумандаа үйлдвэрлэх шинэ бүтээгдэхүүнтэй болсон.

2. ГАМШИГ ОСЛЫН ҮЕИЙН БЭЛЭН БАЙДАЛ ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	БАЯН-ОВОО СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	"ДАРХАН ТӨГӨЛДӨР ГОВЬ" ХХК
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	16,980,000 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Сүүлийн жилүүдэд Баян-Овоо сумын хэмжээнд цасан шуурга, ган, зуд, шороон шуурга, үер, зуд, ган тохиож байна. 2018 онд говийн бүс нутаг болон Баян-Овоо сумын хэмжээнд аадар бороо асар их орж үер усны аюул удаа дараа нөмөрч, мөн хүчтэй цасан болон шороон шуурга 3 удаа, объектын болон ахуйн гал түймэр 2 удаа тус тус болсон. Дээрх гамшгийн улмаас 1 хүн төөрч осгон эрсдэж, 500 орчим мал хорогдож, 30 орчим сая төгрөгийн эд материалын хохирол учирсан. Гал усны ямар ч гамшиг тохиолдоход гамшгийн үеийн авран хайх, эрэл хайгуулын арга хэмжээг зохион байгуулах, унтраах хор хохиролыг багасгахад техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангамж хамгаас чухал байдаг. Сумын иргэдэд төрийн болон нийтийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудыг гал унтраах багаж хэрэгслээр хангах нь энэхүү зорилтын нэг хэсэг юм.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Баян-Овоо сумын хэмжээнд тохиолдож болзошгүй гамшиг осол, онцгой байдлын үед гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах үйл ажиллагаанд шаардлагатай техник, хэрэгслээр сумын Онцгой байдлын комиссыг хангахад оршино.

»» ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

Гамшиг ослын үед хэрэглэгдэх багаж хэрэгсэл, онцгой байдлын үеийн бэлэн байдлыг хангах хэрэглэгдэхүүнийг нийлүүлэх, байрлуулах.

»» ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Гамшиг ослын үед ажиллах бэлэн байдал хангагдана. Хор хохирлыг шуурхай бууруулахад ахиц гарна.
- Сумын нийт 1800 орчим иргэд учирч болзошгүй гамшиг ослоос сэргийлэх, хор хохирлыг шуурхай бууруулах, эрсдэл багатай даван туулах боломжоор хангагдана.

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Камер, дрон, галын хор, галын хөнжил, анхны тусламжийн эмийн сан зэрэг 5 нэр төрлийн 37 ширхэг хэрэгслийг онцгой байдлын газарт хүлээлгэн өгсөн.
- Албан байгууллага бүрт галын хор байрлуулсан.
- Ингэснээр иргэдийн амь нас, эрүүл мэнд, нийтийн болон иргэд, байгууллагын өмч хөрөнгийг гал түймрийн аюул эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх бодит хэрэгсэл болж, энэ төрлийн аюул учирсан үед хохирол багатай даван туулах боломж бүрдсэн.

3. ГОВИЙН ӨВ ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	БАЯН-ОВОО СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	"ТЭРГҮҮН СУВАРГА" ХХК
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	30,000,000 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Баян-Овоо сумын музейг үйлчлүүлэгчдийн сонирхолд нийлүүлэн орчин үеийн стандарт шаардлагад нийцүүлэх, соёлын биет өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах, олны хүртээл болгох шаардлагатай байна. Үүний үр дүнд иргэдийн хувийн цуглуулгад байгаа тусгай арчилгаа, орчин шаардах үзмэрийг зориулалтын хоргод байршуулснаар тухайн үзмэрийг олны хүртээл болгох, хамгаалах боломж бүрдэх юм.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Баян-Овоо сумын харьяат, соёлын гавъяат зүтгэлтэн А.Ганбаатар агсны нэрэмжит орон нутаг судлах музейг баяжуулж, үзмэрийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж, соёлын биет өвийг нутгийн хүүхэд залуучууд болон иргэдэд сурталчилах, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилготой.

»» ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

- Орон нутаг судлах музейг тохижуулах
- Үзмэрийн тоог нэмэх
- Санд хадгалагдаж байгаа үзмэрийг олон нийтийн хүртээл болгох

»» ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Стандартын шаардлага хангасан тоног төхөөрөмжөөр хангагдана.
- Соёлын биет өвийн хадгалалт хамгаалалт сайжирна.
- Үзмэрийг тоо нэмэгдэнэ.
- Орон нутаг судлах музейгээр үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэнэ.
- Музейг орчин үеийн стандарт шаардлагын дагуу тохижуулна.

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Үзмэр байрлуулах, гэрэлтүүлэг бүхий 14 ширхэг шилэн хорготой болсон
- Уламжлалт хэлхээ тоонотой гэрийн загварын байршуулж, залуу үедээ сурталчилж байна.
- Музейн үзмэрийн хадгалалт хамгаалалт сайжирсан.

4. ШИНЭ СОНГОЛТ ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	БАЯН-ОВОО СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	Ц.БЯМБАЖАВ
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	31,630,000 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Мэдээлэл технологийн салбар эрчимтэй хөгжиж буй өнөө үед мэдээллийн технологи хичээлийн сургалтын чанарыг дээшлүүлэхэд зайлшгүй хэрэгцээтэй тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангагдсан, суралцах таатай нөхцөлийг бүрдүүлсэн сургалтын орчинг бий болгох асар чухал. Ингэвэл сурагчдын идэвхийг сайжрах давуу талтай юм.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Сурагчдын сурч хөгжих таатай боломж нөхцөлийг бүрдүүлэх, мэдээлэл технологийн шинэчлэл, орчин үеийн технологиос суралцах, сурагчдын бие даан хөгжих боломжийг бүрдүүлж тэдний бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх.

»» ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

Мэдээлэл зүйн кабинетийг бүрэн тохижуулах

»» ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Мэдээл зүйн хичээлийн сургалтын орчин сайжирна.
- Хүүхэд хөгжих боломж бүрдэнэ.
- Мэдээллийн технологийн хөгжилтэй зэрэгцэн хөгжих боломж бүрдэнэ.
- Мэдээлэл зүйн сургалтын стандартыг 80-90 хувьд хүргэнэ.
- Багш нарын ажиллах орчин сайжирна, интернэтийн орчинд ажиллах боломж бүрдэнэ.

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Багш, сурагчдын сургалтанд хэрэглэх 15 суурин компьютер, чихэвч, тог баригч, компьютерийн ширээ сандал нийлүүлж кабинетийг тохижуулсан.
- Мөн сургалтад ашиглагдах дэлгэц болон бусад хэрэгслүүдийг байрлуулсан.
- Ингэснээр багш сурагчид орчин үеийн сургалтын стандартад нийцсэн техник хэрэгсэл бүхий сургалтын орчинд хичээллэх бололцоо бүрдсэн.

5. “ӨВ ЭРДЭНЭ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	БАЯН-ОВОО СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	Ч.АМАРТҮВШИН
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	15,000,000 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Монгол Улсад орчин цагийн угсаатны зүйн шинжлэх ухаан үүсэж хөгжөөд 60 гаруй жилийн түүх уламжлалтай томоохон салбар болон хөгжиж иржээ. Монголын угсаатны зүйн судалгаа бол эрт цагаас уламжлалтай, дотоодын төдийгүй олон улсын эрдэмтэн судлаачдын ихэд сонирхдог салбар юм. Монгол Улсын Соёлыг хамгаалах тухай хуулинд “Сум, дүүргийн Засаг дарга соёлыг хамгаалах, эрэн сурвалжлах, бүртгэх, хяналт тавих ажлыг зохион байгуулах” гэж заасан байдаг. Өмнөговь аймаг 2019 оныг “Соёлыг дэмжих жил” болгон зарласантай холбоотойгоор Баян-Овоо сумын нутаг дахь түүх, археологи, угсаатны зүйн холбоотой мэдээллийг цуглуулах, тус сумын Налих, Харзаг багийн малчин иргэдтэй уулзан газар нутгийн тухай мэдээлэл цуглуулах, мэдээллийн сан бүрдүүлэх, улмаар газар нутгийн нэршлийг мартагдахаас сэргийлэх, хойч үедээ өвлүүлэх чухал ач холбогдолтой юм.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Баян-Овоо сумын нутаг дахь түүх, археологи, угсаатны зүйн холбоотой мэдээлэл цуглуулах, шинээр дурсгалт газруудыг олж тогтоох, мэдэгдэж буй дурсгалуудыг очиж шалгах, орон нутгийг судлах музейн сан хөмрөгт хадгалагдаж буй үзмэр, олдворуудыг тайлбаржуулах, сумын түүх, археологи, угсаатны зүйн

системтэй мэдээллийн сан бүрдүүлэх, төрөл бүрийн газрын зураг бэлтгэх, түүх соёлын дурсгалыг хамгаалах, хадгалах талаар зөвлөмж боловсруулж гарын авлага гаргах зорилготой.

»» ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

- Угсаатны зүйтэй холбоотой мэдээлэл цуглуулах, судалгаа хийх
- Мэдээллийн сан, товхимол бүрдүүлэн, хүлээлгэн өгөх

»» ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Түүх археологийн нэгдсэн мэдээллийн сантай болно.
- Орон нутаг судлах музейн үзмэрийг тайлбаржуулах, музейн сан хөмрөгийг баяжуулах
- Сумын түүх соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын талаар төлөвлөгөө, чиглэл бүхий гарын авлага, материал хүлээлгэн өгнө.

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Баян-Овоо сумын Налих, Харзаг багийн малчин иргэдтэй уулзан газар нутгийн нэршлийг тодорхойлж, 200 гаруй нэрийн сан бүрдүүлж цуглуулж, уг газруудыг газрын зурган дээр тэмдэглэх, зэргэлдээ буюу хавь орчинд нь орших уул толгод, гол устай жишин тэмдэглэсэн.
- Орчин цагийн газар усны нэрсийг тодорхойлон сан үүсгэсэн.
- Сумын газар, усны домог, хууч яриаг ахмадуудаар яриулан сан үүсгэсэн.
- Соёлын биет бус өвийг хадгалж, хамгаалах тухай зөвлөмж гаргасан.

6. ТОГЛООМЫН ЭЗЭД ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	БАЯН-ОВОО СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	П.ОЮУ-ЭРДЭНЭ
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	6,000,000 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Сургуулийн өмнөх боловсролын сургалтын модуль нь хүүхдийн төрөлхийн бие бялдар, авъяас чадваруудыг хөгжүүлэх, нийгмийн харилцаанд оролцох, сургуульд суралцах суурийг тавьдаг. Аливаа тоглоомыг сургалтын журамд үндэслэн хийдэг бөгөөд хамгийн жижиг тоглоом хүртэл хүүхдийн аль нэг чадварыг хөгжүүлж байдаг. Сурган хүмүүжүүлэгчдэд хүүхдийн чадварыг хөгжүүлэхэд зориулагдсан тоглоомууд хангалттай байх шаардлагатай. Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын 19-р цэцэрлэгийн бага бүлгийн хүүхдүүдийн сурч хүмүүжих таатай орчинг бүрдүүлэх, тоглоомоор хангах хэрэгцээ байсан. Учир нь цэцэрлэгт байгаа тоглоом нь тухайн бүлгийн хүүхдүүдэд хүрэлцээ муутай, тухайн насны хүүхдийн оюун сэтгэхүйн онцлогт тохирсон тоглоом багатай, ихэвчлэн хуванцар, нийлэг эдээр хийгдсэн тоглоомууд байдаг нь бага насны хүүхдийн эрүүл мэндэд сөрөг үр нөлөөтэй юм.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

19-р цэцэрлэгийн бага бүлгийн элсэн суралцагч хүүхдүүдийг нас насных нь онцлогт тохирсон, оюун ухаан, сэтгэхүйг хөгжүүлэх эко тоглоомоор хангах зорилготой.

»» ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

Цэцэрлэгийн бага бүлгийн хүүхдэд тохирсон бие бялдар, авхаалж самбаа, мэдрэмж хөгжүүлэх, тоо тоолол, дүрс сурах өрж байгуулах, эвлүүлэх зэрэг эко тоглоомоор цэцэрлэгийн ангийг тохижуулна.

»» ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Цэцэрлэгийн бага бүлгийн суралцагчдын сурч боловсрох орчинд байгаа тоглоомыг эко тоглоомоор солино.
- Нас, сэтгэхүйн онцлогт тохирсон тоглоомтой болно.
- Стандартын шаардлага хангаагүй тоглоомоор тоглохоо больсноор эрүүл мэндэд нь эерэг нөлөөтэй.

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Бага бүлгийн хүүхдийн нас, сэтгэхүйд тохирсон эко тоглоом нийлүүлсэн.
- Баян-Овоо сумын цэцэрлэгийн багачуул энэхүү хөтөлбөрийн үр шимээр 64 нэр төрлийн 117 шинэ тоглоом хэрэглэгдэхүүнтэй болсон.

2019 ОНД ДАЛАНЗАДГАД СУМАНД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ХӨТӨЛБӨР:

1. АВТО ЗАМЫН ГЭРЛЭН ДОХИО



ЗАХИАЛАГЧ:	ДАЛАНЗАДГАД СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	“АВТО ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ХӨГЖЛИЙН ГАРЦ” ТББ
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	70,000,000 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Даланзадгад сум 8 баг, 8762 өрх, 26 мянган хүн амтай бөгөөд 9020 тээврийн хэрэгсэл замын хөдөлгөөнд оролцож байна. Сүүлийн жилүүдэд аялал жуулчлал болон уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэн аймгийг чиглэсэн шилжилт хөдөлгөөн эрс нэмэгдэж байна. 2018 оны байдлаар ослын тоо 187 хүрсэн нь замын хөдөлгөөнийг зохицуулсан авто замын уулзварын гэрлэн дохиог шинэчлэх, шинээр тавих шаардлагатай байна.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Явган зорчигч болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилтийг хангаснаар зам тээврийн осол бууруулах зорилготой.

»» ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

Өмнөговь аймгийн бүтээн байгуулалтын жилийн хүрээнд хийсэн замын уулзварын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор замын хөдөлгөөн зохицуулах 4 ширхэг гэрлэн дохиог Даланзадгад сумын Ажнай талбайн баруун тал, Төрийн банкны зүүн талд, Даланзадгад зочид буудлын ар талд байрлах дөрвөн замын уулзварт байрлуулна.

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Хэрэгжиж дууссан бөгөөд Даланзадгад сумын төвд стандартад нийцсэн гэрлэн дохио бүхий дөрвөн замын уулзартай болсон.
- Даланзадгад сумын төвийн дөрвөн замын уулзварын замын хөдөлгөөний аюулгүй байдал хангагдаж иргэдийг осол аваараас урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдсэн.

2. БҮГДЭД ХҮРТЭЭМЖТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ-ДАЛАНЗАДГАД СУМ



ЗАХИАЛАГЧ:	ДАЛАНЗАДГАД СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	"РЕХТУС" ХХК
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	40,000,000 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын тодорхойлолтын дагуу тусгай хэрэгцээт иргэдийн тоонд хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон өндөр настнууд ордог байна. Өмнөговь аймгийн хувьд 65,645 иргэн байгаагаас 2018 оны байдлаар 8.7% -нь 55-аас дээш насны иргэд, мөн 1694 хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна. Тиймээс Өмнөговь аймгийн хувьд тусгай хэрэгцээт 7000 гаруй иргэд байгаа нь Өмнөговь аймгийн нийт иргэдийн 10.8 хувийг эзэлж байгаа юм. Эдгээр иргэд нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцох, боловсрол эзэмшин ажиллахад тулгардаг хамгийн эхний том саад бол барилга байгууламж, зам, нийтийн тээврийн хүртээмжгүй байдал буюу дэд бүтцийн хүртээмжгүй байдал байдаг. Тиймээс төрийн үйлчилгээг илүү хүртээмжтэй болгох шаардлагатай байгаа.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО/ХИЙХ АЖИЛ:

Өмнөговь аймгийн иргэд тэр тусмаа Даланзадгад суманд оршин суудаг 3000 гаруй тусгай хэрэгцээт иргэдийн төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор SA-S загварын шатаар буулгагч төхөөрөмжийг Даланзадгад сумын ЗДТГ-т нийлүүлнэ.

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Өмнөговь аймгийн 55-аас дээш насны 5711 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй 1694 иргэн, нийт 7405 иргэний төрийн үйлчилгээг саадгүй авах боломж бүрдэнэ
- Даланзадгад сумын ЗДТГ-ын эзэмшилд нийтэд хүртээмжтэй SA-S загварын шатаар зөөвөрлөх 1 ширхэг төхөөрөмж нийлүүлсэн

3. ХОГ АЧИГЧ



ЗАХИАЛАГЧ:	ДАЛАНЗАДГАД СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	Ж.БААТАР
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	24,900,000 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Даланзадгад суманд гэр хорооллын 7830 өрх байдаг бөгөөд айл өрхүүд хаягдал хог үнсээ гол төлөв 200 литрийн төмөр саванд хийсэн байдаг. Үүнийг ачихын тулд торхтой хогийг асгаж хүрэдэн ачиж их цаг зав, хүч зарцуулдаг. Сүүлийн үеийн хог хаягдал тээвэрлэх зориулалттай автомашин 10 тн-оос дээш даацтай, газраас 2.1-2.6 метрийн өндөртэй байдаг тул хүрэээр ачихад орчныг бохирдуулдаг. Ялангуяа Өмнөговь аймгийн хувьд салхи ихтэй байдаг тул ачиж буй хогийн 10-25 хувь нь агаарт хийсэж орчныг бохирдуулдаг бөгөөд торхыг газарт нүүлэх нөхцөлд газрын хөрс, шороотой холилдон хог ачих ажиллагааг хүндрүүлдэг. Тиймээс энэхүү бэрхшээлийг багасгаж, хог ачигчдын ажлын нөхцөлийг сайжруулах зайлшгүй шаардлагатай байна.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Даланзадгад сумын хот тохижилтын ажил хийж хог ачиж байгаа ажилчдын ажлын байрны нөхцөлийг сайжруулж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангаж иргэдийн эрүүл, аюулгүй нөхцөлд амьдрах эрх хангагдана.


»» ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

Одоо ашиглагдаж байгаа HUBEI маркийн хог ачигч 5 автомашинд өргөгч суурилуулна.

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Даланзадгад сумын Хотын захирагчийн албанд ажиллаж буй хог ачигч нарын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангагдана.
- Хог ачигч нарын ажлын байрны нөхцөл сайжирч эрүүл мэндэд учирч болох эрсдэл буурна.
- Хог ачигчдын ажлын цаг ашиглалт, бүтээмж сайжирч, Даланзадгад сумын гэр хороололд амьдарч буй 27,000 гаруй иргэдийн амьдрах орчин нөхцөл дээшлэн хоггүй, цэвэр болно.
- Байгаль орчинд сөргөөр нөлөөлж байсан хог хаягдал хийсэх асуудал багасна.

4. СМАРТ ДАЛАНЗАДГАД



ЗАХИАЛАГЧ:	ДАЛАНЗАДГАД СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	“ПИРАМИД КАПИТАЛ” ХХК
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	28,000,000 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Мэдээллийн технологи хөгжиж, иргэд олон нийт мэдээллийг хурдан шуурхай авдаг болсон өнөө цаг үед Даланзадгад сумын ЗДТГ-аас үзүүлж буй төрийн үйлчилгээг иргэд нээлттэйгээр, цаг алдалгүй нь авч чадахгүй байна. Тиймээс иргэдэд төрийн үйлчилгээ, олон нийтийг хамарсан ажлын тухай мэдээ мэдээллийг үнэн зөв, бодитойгоор, хурдан шуурхай хүргэх шаардлага гарч байна.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Даланзадгад сумын ЗДТГ-аас үзүүлэх төрийн үйлчилгээний ил тод байдал, мэдээ мэдээллийн түгээлт, ажил үйлчилгээг иргэдэд илүү хүртээмжтэйгээр хүргэх зорилгоор цахим хуудас, гар утасны аппликэйшн хөгжүүлнэ.

»» ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

iOS болон Android үйлдлийн систем дээр ажиллах аппликэйшн, холбогдох цахим хуудсыг хөгжүүлнэ.

SMART Dalanzadgad app- iOS хөгжүүлэлтийн хувьд /Objective C, SQLite (iOS)/
SMART Dalanzadgad app- Android хөгжүүлэлтийн хувьд /Java, SQLite (Android)/

Веб домайн:

- www.dalanzadgad.om.gov.mn
- www.dalanzadgad.mn
- www.dz.mn

»» **ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:**

- Даланзадгад сумын ЗДТГ-аас үзүүлэх үйлчилгээ, мэдээ мэдээллийг иргэдэд ил тод байдлаар хүргэнэ
- www.dalanzadgad.om.gov.mn цахим хуудсыг google-ийн хайлтын илэрцээр хамгийн дээд хэсэгт байхаар support service үйлчилгээг үзүүлнэ
- Уг хөгжүүлсэн аппликэйшнийг бүх ухаалаг утастай хэрэглэгчид ашиглах бүрэн боломжтой байна

5. ЦАХИМ НОМЫН САН



ЗАХИАЛАГЧ:	ДАЛАНЗАДГАД СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	Н.УРТНАСАН
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	5,380,000 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Даланзадгад сумын 3 дугаар сургуулийн төсвийн хүндрэлээс шалтгаалан номын сангийн орчин нөхцөлийг сайжруулж чаддаггүй байсан. Сургуулийн номын санд цахим үйлчилгээ байхгүйн улмаас сурагчид номыг эрж хайхад ихээхэн хугацаа зарцуулдаг, заримдаа сурагчид хэрэгцээтэй номоо олж уншиж чадахгүй зэрэг бэрхшээл байсан тул номын сангийн үйл ажиллагаанд орчин үеийн технологи нэвтрүүлэх шаардлагатай байсан.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Сургуулийн номын сангийн техник тоног төхөөрөмжийг сайжруулан цахим номын сангийн үйлчилгээг үзүүлж хүүхэд залуучуудыг номтой нөхөрлүүлэн бүтээлчээр хөгжүүлэх, орчин үеийн шаардлагад нийцсэн тав тухтай номын сан бүрдүүлэх зорилготой.

»» ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ/ТӨСӨВ:

Даланзадгад сумын 3 дугаар сургуулийн номын санг номын санд тусгай зориулалтын КОХА программыг суулган дараах техник хэрэгслийг нийлүүлэх:

- Компьютер, 3 үйлдэлт өнгөт принтер
- Принтер /формуляр бар кодны цаас/
- Бар код уншигч, каталог, формуляр бар кодны цаас

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Номын сангийн орчин нөхцөл үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага хангагдсан.
- Сурагчид болон үйлчлүүлэгчдийн цаг хугацааг хэмнэж, хэрэгцээтэй байгаа номыг нь хурдан шуурхай олж өгч үйлчлэх нөхцөл бүрдсэн.
- Номын сангийн орчин нөхцөл сайжирсан
- Төсөл хэрэгжсэнээр 1300 гаруй сурагч, багш ажилчид үр шимийг нь хүртсэн.

6. ӨРХИЙН САНХҮҮ-УЛСЫН САНХҮҮ



ЗАХИАЛАГЧ:	ДАЛАНЗАДГАД СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	Б.АМАРЗАЯА
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	6,685,500 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Өмнөговь аймгийн хувьд 2018 онд хэрэглээний зээл 218.7 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 97.6 хувиар өссөн бөгөөд нийт чанаргүй зээлийн 55.9 хувийг хэрэглээний зээл буюу автомашин, баяр ёслол, сургалтын төлбөр, амьдралын анхан шатны хэрэгцээнд зориулан авч байгаа нь иргэдэд санхүүгийн боловсрол шаардлагатай байгаа, өрхийн санхүүгээ зөв зүйтэй удирдан авч явах чадвар, дадал зуршил дутагдаж байгаагийн нэгэн илрэл билээ. Тиймээс иргэд олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлж, өрхийн санхүүгийн нөхцөл байдалд эерэг өөрчлөлт хийх хэрэгцээ шаардлага байна.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Өмнөговь аймгийн 460 гаруй иргэнд өрхийн санхүүгээ зөв удирдах мэдлэг чадвар олгох сургалт зохион байгуулна.

»» ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

Дараах сэдвээр Даланзадгад сумын 8 багийн нийт иргэд, эмэгтэйчүүд, зорилтот бүлгийн иргэдэд сургалт явуулсан. Үүнд:

- Улс орон болон аймгийн эдийн засгийн нөхцөл байдал, бүтээгдэхүүний үнийн өсөлт ба валютын ханш
- Мөнгөө хэрхэн удирдах вэ?
- Хуримтлал ба зээл, тэтгэвэр
- Өрхийн төсөв, санхүүгийн луйвар, эрсдэлүүд

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Даланзадгад сумын 8 багийн 620 иргэнд сургалт явуулсан
- 473 эмэгтэй, 147 эрэгтэйчүүд хамрагдсан
- Насан туршийн боловсролын төвийн Өмнөговь аймаг дахь салбартай хамтран ажиллаж сургалтуудыг тогтмолжуулахаар тохиролцсон.

2019 ОНД СЭВРЭЙ СУМАНД КВОТЫН САНХҮҮЖИЛТЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД:

1. “АВТОМАШИН НИЙЛҮҮЛЭХ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН СЭВРЭЙ СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	“АРЦ ЭНЕРГИ” ХХК
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	34,950,000 төгрөг

»» ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Сэврэй сумын ерөнхий боловсролын сургуулийн эзэмшилд УАЗ-ФУРГОН автомашин байдаг боловч 2011 онд авснаас хойш моторыг нь 2 удаа, тоормосны аппаратыг 1 удаа, 4 дугуйг 15 удаа сольж, хойд урд тэнхлэг хугарсан зэргээр асар их засвар хийсэн. Мөн сүүлийн 3 жилд сургуулийн автомашин 7 удаа замдаа саатсан тохиолдол гарсан. Уг машиныг авснаас хойш 315,000 км явсан бөгөөд гүйлт нь стандартаас 165,00 км-ээр хэтэрсэн. Тиймээс Сэврэй сумын сургуулийн 206 сурагч, 33 багш, ажилчдын сургалт, олимпиад, уралдаан тэмцээнд оролцоход тохиромжтой найдвартай, эрсдэлгүй үйлчлэх автомашинтай болох шаардлагатай байсан.

»» ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Сургуулийн техникийн нөөцийг сайжруулж жилдээ давхардсан тоогоор 370-420 сурагч, багш ажиллагсад 28 төрлийн аймаг, улсын чанартай тэмцээн уралдаан, үйл ажиллагаанд орохдоо найдвартай, тохилог тээврийн хэрэгслээр зорчдог болох.

»» ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Сэврэй сумын ерөнхий боловсролын сургуульд “Hyundai country” автобус нийлүүлсэн.

»» ХӨТӨЛБӨРИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Сургуулийн захиргааны техникийн нөөц бололцоо сайжирч, автомашинд зарцуулдаг засвар үйлчилгээний зардал буурна.
- Сумын ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчид аймаг, улсын уралдаан тэмцээнд явахдаа найдвартай, эрсдэлгүй, тав тухтай, тохилог автобусаар үйлчлүүлнэ.

»» ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2019 оны нэгдүгээр сарын 24-ний хурлын 3 тоот тогтоолоор батлагдсан Зорилтот сумдад жил бүр олгох санхүүжилтийн квотын хүрээнд “Автомашин нийлүүлэх” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн
- Сэврэй сумын ЗДТГ нь “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх удирдамж”, “Говийн оюу хөгжлийг дэмжих санд ирүүлсэн саналыг хянан үзэх, үнэлэх, шийдвэр гаргах протокол”-д нийцүүлэн эрэмбэлэх, сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийн шийдвэрээр хөтөлбөрийг сонгон шалгаруулсан.
- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь захиалагч Сэврэй сумын ЗДТГ болон хөтөлбөрийн хэрэгжүүлэгч “Арц энерги” ХХК-тай санхүүжилтийн гэрээ байгуулсан.
- Сэврэй сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажил хүлээлцэх комиссын шийдвэрээр хөтөлбөрийн ажлыг хүлээж авсан.
- Хөтөлбөрийн хэрэгжүүлэгч “Арц энерги” ХХК нь автобус нийлүүлэх ажлыг гэрээний хугацаанд чанартай гүйцэтгэн комисст хүлээлгэн өгснөөр Өмнөговь аймгийн Сэврэй сумын ерөнхий боловсролын сургуулийн техникийн нөөц бололцоо сайжирч, автомашинд зарцуулдаг засвар үйлчилгээний зардал буурч байгаа бөгөөд багш, сурагчид аймаг, улсын уралдаан тэмцээнд явахдаа найдвартай, эрсдэлгүй, тав тухтай, тохилог автобусаар үйлчлүүлж байна.

2. “ГАР УРЛАЛЫН ТӨВ БАЙГУУЛАХ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН СЭВРЭЙ СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	“АГЪТ ГОВЬ” ХХК
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	7,773,000 төгрөг

»» ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Сэврэй сум нь нийт 600 орчим өрхийн 2000 гаруй хүн амтай бөгөөд түүнээс 362 малчин өрхийн 1269 иргэнтэй. Тус сумын нийт газар нутгийн 83 хувь нь улсын тусгай хамгаалалтанд байдаг, уул уурхай болон эдийн засгийн бусад салбарууд төдийлөн хөгжөөгүйгээс өрхийн орлогын дийлэнхийг мал аж ахуйгаас олдог. Мөн тус суманд ажлын байр дутагдалтайгаас ажилгүй иргэдийн тоо буурахгүй байна. Иймд орон нутгийн онцлог, иргэдийн өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан өрхийн үйлдвэрлэл эрхлэх, түүнийгээ цаашид өргөжүүлэн хөгжүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлэхэд дэмжлэг шаардлагатай.

»» ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Иргэдийн хүсэл сонирхлын дагуу тэдний авьяас чадварыг хөгжүүлэх, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, ажлын байр шинээр бий болгох зорилгоор гар урлалын төв байгуулан тохижуулах

»» ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Сэврэй сумын соёлын төвийн нэг өрөөнд гар урлалын төвийг байгуулж, 15 нэр төрлийн 35 ширхэг техник хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангаж, эсгий болон арьсан урлалын сургалтуудыг явуулсан.

»» ХӨТӨЛБӨРИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Гар урлалын төвд мэргэжлийн 2 багш урин авчирч 20 иргэнд эсгий, арьсан урлалын сургалт зохион байгуулсан.
- Дээрх сургалтын явцад суралцагсад 130 гаруй бүтээл хийж 320,000 төгрөгөөр борлуулсан.
- Иргэд багаар ажиллаж, хамтран хөгжиж өрхийн орлогоо нэмэгдүүлж байна.

»» ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2019 оны нэгдүгээр сарын 24-ний хурлын 3 тоот тогтоолоор батлагдсан Зорилтот сумдад жил бүр олгох санхүүжилтийн квотын хүрээнд “Гар урлалын төв байгуулах” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.
- Сэврэй сумын ЗДТГ нь “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх удирдамж”, “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-д ирүүлсэн саналыг хянан үзэх, үнэлэх, шийдвэр гаргах проткол”-д нийцүүлэн эрэмбэлэх, сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийн шийдвэрээр хөтөлбөрийг сонгон шалгаруулсан.
- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь захиалагч Сэврэй сумын ЗДТГ болон хөтөлбөрийн хэрэгжүүлэгч “Агьт говь” ХХК-тай санхүүжилтийн гэрээ байгуулсан.
- Сэврэй сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажил хүлээлцэх комиссын шийдвэрээр хөтөлбөрийн ажлыг хүлээж авсан.
- Хөтөлбөрийн хэрэгжүүлэгч “Агьт говь” ХХК нь Гар урлалын төв байгуулах ажлыг гэрээний хугацаанд чанартай гүйцэтгэн комисст хүлээлгэн өгснөөр Өмнөговь аймгийн Сэврэй сумын иргэд өөрийн хүсэл сонирхол, нөөц бололцооны дагуу хүссэн үедээ тус төвийн тоног төхөөрөмжийг ашиглан эсгий, арьсан урлал, зөөлөн оёдлын бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн борлуулах, нэг нэгнээсээ суралцан хамтдаа хөгжих, өрхийн орлогоо нэмэгдүүлэх зэрэг эерэг боломжуудаар хангагдсан.

3. “АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, МЭДЭЭЛЛИЙН ТӨВ ТОХИЖУУЛАХ” ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН СЭВРЭЙ СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	"НАТУРАЛ МОРНИНГ" ХХК
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	34,045,000 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Сэврэй сум нь аялал жуулчлалын бүс нутагт хамаардаг бөгөөд сумын төв нь Өмнөговь аймгийн есөн гайхамшгийн нэг Хонгорын элснээс 25 км-ийн зайд оршдог. Аялагчдын тоо жил ирэх тутам нэмэгдэж байгаа бөгөөд сумын төвөөр дайран өнгөрөхөд нь байрлах байр, буудал байдаггүй, аялагчид жуулчид аялалын маршрут, үйлчилгээ зэрэг мэдээллийг авч чаддаггүй нь нэлээд хүндрэл учруулдаг.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Аялагч, жуулчдад зориулсан мэдээллийн төв, буудлыг тохижуулан нээж тэдний тав тухыг хангах, үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлэх, аялал жуулчлалаас олох орлогын нэмэгдүүлэх

»» ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Төслийн хүрээнд Сэврэй сумын төвд байрлалтай сумын ЗДТГ-ын өмчлөлийн Аялал, жуулчлалын мэдээллийн төвийн барилгын гадна, дотор өнгө үзэмжийг сайжруулах, таван өрөөг буудлын зориулалтаар тохижуулах, барилгын гадна талд мэдээллийн самбар байрлуулах, нэг өрөөг аялагч, жуулчид, иргэдэд мэдээлэл өгдөг өрөө болгон тохижуулах ажлуудыг хийж захиалагчид хүлээлгэн өгсөн.

»» ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Барилгын өнгө үзэмж сайжирсан
- Аялагч, жуулчид тав тухтай орчинд үйлчлүүлж байна
- Нэг ажлын байр шинээр бий болсон

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2019 оны нэгдүгээр сарын 24-ний хурлын 3 тоот тогтоолоор батлагдсан Зорилтот сумдад жил бүр олгох санхүүжилтийн квотын хүрээнд “Аялал жуулчлал, мэдээллийн төв тохижуулах” төслийг хэрэгжүүлсэн
- Сэврэй сумын ЗДТГ нь “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх удирдамж”, “Говийн оюу хөгжлийг дэмжих санд ирүүлсэн саналыг хянан үзэх, үнэлэх, шийдвэр гаргах проткол”-д нийцүүлэн эрэмбэлэх, сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийн шийдвэрээр хөтөлбөрийг сонгон шалгаруулсан.
- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь захиалагч Сэврэй сумын ЗДТГ болон захиалагчийн шалгаруулсан гүйцэтгэгч “Натурал морнинг” компанитай санхүүжилтийн гэрээ байгуулсан.
- Сэврэй сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажил хүлээлцэх комиссын шийдвэрээр төслийн ажлыг хүлээж авсан.
- Гүйцэтгэгч “Натурал морнинг” ХХК төслийн гэрээний ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэн комисст хүлээлгэн өгснөөр Өмнөговь аймгийн Сэврэй сумын төвөөр дайрч өнгөрөх аялагч, жуулчин, иргэд тав тухтай орчин нөхцөлөөр хангагдсан мэдээллийн төв, буудлаар үйлчлүүлэх, суманд нэг ажлын байр шинээр бий болох, аялал жуулчлалаас олох орлого нэмэгдэх зэрэг эерэг боломжууд гарч ирсэн.

2019 ОНД БУЛГАН СУМАНД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ХӨТӨЛБӨР:

1. ТОХИЛОГ ОРЧИН



ЗАХИАЛАГЧ:	БУЛГАН СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	"БАЯНЗАГ ДИНОЗАВР" ХХК
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	33,891,966 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Сумын худалдааны төв орчмын хэсэг нь сумын үйлчилгээний гол газар бөгөөд ард иргэд болон гадна дотноос ирсэн хүмүүс, аялал жуулчлагчид ихээр ирж үйлчилдэг юм.

Сумын төв орчмын газар нь сумын нийтийн эзэмшлийн газар бөгөөд энэ газрын тохижилт өнгө үзэмжинд хувиараа худалдаа эрхэлдэг иргэд өөрийн хөрөнгөөр анхаарч тохижилт хийж чадахгүй байгаа учраас сумын зүгээс анхаарч өнгө үзэмжийг нь дээшлүүлэх шаардлагатай байна.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Сумын худалдааны төв орчмын хэсгийг тохижуулж өнгө үзэмжийг сайжруулснаар ард иргэдийн тав тухтай, соёлтой үйлчлүүлэх орчин бүрдүүлж өнгө үзэмжид нөлөөлнө

»» ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

- Худалдааны төвийн хэсгийн талбайн тохижилтын ажил, самбар, сүүдрэвч тэмдэг тэмдэглэгээ суурилуулах
- Нутгийн түүх соёл, онцлогийг харуулсан зураг зуруулах
- Төмөр рам дээр суурилуулсан гэрэлтдэг үсэг, хаяг, туузан гэрэл суурилуулах
- Камержуулалтын ажил хийх

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Тохижилтын ажлын гүйцэтгэл 95 хувьтай байна. Нутгийн түүх соёл, онцлогийг харуулсан зураг зуруулснаар ажил бүрэн дуусна.
- Ингэснээр Булган сумын төвд ажил үйлчилгээ явуулдаг иргэдийн тав тухтай ажиллах орчин нөхцөл бүрдэж сумын иргэд болон жуулчид стандартын дагуу тохижуулсан газарт үйлчлүүлэх боломжтой болно.

2. ЭРХЭМСЭГ ЗАГВАР



ЗАХИАЛАГЧ:	БУЛГАН СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	“АРЦАТ БАЯН ӨНДӨР” ХХК
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	11,700,000 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Урлаг соёлын үйл ажиллагаа зохион байгуулж концерт, жүжиг, тоглолт тавихад зориулалтын хувцас хэрэглэл зайлшгүй шаардлагатай. Булган сумын соёлын төвийн ажилчдын хувьд урлагийн хувцас авах мөнгө, санхүү дутмаг байгаагаас шалтгаалан зориулалтын хувцас хэрэглэлгүй тул бусад байгууллагаас төлбөртэй хувцас түрээслэн авч өмсөх байдлаар урлаг соёлын үйл ажиллагаанд оролцож байна. Тиймээс хувцас түрээслэх зардлаа багасгаж соёлын төвийн ажилчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах зайлшгүй шаардлагатай байгаа юм.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Уг төслийн хүрээнд Булган сумын соёлын төвийн ажилчдад шаардлагатай хувцас хэрэглэлийг захиалан хийлгэж, улмаар соёлын төвөөр үйлчлүүлж буй сумын иргэд, гадаадын жуулчдад сумын түүх соёлыг сурталчилан таниулах юм.

»» ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

Булган сумын соёлын төвд 104 ширхэг гутал, хувцас хэрэглэл нийлүүлнэ.

№	Хувцас хэрэглэлийн нэр, төрөл	Тоо ширхэг
1	Гоцлол дуучны дээл-эрэгтэй	5
2	Гоцлол дуучны дээл-эмэгтэй	5
3	Бүс-эрэгтэй	5
4	Бүс-эмэгтэй	5
5	Гутал-эрэгтэй	5
6	Гутал-эмэгтэй	5
7	Малгай-эмэгтэй	5
8	Малгай-эрэгтэй	5
9	Пиджак, өмд-эрэгтэй	4
10	Плаж, даашинз, дээл-загварын	4
11	Бүжгийн хувцас-эрэгтэй	5
12	Бүжгийн хувцас-эмэгтэй	5
13	Бүжгийн гутал	10
14	Хантааз эмэгтэй	2
15	Хантааз эрэгтэй	3
16	Хөгжимчний хувцасны ком	4
17	Бусад гоёл чимэглэл	27
	Нийт	104

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Төслийн хүрээнд 104 ширхэг хувцас хэрэглэлийг нийлүүлж Булган сумын соёлын төвийн ажилчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулснаар сумын иргэд болон жуулчид үзвэр үйлчилгээ авч нутгийн урлаг соёлтой танилцаж байна.
- Иргэд олон нийтэд хүргэх урлаг соёлын үйлчилгээний чанар хүртээмж сайжирсан

3. СОЁЛЧ СУМ



ЗАХИАЛАГЧ:	БУЛГАН СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	"БУЛГАН ГҮРТЭН" ХХК
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	27,508,450 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Аймаг, сум, нийслэл гэлтгүй бүх суурин газар тохижилт, үйлчилгээ зайлшгүй шаардлагатай байдаг. Булган сумын хувьд сумынхаа өнгө үзэмжийг сайжруулж, иргэддээ зөв дадал хэвшил суулгах ажил зохион байгуулах шаардлагатай байгаа.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Булган сумын төвийн хэсэгт байрлах албан байгууллагуудын гадаа хогийн сав байрлуулж жишиг гудамж бий болгон иргэдийн амьдрах тав тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилготой.

»» ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

Төслийн хүрээнд Булган сумын төвийн нэг гудамжийг сонгон авч, будаж засч янзлан төвийн хэсгийн албан байгууллагуудын гадна талбайд хог ангилан ялгах зориулалт бүхий 20 хогийн сав байрлуулж, хоггүй цэвэр орчин бий болгох санаачилга хэрэгжүүлсэн.

»» ТӨСЛИЙН ТӨСӨВ:

№	Зардлын нэр	Төсөв ₮
1	Материал	21,208,450
2	Ажиллах хүч	4,600,000
3	Тээвэр	1,700,000
	Нийт	27,508,450

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

Булган сумын төвийн хэсгийн өнгө үзэмж сайжирч иргэд хоггүй цэвэр суманд амьдрах дадал суух нөхцөл бүрдсэн.

2019 ОНД НОМГОН СУМАНД КВОТЫН САНХҮҮЖИЛТЭЭР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ХӨТӨЛБӨР:

1. ХӨВГҮҮДИЙН КАБИНЕТ ТОХИЖУУЛАХ ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:

НОМГОН СУМЫН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

Д.ГАНБОЛД

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

15,000,000 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Дизайн технологийн хичээлд онолын мэдлэгээс гадна дадлага ажлаар практикт суралцах асар чухал байдаг. Ингэснээр ажлын эв дүйд суралцаж, онолын мэдлэгээ ашиглан бүтээл хийх чадвар олж авдаг билээ. Сургуулийн дизайн технологийн кабинетэд шаардлагатай багаж хэрэгсэл дутмагаас дадлага сургалт явагдахад хүндрэлтэй байдаг.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Номгон сумын ерөнхий боловсролын сургуулийн хөвгүүдийн дизайн технологийн кабинетэд сургалт явуулахад шаардлагатай багаж хэрэгслийг нийлүүлж, тохижуулах.

»» ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

Хөвгүүдийн кабинетэд хэрэглэгдэх 65 нэр төрлийн 343 ширхэг цахилгаан болон гар багажыг нийлүүлнэ.


»» ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Сурагчдын ур чадвар сайжирна.
- Тоног төхөөрөмжтэй харьцаж, түүнийг хэрэглэж сурна.
- Мэргэжлийн чиг баримжаа олгоно.
- Сум, орон нутгийн тохижилтод нөлөөлнө.

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

22 нэр төрлийн цахилгаан багаж, 36 нэр төрлийн гар багаж, 7 нэр төрлийн кабинетын тохижилтод шаардлагатай хэрэгслүүдийг нийлүүлсэн.

2. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВД ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	НОМГОН СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	Б.ДАЛАЙХҮҮ
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	12,500,000 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Номгон сумын эрүүл мэндийн төв сумын нийт хүн амд эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай, чанартай хүргэхээр хичээн ажиллаж байна. Эмчилгээ үйлчилгээнд сүүлийн үеийн дэвшилтэт техник технологи нэвтрүүлж, үзүүлэх тусламж үйлчилгээ сайжирч байгаа бөгөөд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээнд мобайл технологи ашиглах болж, цахимаар өвчтөний намтар мэдээлэл шилжүүлэх, цахим үзлэг оношилгоо, цахим жор бичих, дээд шатлалын эмнэлэгтэй цахимаар холбогдож зөвлөгөө тусламж авах зэрэг олон ажлууд хийгдэж байна.

Сумын эрүүл мэндийн төв нь Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ компаниас цахилгаан авдаг. Цахилгааны саатал гарах үе байдаг тул хүнд өвчтөн тээвэрлэх, вакцин тарилгын тогтмол хэмд хадгалах зэрэгт нөөц мотор зайлшгүй шаардлагатай байгаа юм.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Эрүүл мэндийн төвийг зөөврийн цахилгаан үүсгүүр, компьютертэй болгосноор эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний хурдыг сайжруулж, цаг алдалгүй мэдээлэл солилцох боломж бүрдэнэ.

»» ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Цахилгааны саатал гарсан үед ашиглах нөөц үүсгүүртэй болно
- Цахим тусламж үйлчилгээнд хамрагдах иргэдийн тоо нэмэгдэнэ.
- Ачаалал багасаж, сэтгэл ханамж дээшилнэ.

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

Сумын эрүүл мэндийн төвд яаралтай үед ашиглах зөөврийн цахилгаан үүсгүүр, эмнэлгийн хэрэгсэл зөөвөрлөх чингэлэг, зөөврийн компьютер, хэвлэгч нийлүүлсэн.

3. ТӨХӨМ БАГИЙН ХУДАГ ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	НОМГОН СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	Б.БУЖИН
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	10,000,000 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Номгон сумын Төхөм багийн нутагт байх худгийн барилга хуучирч ашиглалтын шаардлага хангахгүй болсон. Худгийн барилгын завсар зайгаар шороо, ус чийг нэвтрэн орж худгийн тоног төхөөрөмжийг гэмтээж, зэврүүлснээр худгийн хэвийн ажиллагаа доголдсон. Уг худгийн барилгыг сэргээн, насос моторыг шинэчлэн худгийн ажиллагааг хэвийн болгосноор Төхөм багийн малчид ундны усны эх үүсвэртэй болно.



»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Малчдын бүлэг, нөхөрлөлөөрөө хамтран ахуйн хэрэглээний ундны ус болон хүнсний ногоо тариалах худагтай болох.

»» ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

Төхөм багт байрлах хуучин гүн өрмийн худгийн хуучин модон барилгыг шинэчлэн тоног төхөөрөмж суурилуулан, 2 онгоц шинээр байрлуулна

»» ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Хуучирсан худгийн тоног төхөөрөмжийг шинэчилнэ.
- Худгийн барилгыг шинээр барьснаар тоног төхөөрөмжийг хамгаална.
- Малчдын мал услах, мал угаах ус татах боломж бий болно.

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Хуучирсан худгийн барилгыг 3x4 хэмжээтэй блокон барилгаар шинэчилсэн.
- Ус нөөцлүүрийн сав байрлуулсан.
- Худгийн мотор, насосыг шинэчилсэн.
- Шинээр онгоц байрлуулсан.

4. НОМГОН СУМЫН ГЭРЭЛТҮҮЛЭГ ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	НОМГОН СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	А.УУГАНБАЯР
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	30,000,000 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Номгон сумын төвд 295 өрхийн 816 хүн амьдардаг. Сумын төвд гэрэлтүүлэг суурилуулаагүйгээс шалтгаалан оройтож тардаг сургуулийн сурагчид, иргэд гэмтэж бэртэх, нохойд уруулах зэргээр гэмтэх тохиолдол их байдаг. Мөн бусад сумдаас ирж буй иргэд төөрөх зэрэг эрсдэл гардаг. Сумын төвд цамхаг гэрэлтүүлэгтэй болсноор иргэд айх аюулгүйгээр гудамж талбайгаар зорчих, сум уруу ирж буй иргэд уг цамхаг гэрлээр баримжаа авч төөрөхгүй ирэх давуу талтай болох юм.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Сумын ард иргэдийн аюулгүй амьдрах орчинг бүрдүүлэх, залуусын оролцоог нэмэгдүүлэх

»» ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:

Сумын төвд гэрэлтүүлэг багатай, аюул осол гарах магадлал ихтэй газруудад цамхаг гэрлийг байрлуулна.

»» ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

Гэрэлтүүлэг нэмэгдсэнээр хичээл нь оройтож тардаг сургуулийн хүүхдүүд, оройн цагаар гудамж, талбайд зорчиж буй иргэд нохойд уруулах, осолд өртөх эрсдэл буурна.

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

Номгон сумын заагдсан 6 газар цамхаг гэрэл байрлуулж, ойр орчмыг гэрэлтүүлсэн.

2019 ОНД ЦОГТ-ОВОО СУМАНД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ХӨТӨЛБӨР:

1. ЗӨӨВРИЙН ЭРЧИМ ХҮЧ



ЗАХИАЛАГЧ:

ЦОГТ-ОВОО СУМЫН ЗДТГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

НОГООН ТӨГӨЛ БҮЛГИЙН АХЛАГЧ А.ГАНТӨМӨР

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:

9,973,800 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Цогт-Овоо сум төвлөрсөн эрчим хүчний системд 2008 онд холбогдсон боловч Багануурын цахилгаан дамжуулах төв болон зам зуурын аймаг сумдын дамжуулах станц, шугамын гэмтэл, засварын ажлаас шалтгаалан дунджаар жилийн 20-30 хоногт цахилгаан тасрах тохиолдол гардаг. Энэ үед иргэдэд хүргэх төрийн үйлчилгээ, соёл, боловсрол, эмнэлгийн үйлчилгээ тасалддаг бөгөөд төвийн эрчим хүчний цахилгаан тасарсан үед ашиглах цахилгаан үүсгүүртэй байх хэрэгцээтэй байна.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Цахилгаан үүсгүүр, цахилгааны утастай хамт худалдан авснаар сумын ЗДТГ, соёлын төв, цагдаагийн хэсэг, сургууль цэцэрлэгийн үйл ажиллагааг хэвийн явуулж, хурал цуглаан зохион байгуулж, эмнэлгийн яаралтай тусламжийн үйлчилгээг төвийн цахилгаан эрчим хүч тасарсан үед ч зөөврийн цахилгаан эх үүсвэрийн тусламжтайгаар хэвийн хүргэнэ.

»» ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ:

- Япон улсад үйлдвэрлэсэн зөөврийн цахилгаан үүсгүүр худалдан авсан (ELEMAX-SH7600EX).
- Солонгос улсад үйлдвэрлэсэн, 300 метр цахилгааны кабель авсан.
- 2.8x2.8 метрийн харьцаатай блокон барилга барьсан.

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Төслийн хүрээнд нийлүүлэх цахилгаан үүсгүүр болон барилга бүрэн хүлээлгэж, 3 байгууллага холбогдсон.
- Цаашид шаардлага гарсан тохиолдолд зөөврийн эрчим хүчээр хангах боломж бүрдсэн.

2. ЦОГТ-ОВОО СУМЫН МУЗЕЙН ТОХИЖИЛТ



ЗАХИАЛАГЧ:	ЦОГТ-ОВОО СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	ЦОГ БҮЛГИЙН АХЛАГЧ Б.МӨНХ-УНДРАМ
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	18,879,800 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Цогт-Овоо сумын орон нутаг судлах музейн барилгыг 2016 онд барьж ашиглалтанд оруулсан. Музейн зориулалттай уг барилгыг барих үед санхүүжилт хангалтгүй байсан тул дотор тохижилтын ажлыг хийгээгүйгээс үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй, мөн сумын байгаль, нийгэм, түүхэн замнал, өв уламжлал, зан заншлыг шингээсэн үзмэр байхгүйгээс нутгийн иргэд болон гадаад улсаас ирэх зочид жуулчдад нутгийн түүх соёлыг сурталчлах боломжгүй байгаа тул музейг тохижуулах зайлшгүй шаардлагатай.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО/ХИЙХ АЖИЛ:

Цогт-Овоо сумын музейд шинээр дараах үндсэн 6 танхимыг бий болгож тохижуулна.

- Манай эриний өмнөх I танхим /Юрийн галав, чулуун зэвсэг/
- Говь Түшээ гүний хошуу, Цогт сум, Цогт-Овоо сум II танхим
- Их Монгол улс, Тогоонтөмөр хааны үе III танхим
- Угсаатны зүйн IV танхим.
- Байгалийн V танхим
- Хүлээлгийн VI танхим

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Музейд байнгын 1 ажлын байр бий болсон
- 81 метр квадрат талбай бүхий барилгын дотор заслыг өөрчлөн үзмэрийн 5, хүлээлгийн 1 танхимтай болгон тохижуулсан

3. ШУУРХАЙ МЭДЭЭЛЭЛ-ИРГЭН БҮРИЙН ОРОЛЦОО



ЗАХИАЛАГЧ:	ЦОГТ-ОВОО СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	"ХАЙРХАН БАЯН БОР" ХХК
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	5,180,000 төгрөг

»» **ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:**

Цогт-Овоо сумын хэмжээнд сумын төвд 247 өрхийн 620 иргэн оршин суудаг. Мөн малчин иргэд, авто замаар зорчигчид сумын төвөөр зорчин өнгөрдөг бөгөөд суманд үзүүлэх төрийн үйлчилгээ, урлаг соёл, олон нийтийн арга хэмжээний тухай мэдээ мэдээллийг төвийн зарлал дээр байршуулж цахим байдлаар фэйсбүүк дээр тавьдаг. Гэвч зарим мэдээллийг түргэн шуурхай авч чадаагүй, сумын төвд байгаагүй учраас сонсоогүй, фэйсбүүк ашигладаггүй гэх мэт олон шалтгаанаас болж мэдээ мэдээлэл аваагүй үлдсэн, олон нийтийн үйл ажиллагаанд оролцоогүй учраас үзэл бодлоо илэрхийлэх боломжгүй хоцорсон гэх асуудал гардаг. Тиймээс олон нийтэд мэдээ мэдээллийг түргэн шуурхай хүргэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх байдлыг сайжруулах, зарын узель, цагаан хоолойтой болох шаардлагатай байгаа.

»» **ТӨСЛИЙН ЗОРИЛГО:**

Узель, зар мэдээний техник, тоног төхөөрөмжийг цахилгааны утасны хамт худалдан авснаар сумын иргэдэд төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагаа, хурал цуглаан, цаг үеийн мэдээ мэдээллийг түргэн шуурхай, цаг алдалгүй хүргэнэ.

»» **ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ:**

Цогт-Овоо сумын соёлын төвд дараах тоног төхөөрөмж, хэрэгслүүдийг нийлүүлсэн.

№	Нийлүүлэх тоног төхөөрөмж, хэрэгслүүд	Тоо ширхэг
1	Гаралтын өсгөгч /u-6300/	1
2	Чанга яригч цагаан хоолой /U-308/	4
3	Ширээний микрофон /Be-zze/	1
4	Компьютер ком /ком/	1

№	Нийлүүлэх тоног төхөөрөмж, хэрэгслүүд	Тоо ширхэг
5	Кабель утас /м/	4500
6	Цахилгааны утас /м/	300

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Дэнж хороололд 1 ширхэг цагаан хоолой, Бумбат, Хараат хороололд 2 ш, сургуулийн хороололд 1 ширхэг цагаан хоолой байршуулж, Цогт-Овоо сумын соёлын төвд өсгөгч, ширээний микрофон, компьютер, кабель утас, цахилгааны утас нийлүүлсэн.
- Иргэд зарлал, мэдээллийг шуурхай, цаг алдалгүй авдаг болсон
- Цогт-Овоо сумын төвийн 620 иргэдийн өдөр тутмын амьдралд салшгүй үүрэг гүйцэтгэнэ.

4. СУМЫН ТӨВИЙН ЗАСМАЛ ЗАМ, ГЭР ХОРООЛЛЫН ЗАМЫН ТЭМДЭГЖҮҮЛЭЛТ



ЗАХИАЛАГЧ:	ЦОГТ-ОВОО СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	"АЯН ЗАМ" БҮЛГИЙН АХЛАГЧ Ц.ЭНХТӨР
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	9,584,000 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Улаанбаатар-Даланзадгад, Даланзадгад-Улаанбаатар, Улаанбаатар-Цогтцэций, Улаанбаатар-Ханбогд, Улаанбаатар-Цагаан хад, Улаанбаатар-Гурвантэс сумдын чиглэлийн улсын чанартай авто замаар өдөрт дунджаар 100-150 тээврийн хэрэгсэл зорчиж байна. Тээврийн хэрэгслийн жолооч нар замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахгүй гүйцэж түрүүлэх, хурд хэтрүүлж явах, мал мөргөх зэрэг ослоуд гарсаар байна. 2018 онд зам тээврийн 4, 2019 оны эхний дөрвөн сарын байдлаар 3 зам тээврийн осол Цогт-Овоо сумын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрч буй авто зам дээр гарсан байна. Тиймээс сумын төв, гудамж, замын тэмдэгжүүлэлтийг сайжруулж, зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх хэрэгтэй байгаа.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Цогт-Овоо сумын замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, зам тээврийн осол аваараас урьдчилан сэргийлнэ.


»» ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ:

30 ширхэг замын тэмдэг, 3 ширхэг нараар цэнэглэгч гэрэл, 2 ширхэг хурд сааруулагч байршуулсан

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Цогт-Овоо сумын иргэд болон тус сумын нутаг дэвсгэрээр дайран өнгөрч буй авто тээврээр зорчигчид, явган хүн болон жолооч нарыг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэхэд нэмэр оруулж байна.
- Төсөл хэрэгжих явцад 7 хүн түр ажлын байраар хангагдсан.
- Цогт-Овоо сумын 620 иргэн байнгын үр шим хүртэж өдөрт зорчин өнгөрч буй 100-150 хүний амь нас эрсдэхээс хамгаалж байна.

5. ХЯНАЛТЫН КАМЕР-АЮУЛГҮЙ ОРЧИН



ЗАХИАЛАГЧ:	ЦОГТ-ОВОО СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	“ВИШН МЕЖИК” ХХК
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	5,500,000 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Цогт-Овоо сумын эрүүл мэндийн төв 1958 онд баригдаж 1959 онд ашиглалтанд орсон. Уг эрүүл мэндийн төв нь бага эмчийн салбараас их эмчийн, Эрүүл мэндийн төв болтлоо хөгжиж анхан шатны тусламж үйлчилгээг чанарын өндөр түвшинд хүргэж байна. Гэвч эрүүл мэндийн төвийн дотор болон гадна хяналтын камер суурилуулж эрүүл мэндийн төвийн ажилчид болон үйлчлүүлэгчдийг учирч болох эрсдэлээс хамгаалах хэрэгцээ шаардлагатай байгаа.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Цогт-Овоо сумын 2 давхар эрүүл мэндийн төвийн гадна болон дотор талд хяналтын камер суурилуулж байнгын хяналттай болгож, эрсдэлээс сэргийлнэ.

»» ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ/ТӨСӨВ:

Цогт-Овоо сумын 2 давхар эрүүл мэндийн төвийн гадна болон дотор талд 7 камер суурилуулж дараах туслах хэрэгслүүдийг нийлүүлнэ. Үүнд:

№	Нийлүүлсэн барааны нэр төрөл	Тоо ширхэг-хэмжээ
1	IP камер гадаа 4 MP	2 ш
2	IP камер дотор 4 MP	3 ш
3	Samsung брэндийн 42 инч дэлгэц	1 ш
4	Свитч спорт	1 ш
5	Кабель	500 м

№	Нийлүүлсэн барааны нэр төрөл	Тоо ширхэг-хэмжээ
6	Тэжээлийн үүсгүүр 2А	7 ш
7	NVR спорт	1 ш
8	Хард диск 2МВ	1 ш
9	Гадаа камер 2 МР	1 ш
10	Дотор камер 2 МР	1 ш
11	Сумын камерын антен	2 ш
12	Хоолой	200 м
13	Далдлагч	60 ш
14	Хайрцаг	2 ш
15	Холбогч	30 ш

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Цогт-Овоо сумын эрүүл мэндийн төвийн 22 ажилчин, уг ЭМТ-өөр үйлчлүүлэгч 6240 үр шимийг нь хүртэнэ
- Хяналтын камераар эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг 24/7 хянаж, гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.

6. ЭКО ОРЧИН-БҮТЭЭЛЧ ИРЭЭДҮЙ



ЗАХИАЛАГЧ:	ЦОГТ-ОВОО СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	"АЗ БИЛЭГТЭЙ" ХХК
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	8,900,000 төгрөг

»» ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Өмнөговь аймгийн "Хөдөө аж ахуй, үйлдвэржилтийн жил"-ийн хүрээнд Цогт-Овоо сумын цэцэрлэгийн насны хүүхдүүдэд зориулсан төсөл санаачилж, Цогт-Овоо сумын 12-р цэцэрлэгийн 4 бүлгийн 168 хүүхдийн танин мэдэхүйг хөгжүүлэх, бүтээлч хандлагыг бий болгох, хөдөлмөрт сургах, цэцэрлэгийн орчныг ногоон байгууламжтай болгох хэрэгцээг хангахаар шийдвэрлэсэн.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Цогт-Овоо сумын 12-р цэцэрлэгийн 168 хүүхэд, 14 багш, ажилчдад зориулсан хүнсний ногоо тариалах хүлэмж бүхий туршилтын талбайтай болгоно.

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Ногоон ургамал тариулах дадлагын талбай, явган хүний зам бүхий 5 хэсэг хашлагатай талбай, 4 талд модон сүүдрэвч болон бусад тохижилтын ажил хийж 7 төрлийн 50 ширхэг хүлэмжийн багаж хэрэгсэл нийлүүлсэн.
- Цогт-Овоо сумын 12 дугаар цэцэрлэгийн 4 бүлгийн 115 хүүхэд, тойргийн цэцэрлэгийн насны 168 хүүхдийн танин мэдэхүй, сэтгэн бодох чадвар, бие бялдрыг хөгжүүлэх ногоон байгууламж бүхий туршилтын талбай бий болсон.

2019 ОНД БАЯНДАЛАЙ СУМД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ХӨТӨЛБӨР:

1. “ГЭРЭЛТҮҮЛГИЙН АЖИЛ” ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БАЯНДАЛАЙ СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	“ЭС ЖИ ЭМ” ХХК
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	52,997,078 төгрөг

»» ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Баяндалай сумын төв нь гудамжны гэрэлтүүлэггүй. Үүнээс шалтгаалж иргэд осол бэртэлд өртөх, нохойд уруулах, гэмт хэрэг гарах гэхчлэн иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд аюул учрах нь элбэг байдаг. Иймд сумын төвд стандартын шаардлага хангасан гудамжны гэрэлтүүлэг болон цамхагт гэрэл хийх шаардлагатай байсан.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Баяндалай сумын төвд стандартын шаардлага хангасан гудамжны гэрэлтүүлэг хийж ард иргэдийн амьдралын аюулгүй байдлыг хамгаалах.

»» ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Баяндалай сумын төвд нийт 60ш гудамжны гэрэлтүүлэг, 23ш цамхагт гэрэл хийж ашиглалтанд хүлээлгэн өгсөн.

»» ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн хохирлын эрсдэлийг бууруулна
- Сумын төвийн өнгө үзэмж сайжирч, сумын хөгжил цэцэглэлтэнд хувь нэмэр оруулсан

- Иргэд тав тухтай орчинд ажиллаж амьдрах болсон.
- Төслийн хүрээнд сумын төвийн хэмжээнд нийт 60 ш гудамжны гэрэлтүүлэг, 23ш цамхагт гэрэл суурилуулсан.

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн Удирдах зөвлөлийн 2019 оны нэгдүгээр сарын 24-ний хурлын 3 тоот тогтоолоор батлагдсан Зорилтот сумдад жил бүр олгох санхүүжилтийн квотын хүрээнд “Гэрэлтүүлгийн ажил” төслийг хэрэгжүүлсэн.
- Баяндалай сумын ЗДТГ нь “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх удирдамж”, “Говийн оюу хөгжлийг дэмжих санд ирүүлсэн саналыг хянан үзэх, үнэлэх, шийдвэр гаргах протокол”-д нийцүүлэн эрэмбэлэх, сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийн шийдвэрээр хөтөлбөрийг сонгон шалгаруулсан.
- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь захиалагч Баяндалай ЗДТГ болон хөтөлбөрийн хэрэгжүүлэгч “Эс Жи Эм” ХХТ-тай санхүүжилтийн гэрээ байгуулсан.
- Хэрэгжүүлэгч “Эс Жи Эм” ХХК-тай гэрээний ажлыг хугацаанд нь чанартай хэрэгжүүлснээр Өмнөговь аймгийн Баяндалай сумын төвд стандартын шаардлага хангасан гудамжны гэрэлтүүлэгтэй болж, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө хохирох эрсдлийг бууруулахад дэм болон, сумын төвийн өнгө үзэмж хийгээд иргэд тав тухтай орчинд ажиллаж амьдрах нөхцөл сайжирсан.

2. “ХҮҮХДИЙН ТОГЛООМЫН ТАЛБАЙ БОЛОН САГСНЫ ТАЛБАЙ БАЙГУУЛАХ” ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БАЯНДАЛАЙ СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	“САУДГОБИ КАПИТАЛ” ХХК
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	23,442,905 төгрөг

»» ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Баяндалай сумын төвд стандартын шаардлага хангасан хүүхэд залуучуудын спортын тоглоом болон бие бялдар чийрэгжүүлэх хэрэгсэл байдаггүй тул сумын хүүхэд залуучуудын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, бие бялдар, гоо зүй, эрүүл мэндэд нь анхаарахад дэмжлэг үзүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор төслийг санаачилсан.

»» ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Сумын хөгжилд дэмжлэг болох, иргэд чөлөөт цагаа боловсон өнгөрүүлэх, зөв дадал хэвшлээр эрүүл мэнддээ анхаарах, хүүхэд, залуус спортод дурлах, хичээллэх зэрэг зэрэг нөхцөлүүдийг бүрдүүлэх

»» ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Баяндалай сумын төвд хүүхдийн тоглоомын талбай болон сагсны талбай байгуулан ашиглалтанд хүлээлгэн өгсөн.

»» ХӨТӨЛБӨРИЙН ҮР ӨГӨӨЖ:

Сумын хүүхэд, залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, хүүхэд залуучууд спортод дурлах, хичээллэх, иргэдэд хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх,

иргэд зөв дадал хэвшилтэй болсноор гэмт хэргийн гаралт буурахад дэмжлэг болох, сумын хөгжил цэцэглэлтэнд хувь нэмэр оруулах зэрэг эерэг үзүүлэлтүүдийг бий болгосон.

»» ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Сумын хүүхэд, залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, спортод дурлах, хичээллэх, иргэдэд хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, цаашлаад иргэд зөв дадал хэвшилтэй болсноор гэмт хэргийн гаралт буурахад дэмжлэг болох, сумын хөгжил цэцэглэлтэнд хувь нэмэр оруулах зэрэг эерэг нөлөө үзүүлсэн.
- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2019 оны нэгдүеэр сарын 24-ний хурлын 3 тоот тогтоолоор батлагдсан Зорилтот сумдад жил бүр олгох санхүүжилтийн квотын хүрээнд “Хүүхдийн тоглоомын талбай болон сагсны талбай байгуулах” төслийг хэрэгжүүлсэн.
- Баяндалай сумын ЗДТГ нь “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх удирдамж”, “Говийн оюу хөгжлийг дэмжих санд ирүүлсэн саналыг хянан үзэх, үнэлэх, шийдвэр гаргах проткол”-д нийцүүлэн эрэмбэлэх, сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийн шийдвэрээр төслийг сонгон шалгаруулсан.
- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь захиалагч Баяндалай сумын ЗДТГ болон төслийн гүйцэтгэгч “Саудгоби капитал” ХХК -тай санхүүжилтийн гэрээ байгуулсан.
- Гүйцэтгэгч “Саудгоби капитал” ХХК төслийн гэрээний ажлыг хугацаанд нь чанартай хэрэгжүүлснээр Өмнөговь аймгийн Баяндалай сумын хүүхэд, залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх газартай болж, хүүхэд залуучууд спортод дурлах, хичээллэх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэхийн дээр иргэд зөв дадал хэвшилтэй болсноор гэмт хэргийн гаралт буурахад дэмжлэг болох, сумын хөгжил цэцэглэлтэнд хувь нэмэр оруулах зэрэг эерэг нөлөө гарсан.

2019 ОНД МАНДАЛ-ОВОО СУМД ОЛГОСОН КВОТООР САНХҮҮЖҮҮЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ХӨТӨЛБӨР:

1. “АЮУЛГҮЙ ОРЧИН-ХҮҮХДИЙН ИРЭЭДҮЙ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ МАНДАЛ-ОВОО СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	“ХАЙРХАН БАЯН БОР” ХХК
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	25,042,600 төгрөг

»» ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Мандал-Овоо сумын ЕБС нь 161 сурагч, 29 багш ажилчидтай. Сургуулийн орчинд хяналтын камергүйгээс болж сургууль дээр болж байгаа үйл ажиллагаа, алдаа зөрчлийг хянах боломжгүй байсныг харгалзан үзэж, хүүхдийн аюулгүй орчинд сурч боловсрох орчин нөхцөлийг хангах шаардлагаар төслийг санаачилсан.

»» ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Сургуулийн гадаад, дотоод орчны хяналтыг сайжруулах, хүүхдийн сурч, боловсрох ая тухтай орчин бүрдүүлэх.

»» ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Мандал-Овоо сумын ЕБС-д хяналтын камер нийлүүлж, суурилуулсан.

»» ХӨТӨЛБӨРИЙН ҮР ӨГӨӨЖ:

Мандал-Овоо сумын ЕБС-ийн гадна, дотор орчныг хяналтын камераар хянаж, тус сургуулийн 161 сурагч, 29 багш, ажилчдын аюулгүй орчинд сурч боловсрох, ажиллах нөхцөл сайжрахаас гадна сургуулийн орчны эд хөрөнгө гэмтэх, алдагдах эрсдэл багасгах юм.

»» ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- Мандал-Овоо сумын ЕБС-ийн гадна, дотор орчныг хяналтын камераар хянаж тус сургуулийн 161 сурагч, 29 багш, ажилчдын аюулгүй орчинд сурч боловсрох, ажиллах нөхцөл сайжрахаас гадна сургуулийн орчны эд хөрөнгө гэмтэх, алдагдах эрсдэл багасгах юм.
- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2019 оны нэгдүгээр сарын 24-ний хурлын 3 тоот тогтоолоор батлагдсан Зорилтот сумдад жил бүр олгох санхүүжилтийн квотын хүрээнд “Аюулгүй орчин-хүүхдийн ирээдүй” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.
- Мандал-Овоо сумын ЗДТГ нь “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх удирдамж”, “Говийн оюу хөгжлийг дэмжих санд ирүүлсэн саналыг хянан үзэх, үнэлэх, шийдвэр гаргах протокол”-д нийцүүлэн эрэмбэлэх, сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийн шийдвэрээр төслийг сонгон шалгаруулсан.
- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь захиалагч Мандал-Овоо сумын ЗДТГ болон төслийн хэрэгжүүлэгч “Хайрхан баян бор” ХХК-тай санхүүжилтийн гэрээ байгуулсан.
- Мандал-Овоо сумын засаг даргын захирамжаар байгуулагдсан ажил хүлээлцэх комиссын шийдвэрээр төслийн ажлыг хүлээж авсан.
- Хөтөлбөрийн хэрэгжүүлэгч “Хайрхан баян бор” ХХК нь гэрээний ажлыг хугацаанд нь чанартай хэрэгжүүлснээр Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын ЕБС гадна, дотроо хяналтын камертай болж тус сургуулийн 161 сурагч, 29 багш, ажилчид тав тухтай, аюулгүй орчинд сурч боловсрох, ажиллах болсноос гадна сургуулийн орчны эд хөрөнгө гэмтэх, алдагдах эрсдэл багасна.

2. “ЯСЛИ-ХҮҮХЭД ХӨГЖИЛ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ МАНДАЛ-ОВОО СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	“МАНДАЛ СТИЛЬ” ХХК
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	9,980,000 төгрөг

»» ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

2019 оны байдлаар Мандал-Овоо сумын төвд ажиллаж амьдарч байгаа мэргэжилтэй боловсон хүчин болох эмч, багш, тамгын газрын ажилтнуудын 15 хүүхэд 1.5-2 настай байна. Тэдгээр нялхасыг асарч сувилах, хөгжүүлэх байгууллага байхгүй учир залуу ээж нар хөдөлмөр эрхэлж өрхийн орлогоо нэмэгдүүлэхийн тулд бага насны хүүхдээ гэртээ цоожилж эсвэл гадны хүн гуйж харуулдаг. Энэ нь хүүхдийн амь нас, эрүүл мэндэд өндөр эрсдэлтэй байсан.

»» ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

1,5-2 хүртэл насны хүүхдийг асарч хамгаалах, тэдэнд эрүүл аюулгүй орчинд өсч бойжих нөхцөл бүрдүүлэх, яслийн насны хүүхдийн оюун ухаан хөгжүүлэх сургалтын хөтөлбөрийг сэргээн хэрэгжүүлэх, залуу эцэг, эхчүүдийг хөдөлмөр эрхэлж өрхийн орлогоо нэмэгдүүлэх, сурч хөгжих нөхцөл боломжоор хангах

»» ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Мандал-Овоо сумын 17-р цэцэрлэгт яслийн нэг анги шинээр бий болгож, 50 ширхэг тавилга, хэрэгслийг (яслийн хүүхдэд зориулсан) нийлүүлсэн.

»» ХӨТӨЛБӨРИЙН ҮР ӨГӨӨЖ:

Мандал-Овоо сумын 17-р цэцэрлэгийн яслийн шинэ ангид 1.5-2 хүртэлх насны 15 хүүхдийг хамруулж байна. Үүний үр дүнд цэцэрлэгт хамрагдах насанд хүрээгүй хүүхдүүд аюул осолгүй, ая тухтай орчинд өсөж хүмүүжих, тэдний эцэг, эхчүүдэд албан ажил эрхлэх, орлогоо нэмэгдүүлэх, чөлөөт цагтай болж амрах, өөрийгөө хөгжүүлэх боломж гарч, шинээр хоёр ажлын байр бий болсон гэх мэт олон зэрэг үзүүлэлтүүд гарсан юм.

»» ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2019 оны нэгдүеэр сарын 24-ний хурлын 3 тоот тогтоолоор батлагдсан Зорилтот сумдад жил бүр олгох санхүүжилтийн квотын хүрээнд “Ясли-хүүхэд хөгжил” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.
- Мандал-Овоо сумын ЗДТГ нь “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх удирдамж”, “Говийн оюу хөгжлийг дэмжих санд ирүүлсэн саналыг хянан үзэх, үнэлэх, шийдвэр гаргах проткол”-д нийцүүлэн эрэмбэлэх, сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийн шийдвэрээр хөтөлбөрийг сонгон шалгаруулсан.
- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь захиалагч Мандал-Овоо сумын ЗДТГ болон хөтөлбөрийн хэрэгжүүлэгч “Мандал стиль” ХХК-тай санхүүжилтийн гэрээ байгуулсан.
- Хөтөлбөрийн хэрэгжүүлэгч “Мандал стиль” ХХК гэрээний ажлыг хугацаанд нь чанартай хэрэгжүүлснээр Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын мэргэжилтэй боловсон хүчин, төрийн албан хаагчдын цэцэрлэгт хамрагдах насанд хүрээгүй хүүхдүүд аюул осолгүй, ая тухтай орчинд өсөж хүмүүжих, тэдний эцэг, эхчүүдэд албан ажил эрхлэх, орлогоо нэмэгдүүлэх, чөлөөт цагтай болж амрах, өөрийгөө хөгжүүлэх, шинээр хоёр ажлын байр бий болох гэх мэт олон зэрэг үр дүнд хүрсэн юм.

3. “БАЯН ТӨГӨЛ” ХӨТӨЛБӨР



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ МАНДАЛ-ОВОО СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	“ХАЛБАС ХАЙРХАНЫ ХИШИГ” ХХК
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	6,972,000 төгрөг

»» ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Мандал-Овоо сумын нутаг нь шороон шуурга их шуурдаг, маш их элсний нүүдэлтэй. Сумын баруун хойно байрлалтай нийтийн эзэмшлийн 7 га талбайд сумын иргэд, байгууллага нийтээрээ 2017 оноос хойш жил бүр мод тариалах болсон усалгааны системгүйгээс модны ургалт маш муу байна. Иймд дээрх талбайд услалтын систем суурилуулан модны усалгааг тогтмолжуулан ургалтыг нь сайжруулах, цаашид мод, бутыг үргэлжлүүлэн тогтмол тариалж ногоон төгөл болгон сумын төвийг элсний нүүдлээс хамгаалах шаардлагатай байв.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Ногоон байгууламж нэмэгдүүлэх замаар цөлжилт, элсний нүүдэл бууруулах, сумын өнгө үзэмжийг сайжруулах.

»» ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Мандал-Овоо сумын баруун хойд талд байрлалтай мод үржүүлгийн талбайд услалтын системийн 200 метр хоолой, дагалдах хэрэгслийн хамт нийлүүлж, суурилуулсан.

»» ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

Мандал-Овоо сумын мод үржүүлгийн талбай услалтын системээр хангагдаж, усалгааны ажилтны ажлыг хөнгөвчлөх, усалгааны чанар, модны ургац сайжрах, элсний нүүдлийг бууруулах, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд дэмжлэг болох зэрэг эерэг үзүүлэлтүүд бий болсон.

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2019 оны нэгдүгээр сарын 24-ний хурлын 3 тоот тогтоолоор батлагдсан Зорилтот сумдад жил бүр олгох санхүүжилтийн квотын хүрээнд “Баян төгөл” төслийг хэрэгжүүлсэн.
- Мандал-Овоо сумын ЗДТГ нь “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх удирдамж”, “Говийн оюу хөгжлийг дэмжих санд ирүүлсэн саналыг хянан үзэх, үнэлэх, шийдвэр гаргах протокол”-д нийцүүлэн эрэмбэлэх, сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийн шийдвэрээр төслийг сонгон шалгаруулсан.
- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь захиалагч Мандал-Овоо ЗДТГ болон хөтөлбөрийн хэрэгжүүлэгч “Халбас хайрханы хишиг” ХХК-тай санхүүжилтийн гэрээ байгуулав.
- Хөтөлбөрийн хэрэгжүүлэгч “Халбас хайрханы хишиг” ХХК гэрээний ажлыг хугацаанд нь чанартай хэрэгжүүлснээр Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын мод үржүүлгийн талбай услалтын системээр хангагдаж, усалгааны ажилтны ажлыг хөнгөвчлөх, усалгааны чанар, модны ургац сайжрах, элсний нүүдлийг бууруулах, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд дэмжлэг болох зэрэг эерэг үзүүлэлтүүд бий болсон.

4. “УХААЛАГ ХУДАГ” ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ МАНДАЛ-ОВОО СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	“ХАЛБАС ХАЙРХАНЫ ХИШИГ” ХХК
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	20,901,480 төгрөг

»» ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Сумын төвийн иргэдийн ундны усны хэрэгцээг хангаж байгаа нэг худаг нь өвөл, зуны цагийн хуваариар ажилладаг, бусад үед худаг хаалттай байдаг учир цагийн ажилтай болон гадагшаа явсан иргэд шөнө оройн цагаар ирээд хүссэн үедээ усаа авах боломж хязгаарлагдмал байсан.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Иргэдэд 24 цагийн ажиллагаатай ус түгээх ухаалаг худгаар үйлчлэх

»» ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Мандал-Овоо сумын төвийн ундны усны худгийг засварлаж, ус түгээх ухаалаг систем суурилуулах, хамгаалалтын хашаа татах, камержуулах ажлууд хийгдсэн.

»» ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:

- Сумын төвийн 205 өрхийн 314 хүн төслийн үр ашгийг шууд хүртэж байна.
- Иргэд хоногийн 24 цагийн аль ч үед ус авах боломжтой болсон.
- Ундны усны эх үүсвэрт эрүүл ахуйн эрсдэл буурна.

- Барилгын өнгө үзэмжийг сайжруулсан.
- Худгийн гадна орчныг хяналтын камераар хянах боломжтой болсон.
- Усны хэмнэлт нэмэгдэнэ.
- Бэлэн төлбөр тооцоо хийгдэхгүй.
- Усны картаар үйлчлүүлэгчдийн бүртгэл, мэдээллийн сантай болно.
- Усны зарцуулалт, борлуулалтыг нарийн хянах боломжтой болсон.
- Ундны усан хангамжийн хүртээмж сайжирна.

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2019 оны нэгдүгээр сарын 24-ний хурлын 3 тоот тогтоолоор батлагдсан Зорилтот сумдад жил бүр олгох санхүүжилтийн квотын хүрээнд “Ухаалаг худаг” төслийг хэрэгжүүлсэн;
- Мандал-Овоо сумын ЗДТГ нь “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх удирдамж”, “Говийн оюу хөгжлийг дэмжих санд ирүүлсэн саналыг хянан үзэх, үнэлэх, шийдвэр гаргах проткол”-д нийцүүлэн эрэмбэлэх, сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийн шийдвэрээр төслийг сонгон шалгаруулсан;
- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь захиалагч Мандал-Овоо сумын ЗДТГ болон төслийн гүйцэтгэгч “Халбас хайрханы хишиг” ХХК-тай санхүүжилтийн гэрээ байгуулсан;
- “Халбас хайрханы хишиг” ХХК нь төслийн гэрээний ажлыг хугацаанд нь чанартай хэрэгжүүлснээр Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын иргэд хоногийн 24 цагийн аль ч үед ундны усаа авах нөхцөл боломжоор хангагдсан.

5. “ХОГИЙН ЦЭГ” ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧ:	ӨМНӨГОВЬ МАНДАЛ-ОВОО СУМЫН ЗДТГ
ГҮЙЦЭТГЭГЧ:	“ДЭЭД ГОЛ” БҮЛЭГ
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТӨСӨВ:	9,845,000 төгрөг

»» ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Хог хаягдал байгалийн хүчин зүйлээс бус хүн төрөлхтний үйл ажиллагаанаас үүдэн бий болж, байгаль орчныг ихээхэн бохирдуулж, экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулж байна. Иймд орон нутгийн иргэд, малчид ч өөрсдийн хэмжээнд санаачлан хог хаягдлын цэг байгуулан ахуйн хог хаягдал болон ган, зуд, малын өвчлөлөөс шалтгаалсан үхсэн малын сэг зэм зэргийг нэг цэгт зохих ёсоор устгах ажлыг зохион байгуулах шаардлагатай байсан.

»» ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Мандал-Овоо сумын Өтгөн багийн нутагт нэгдсэн хог хаягдлын цэгтэй болж иргэдийн зөв дадал хэвшлээр байгаль орчны бохирдол, халдварт өвчнийг бууруулахад нэмэр болох

»» ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Мандал-Овоо сумын Өтгөн багийн нутагт хогийн цэг байгуулан ашиглалтанд хүлээлгэн өгсөн.

»» ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ:


- Байгаль орчноо хамгаална.
- Иргэдийг зөв дадалд хэвшүүлнэ.
- Малын халдварт өвчнийг бууруулна.
- Мандал-Овоо сумын Өтгөн багийн 20 гаруй өрх төслийн үр шимийг хүртэж байна.

»» ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн Удирдах зөвлөлийн 2019 оны нэгдүгээр сарын 24-ний хурлын 3 тоот тогтоолоор батлагдсан Зорилтот сумдад жил бүр олгох санхүүжилтийн квотын хүрээнд “Хогийн цэг” төслийг хэрэгжүүлсэн.
- Мандал-Овоо сумын ЗДТГ нь “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх удирдамж”, “Говийн оюу хөгжлийг дэмжих санд ирүүлсэн саналыг хянан үзэх, үнэлэх, шийдвэр гаргах протокол”-д нийцүүлэн эрэмбэлэх, сонгон шалгаруулах ажлын хэсгүүдийн шийдвэрээр төслийг сонгон шалгаруулсан.
- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь захиалагч Мандал-Овоо сумын ЗДТГ болон төслийн гүйцэтгэгч “Дээд гол” бүлгийн ахлагч Б.Ичинхоролтой санхүүжилтийн гэрээ байгуулсан.
- “Дээд гол” бүлэг нь төслийн гэрээний ажлыг хугацаанд нь чанартай хэрэгжүүлснээр Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын Өтгөн багийн 20 гаруй өрх нэгдсэн хог хаягдлын цэгтэй болж иргэдийн зөв дадал хэвшлээр байгаль орчны бохирдол, халдварт өвчнийг бууруулахад дэмжлэг болох юм.

»» САНГИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

1



www.goviinoyu.mn

Сангийн цахим хуудсанд 7 хоног тутамд мэдээлэл байршуулж байна

2



Говийн Оюу мэдээлийн сонин

Сангийн мэдээллийн сонинг гаргаж олон нийтэд мэдээлэл түгээж байна

3



Орон нутгийн болон үндэсний сонинд Сангийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн талаар мэдээлэл нийтэлж байна.

Төслийн нээлт, хүлээлгэн өгөх ёслол, хаалтын үйл ажиллагаа, Сангийн үйл явдлын тухай гэх мэт мэдээлэл сонинд нийтлүүлж байна.

4



Жил бүр хөндлөнгийн аудитын үйлчилгээ авч байна

Далайван аудит



5

Даланзадгад сумын төвийн зарын самбарууд дээр Сангийн тухай мэдээлэл байршуулж байна
Санхүүжүүлсэн төсөл хөтөлбөр, тэтгэлэг, Сангийн үйл явцын мэдээлэл, хөрөнгө оруулалтын тухай мэдээлэл

6



Хөрөнгө оруулагч Оюу толгой ХХК, Хамтын ажиллагааны гэрээний талууд болох Өмнөговь аймгийн ЗДТГ, Ханбогд сумын ЗДТГ-тай албан тоот, имэйл, уулзалт зохион байгуулж мэдээлэл солилцож байна

Сангийн санхүүжилтийн хуваарилалт, батлагдсан төсөл, үйл явцын мэдээ, төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, хяналт

7



Жил бүрийн үйл ажиллагааны тайланг товхимол байдлаар 6000-8000 хувь хэвлүүлэн олон нийтэд тайлагнаж байна

»» САНГИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- Сангийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний журмыг 2018 оны гуравдугаар сарын 15-ны өдөр Удирдах зөвлөлөөс баталсан бөгөөд Сан нь уг журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байна.
- Хяналт-шинжилгээ, үнэлгээний журмын зорилго нь “Говийн оюу хөгжлийн дэмжих сан”-ийн Санхүүжилтийн удирдамж, Сангийн дүрэм болон Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд ХДС-аас санхүүжилтийн дэмжлэг олгохоор батлагдсан төсөл хөтөлбөрүүдийн хөрөнгө оруулагч, санхүүжүүлэгч, санаачлан удирдагч, хэрэгжүүлэгч, холбогдох орон нутгийн төр захиргааны байгууллагууд болон төслийн үр шим хүртэгчдийн зүгээс төсөл хөтөлбөрүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, шалгараагүй болон хэрэгжиж дууссан төсөл хөтөлбөрийн хаалт, төсөл хөтөлбөрт эрсдэлийн үнэлгээ хийх үйл ажиллагааг зохицуулахад оршиж байна.
- Сангийн хяналт-шинжилгээ үнэлгээний ажилд дараах оролцогч талууд оролцоно.
 - o Хөрөнгө оруулагч - “Оюу толгой” компани
 - o Санхүүжүүлэгч байгууллага- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”
 - o Захиалагч- Хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангаж, хэрэгжиж дууссанаас хойш үйл ажиллагааг авч явах/хариуцах иргэн/байгууллага
 - o Гүйцэтгэгч/Хэрэгжүүлэгч- Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж байгаа иргэн/байгууллага
 - o Шууд болон шууд бус үр шим хүртэгч- Өмнөговь аймгийн иргэд/байгууллага
 - o Үнэлгээний байгууллага/хувь хүн- Бие даасан үнэлгээ, судалгааны байгууллага/хувь хүн

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

АРХИВТ БҮРТГЭСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД

Төсөл хөтөлбөрийн нэр	Бүртгэлийн дугаар	Хэрэгжиж дууссан огноо
1 Ханбогд сумын сургууль цэцэрлэгийн цогцолборын барилга, зураг төсөл, тоног төхөөрөмж	SI/НДБ-2016-03	2019-12-05
2 Ханбогд суман дахь сум дундын малын эрүүл мэндийн төвийн барилга, зураг төсөл, тоног төхөөрөмж	SI/НДБ-2016-06	2018-12-17

	Төсөл хөтөлбөрийн нэр	Бүртгэлийн дугаар	Хэрэгжиж дууссан огноо
3	Манлай сумын уурын зуух	SI/НДБ-2016-07	2018-12-27
4	Дулаан хангамж	SI/НДБ-2017-02	2019-09-11
5	Баян-Овоо сумын сургуулийн дотуур байрны зураг төсөл	SI/НДБ-2017-03	2018-08-30
6	Даланзадгад сумын Төвийн хэсгийн автозамын гадаргуугийн ус зайлуулах шугам	SI/НДБ-2017-04	2019-12-02
7	Ханбогд сумын сургуулийн нийтийн бие засах газар	SI/НДБ-2017-05	2017-12-20
8	Ханбогд суманд үерийн далан байгуулах ажлын зураг төсөл, төсөв	SI/НДБ-2017-06	2018-10-10
9	Даланзадгад сумын 11-р цэцэрлэгийн дэргэдэх 100 хүүхдийн цэцэрлэг	SI/НДБ-2017-08	2019-10-21
10	Манлай сумын эрүүл мэндийн төвийн 15 ортой шинэ барилгын зураг төсөл	SI/НДБ-2018-04	2018-11-23
11	Ханбогд сумын мод үржүүлгийн газар байгуулах	EM/БОМ-2016-01	2019-04-12
12	Манлай сумын "Говийн ойн төгөл" хөтөлбөр	EM/БОМ-2016-03	2019-10-14
13	Даланзадгад сумын хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох төсөл болон холбогдох барилга байгууламжийн зураг, төсөв боловсруулах ажил	EM/БОМ-2017-04	2019-01-08
14	Хөрс эрдэнэ	EM/БОМ-2018-01	2019-12-12
15	Хүний наймааны хохирогч болон цагаачдын эрхийг хамгаалах	SBS/НСҮ-2016-06	2019-02-21

Төсөл хөтөлбөрийн нэр	Бүртгэлийн дугаар	Хэрэгжиж дууссан огноо
16 Залуу манлайлагч	SBS/HCY-2016-08	2019-04-12
17 Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	SBS/HCY-2017-04	2019-07-17
18 Эх хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний багаж тоног төхөөрөмжийн хүрэлцээ нөлөөлөх нь	SBS/HCY-2017-11	2019-01-14
19 Зөвлөх профессорын баг	SBS/HCY-2017-15	2019-04-12
20 Уул уурхайн салбарын ажиллах хүчин бэлтгэх хөтөлбөр	SBS/HCY-2018-02	2019-12-16
21 Дотуур байр-хүүхдийн ээлтэй орчин	SBS/HCY-2018-03	2019-12-26
22 Мал угаалга, хашаа хорооны ариутгал халдваргүйжүүлэлт- 2019	ТАН/МАА-2019-02	2019-11-28
23 Аялал жуулчлалын салбарын хөгжил-жуулчдыг татах сургалт, сурталчилгаа	NHC/YTC-2016-03	2018-08-29
24 Хөдөөгийн соёл-хөгжлийн түүчээ	NHC/YTC-2017-03	2019-04-12
25 Батмөнх даян хааныг алдаршуулах- Эрдэм шинжилгээ, судалгаа сэдэвт бага хурал	NHC/YTC-2018-04	2019-12-26
26 Гашуун сухайт боомтын ундны усыг цэвэршүүлэх байгууламж	SBS/HCY-2018-01	2019-11-14

»» ХЭРЭГЖИЖ БАЙГАА ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

Сангийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийг хүлээн авахаас эхлэн хаах хүртэлх бүх үе шатанд хяналт тавьж захиалагч, ашиглагч, гүйцэтгэгч болон хүлээн авагчидтай харилцаа холбоотой хамтран ажиллаж байна.

ҮЕ ШАТНЫ ХЯНАЛТ

1-Р ҮЕ ШАТ САНАЛ ХҮЛЭЭН АВАХ

- Төсөл санаачлагч төслийн ерөнхий мэдээлэл, хүрээ болон бусад материалаыг тогтвортой байдлыг хангах төлөвлөгөөтэй хамт санд ирүүлдэг
- Төслийг цаашид авч явах захиалагч үйл ажиллагааны зардлаа тодорхой болгоно

2-Р ҮЕ ШАТ ҮНЭЛЭХ, БАТЛАХ

- Харилцааны хороо, Удирдах зөвлөл төслийн материалыг хянаж үзэн сангийн бичиг баримтууд, Хамтын ажиллагааны гэрээ болон аймаг сумдын төлөвлөгөөтэй уялдаж байгаа эсэхэд үнэлгээ өгнө
- Барилга байгууламж барих төсөл дээр захиалагч нь цаашид авч явах төсөвтэй эсэхийг нягтална

3-Р ҮЕ ШАТ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

- Төсөл хэрэгжүүлэхэд оролцож байгаа талууд гэрээний эрх, үүрэг хариуцлагаа ухамсарлан хүлээн зөвшөөрч байгаа эсэхэд хяналт тавина
- Гэрээгээр биелүүлэх ажлын гүйцэтгэлийн үзүүлэлт, хяналтын тогтолцоог талууд бүрэн хүлээн зөвшөөрч байгаа эсэхэд хяналт тавина

4-Р ҮЕ ШАТ ХЭРЭГЖИЛТ

- Гэрээгээр биелүүлэх ажлын гүйцэтгэлийн үзүүлэлтэд тулгуурлан ХДС, зохиогч, захиалагч, болон ОТ ХХК-иас хяналт тавина

5-Р ҮЕ ШАТ ХЭРЭГЖҮҮЛЖ ДУУСГАХ, ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ

- Хүлээн авч комиссын акт үйлдэх
- Улс, орон нутгийн өмчид бүртгэх
- Захиалагч үйл ажиллагааг авч явах баг бүрдүүлэх: ажилчин, албан хаагчдыг ажилд авах
- Захиалагч үйл ажиллагааны зардлыг хариуцан авч явах
- Захиалагч гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээг хүлээн авч тогтвортой байдлыг хангана

6-Р ҮЕ ШАТ ХҮЛЭЭЛГЭН ӨГСНИЙ ДАРАА

- Тогтвортой байдлыг хангах, судалгаа явуулах
- ОТ ХХК, ХДС, хөндлөнгийн судалгааны байгууллага, хувь хүнээр үнэлгээ хийлгэж, зөвлөмж авах

»» НИЙГМИЙН ДЭД БҮТЭЦ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

Ашиглалттай холбоотой мэдээлэл

- 2015-2019 оны хооронд 32.7 тэрбум төгрөгийн төсөв бүхий нийгмийн дэд бүтцийн 33 төсөл хэрэгжүүлж байна.
- Эдгээр төслүүдийн 24 нь бүрэн хэрэгжиж дууссан бөгөөд хүлээлгэн өгч ашиглалтад оруулсан.
 - Эдгээр төслийн хүрээнд баригдсан барилгуудын ашиглалт 50-100 хувь, дунджаар 95 хувьтай байна.
- 5 төсөл хэрэгжиж байгаа бөгөөд 80 хүртэлх хувийн гүйцэтгэлтэй байна.
 - Өмнөговь аймгийн музейн барилга
 - Ханбогд сумын цахилгаан шугамын өргөтгөл
 - Ханбогд сумын хог хаягдлын менежмент
 - Ханбогд сумын үерийн далан барих ажил
 - Ханбогд сумын өвс тэжээлийн агуулах

Иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангах тухайд

- Урьд нь байсан нөөц бололцоо, багтаамжийг нэмэгдүүлсэн- 10 төсөл
 - 2017 онд Ханбогд болон Манлай сумдын халаалтыг 140 хувиар нэмэгдүүлсэн бол 2019 онд Баян-Овоо суманд уурын зуухыг шинээр барьж ашиглалтанд оруулснаар хүчин чадал 3 дахин өсч, одоогийн байдлаар хэрэглэгчдийн тоо 24 хувиар өссөн
 - Малын эрүүл мэндийн цогц үйлчилгээг нэвтрүүлж байна
- Иргэдэд үзүүлэх үйлчилгээг шинэчилж, сайжруулсан -6 төсөл
 - 2017 онд Гашуун сухайт боомтод ус цэвэршүүлэх байгууламж төслөөр боомт орчмын иргэдэд шүүж цэвэршүүлсэн усны нөөцтэй болгосон, Даланзадгад сумын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулсан, Ханбогд сумын сургуулийн нийтийн ариун цэврийн барилгыг барьж ашиглалтад оруулсан, Ханбогд, Манлай сумдын төвийн дулааны эх үүсвэрийг сайжруулан хоногийн 24 цаг дулаан байж болохуйц халаалттай болгосон.
 - 2018 онд Ханбогд суманд Сум дундын малын эрүүл мэндийн төвийг барьж ашиглалтад оруулж малын эмч нарыг бэлтгэж байгаа бөгөөд Даланзадгад сумын төвийн хэсэгт ус зайлуулах шугам тавьсан.
 - 2019 онд Өмнөговь аймагт махны үйлдвэрийн барилга барьж чанартай мах, махан бүтээгдэхүүнээр Өмнөговь аймгийн иргэдийг хангах боломж бүрдүүлсэн.

Асуудал/Зөвлөмж

- Барилгын ажлыг хүйтний улиралд гүйцэтгэхгүй тал дээр анхаарч, тендерийг төлөвлөж шуурхай зарлан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж шийдвэрлэж байх.
- Зураг төслийн гүйцэтгэлийн чанарт анхаарах, холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллах

N	Төслийн нэр	Ерөнхий мэдээлэл				ОТ-н хөрөнгө оруулалт		Ашиглалтын үзүүлэлт				Биелэлтийг хэмжих үзүүлэлт					
		Ашигласандаа орсон огноо	Ашиглагч	Захиалагч	Байгууллагын төрөл	Төсөв	Эх үүсвэр	Санхүүжилт (т)	Даяа, бартамж	2019 оны ашиглалт	Хувь	Асуудал	Үзүүлэлт	Төсөөс өмнөх үзүүлэлт	2019 оны үзүүлэлт	Өөрчлөлт	Бий болсон/болгох ажлын байр
1	ДЗ 25-р цэцэрлэг	2016	ДЗ 25-р цэцэрлэг	Орон нутаг	Ашгийн бус	Улсын, орон нутгийн төсөвт	ХДС	1,8 тэрбум	200	327	100%	байхгүй	Хамрагдсан хүүхдийн тоо	0	327	+59%	31
2	ДЗ 26-р цэцэрлэг	2016	ДЗ 26-р цэцэрлэг	Орон нутаг	Ашгийн бус	Улсын, орон нутгийн төсөвт	ХДС	2,2 тэрбум	200	288	100%	байхгүй	Хамрагдсан хүүхдийн тоо	0	288	+35%	34
3	БО ЭМТ	2017	БО эрүүл мэндийн төв	Орон нутаг	Ашгийн бус	Орлогоор санхүүждэг	ХДС	1,1 тэрбум	10 ортой	15 ортой	100%	байхгүй	Эмчлүүлж буй өвчний тоо	10	15	+50%	-
4	ДЗ 2-р сургуулийн заал	2017	ДЗ 2-р сургууль	Орон нутаг	Ашгийн бус	Улсын, орон нутгийн төсөвт	ХДС	796,9 сая	768	830	100%	байхгүй	Байгууламжийг ашиглаж байгаа хүүхдийн тоо	0	830	+8%	-
5	Манлай сумын уурын зуух (3,2 МВт)	2017	Манлай сумын уурын зуух	Орон нутаг	Ашгийн бус	Орлогоор санхүүждэг	ХДС	929,1 сая	3,2МВ (2 зуух тус бүр 1,6МВ)	3,2мв (2 зуух)	100%	байхгүй	Халаалтанд холбогдсон байгууламжийн тоо	5 барилга	29628м2 5 барилга, 67 өрх	+100%	8
6	Ханбогд сумын уурын зуух (1,8 МВт)	2017	Хандизель ХХК	Орон нутаг	Ашгийн бус	Орлогоор санхүүждэг	ХДС, Сумын ЗДТГ	365,7 сая	5МВ (3 зуух тус бүр 1,8МВ)	1,8мв (1 зуух)	100%	байхгүй	Халаалтанд холбогдсон байгууламжийн тоо	6 барилга (38000м3)	10 барилга	+40%	6
7	ХБ сумын сургуулийн бие засах газар	2017	ХБ сумын сургууль	Орон нутаг	Ашгийн бус	Орон нутгийн төсөвт	ХДС	39,6 сая	9 тасалгаатай	9 тасалгаатай	100%	байхгүй	Бие засах газар ашиглаж буй сурагчийн тоо	0	9	+7%	-
8	Ханбогд сумын сургууль цэцэрлэгийн цогцлобор	2018	Ханбогд сумын сургууль, цэцэрлэг	Орон нутаг	Ашгийн бус	Улсын, орон нутгийн төсөвт	ХДС	7,2 тэрбум	360 сурагч 300 хүүхэд	1070 сурагч	100%	байхгүй	Хамрагдсан хүүхдийн тоо	660	1070	+127%	92
9	Сум дундын малын эрүүл мэндийн төв	2018	Мал аж ахуй хариуцсан нэгж	Улсын	Ашгийн бус	Улсын, орон нутгийн төсөвт	ХДС	1,4 тэрбум	Үйл ажиллагаа явуулж эхлээгүй	1070 сурагч	50%	Ажиллах хүчин бэлтгэж байна	Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан малын тоо	Одоогоор мөрдөөлөл байхгүй	-	7	

N	Төслийн нэр	Ерөнхий мэдээлэл				ОТ-н хөрөнгө оруулалт		Ашиглалтын үзүүлэлт				Биелэлтийг хэмжих үзүүлэлт					
		Ашиглатад орсон огноо	Ашиглагч	Захиалагч	Байгууллагын төрөл	Төсөв	Эх үүсвэр	Санхүүжилт (₮)	Даац, багтамж	2019 оны байдлаар ашиглалт	Хувь	Асуудал	Үзүүлэлт	Төлөөс өмнөх үзүүлэлт	2019 оны үзүүлэлт	Өөрчлөлт	Бий болсон/болгох ажлын байр
10	ДЭ эко автобус	2018	ДЗ захирагчийн алба	Орон нутаг	Ашгийн бус	Орлогоор санхүүждэг	ХДС, Аймгийн ЗДТГ	396 сая	80 суудалтай (8 автобусанд тус бүр 10 хүн зорчиж байна)	75%	2 жолооч бэлтгэж байна	Эко автобусны Тоо	0	8	+100%	15	
11	ДЭ сумын төвийн ус зайлуулах шугам	2018	ӨМ ЗДТГ	Орон нутаг	Ашгийн бус	Орон нутгийн төсөвт	ХДС, ӨМ ЗДТГ	2.7 тэрбум	Даланзадгад сумын төвд 6.5 км ус зайлуулах шугам татсан	100%	байхгүй	Ус зайлуулах шугамын урт	0	6,5 км	+100%	-	
12	ДЭ 11-р цэцэрлэгийн өргөтгөл	2018	ДЗ сумын 11-р цэцэрлэг	Орон нутаг	Ашгийн бус	Улсын, орон нутгийн төсөвт	ХДС	1,4 тэрбум	100	100%	байхгүй	Хамрагдсан хүүхдийн тоо	0	273	7		
13	Гашуун сухайт боомтын ундны ус цэвэршүүлэх байгууламж	2018	Гашуунсухайт боомт	Орон нутаг	Ашгийн бус	Улсын, орон нутгийн төсөвт	ХДС	1099 сая	3 шүүлтүүр	100%	байхгүй	Цагт шүүх усны хэмжээ	0	2tons/hour	1		
14	Мах жижиглэн ангиллах, хиамны үйлдвэр	2019	Гүүд Рүүт Итер Трейдинг	Орон нутаг	Ашгийн бус	Орлогоор санхүүжнэ	ХДС, Гүүд Рүүт Итер Трейдинг	4.8 тэрбум	3000м2, 2 давхар үйлдвэрийн барилга, 400 тонн мах хадгалах агуулах	100%	байхгүй	Мах боловсруулах, хадгалах хэмжээ	Одоогоор мэдээлэл байхгүй			25	
15	Жаргалтай хүүхдүүд	2018	Ханбогд сумын цэцэрлэг	Орон нутаг	Ашгийн бус	Улсын орон нутгийн төсөвт	ХДС	14.5 сая	24 хүүхдийн 2 анги нээсэн	100%	байхгүй	Хамрагдсан хүүхдийн тоо	0	24	20%	5	
16	Усан халаагуурын тогтоо, тоног төхөөрөмж	2018	Баяндагай сумын уурын зуух	Орон нутаг	Ашгийн бус	Орлогоор санхүүждэг	ХДС, Орон нутас	ХДС 69.4 сая	1400 кв чадалтай 1 зуух	100%	байхгүй	Халаалтанд холбогдсон байгууллагын тоо	5	байгууллага, 23 айл өрх			
17	Эко автобусны цахим систем	2018	Даланзадгад сумын Захирагчийн ажлын алба	Орон нутаг	Ашгийн бус	Орлогоор санхүүждэг	ХДС	1500 ш карт, 1500 ш карт, карт уншигч	1500 ш карт, карт уншигч	100%	байхгүй	Цахим картны тоо	0	1500	+100%		

N	Төслийн нэр	Ерөнхий мэдээлэл				ОТ-н хөрөнгө оруулалт		Ашиглалтын үзүүлэлт				Биелэлтийг хэмжих үзүүлэлт				
		Ашиглалтад орсон онноо	Ашиглагч	Захиалагч	Байгууллагын төрөл	Төсөв	Эх үүсвэр	Санхүүжилт (₮)	Даяа, бартамж	2019 оны ашиглалт	Хувь	Асуудал	Үзүүлэлт	Төсвөөс өмнөх үзүүлэлт	2019 оны үзүүлэлт	Өөрчлөлт
18	Халуун ус	2018	Манлай ЭДТГ	Орон нутаг	Ашгийн	Орлогоор санхүүждэг	ХДС	29.8 сая	Халуун усны газар	100%	байхгүй	Халуун усны ерөөний тоо	0	1	+100%	
19	Соёл, спортын хөгжил	2018	Манлай ЭДТГ	Орон нутаг	Ашгийн	Орлогоор санхүүждэг	ХДС	58.6 сая	Орчин нөхцөл сайжруулсан	100%	байхгүй	Орчин нөхцөл сайжруулсан			+100%	
20	Цэцэрлэгт хүрээлэн байгуулах	2018	Номгон ЭДТГ	Орон нутаг	Ашгийн бус	Улсын орон нутгийн төсөвт	ХДС	56 сая	Олон нийтийн амралт, зугаалтын газар	100%	байхгүй	Амьдрах орчин нөхцөл сайжирсан			+100%	
21	Баян-Овоо сумын уурын зуух (2 МВт)	2019	7 шар цаг ОНӨТҮГ	Орон нутаг	Ашгийн	Орлогоор санхүүждэг	ХДС	901.8 сая	4МВ (2 зуух тус бүр 2МВ)	100%	байхгүй	Халаалтанд холбогдсон байгууламжийн тоо	29 айл өрх, 12 байгууллага	36 айл өрх, 12 байгууллага	+17%	
22	Манлай сумын цэцэрлэг, тоног төхөөрөмж	2019	Манлай сумын цэцэрлэг	Орон нутаг	Ашгийн бус	Улсын орон нутгийн төсөвт	ХДС	1.7 тэрбум	100 хүүхдийн цэцэрлэг	100%	байхгүй	Хамрагдсан хүүхдийн тоо	0	100	+100%	13
23	Гэрлүүлгийн ажил	2019	Баяндалай ЭДТГ	Орон нутаг	Ашгийн бус	Улсын орон нутгийн төсөвт	ХДС	52.9 сая	60 ш гудамжны гэрэлтүүлэг, 5 ш цамхагт гэрэлтүүлэг	100%	байхгүй	Суурилуулсан гэрлийн тоо	0	65	+100%	
24	Гэрлэн Дохио	2019	Даланзадгад ЭДТГ	Орон нутаг	Ашгийн бус	Улсын орон нутгийн төсөвт	ХДС	70 сая	Уулзварын 4 ш гэрлэн Дохио	100%	байхгүй	Суурилуулсан гэрлэн дохионы тоо	0	4	+100%	
25	Мандал-Овоо сумын эрүүл мэндийн төв	2019	Мандал-Овоо эмнэлэг	Орон нутаг	Ашгийн бус	Улсын орон нутгийн төсөвт	ХДС	1.2 тэрбум ₮	10 ортой эрүүл мэндийн төвийн барилга	100%	байхгүй	ЭМТ-ийн орны тоо	0	10	100%	

»» ХЭРЭГЖИЖ БАЙГАА ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРҮҮД

№	Төсөл хөтөлбөрийн нэр	Хүрэх үр дүн	Хөтөлбөрийн явц	Хяналт шинжилгээ үнэлгээ
1	Оюу хүлэмж	2016-2026 оны хооронд Өмнөговь аймгийн иргэдэд хөнгөлөлттэй үнээр хүлэмж олгох	2016-2018 оны хооронд хүлэмж хөнгөлөлттэй үнээр өгсөн	Санхүүжилтийн гэрээний дагуу төслийн үе шат бүрд хяналт, үнэлгээ хийсэн
2	Чадварлаг эмч	БОЭТ-д 32 ширхэг хяналтын камер суурилуулж мэс засал, гэмтлийн тасаг, цусны амбулаторын хэсгийн тохижилтын ажлыг гүйцэтгэж, нярайн тасагт тоног төхөөрөмж суурилуулан, Дорноговь аймгийн эмч нараас туршлага судлан 332 эмч мэргэжилтэнд сургалт явуулсан.	Гэрээний дагуу ажлаа хийж байна.	Санхүүжилтийн гэрээний дагуу төслийн үе шат бүрд хяналт, үнэлгээ хийсэн
3	БОЭТ-ийн шүдний кабинет тохижуулах	БОЭТ-д 77 төрлийн 601 багаж, тоног төхөөрөмж нийлүүлэх	Баталгааны хугацаа эхэлсэн	Санхүүжилтийн гэрээний дагуу төслийн үе шат бүрд хяналт, үнэлгээ хийсэн
4	Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийг дэмжих хамтарсан хөтөлбөр	4 жилийн хугацаанд 6 зорилтын хүрээнд Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ	2018-2019 оны ажлыг гүйцэтгэж ажлаа дүгнэж байна	Санхүүжилтийн гэрээний дагуу төслийн үе шат бүрд хяналт, үнэлгээ хийж байна. Мөн төслийн техникийн ажлын хэсэг, удирдах хорооны хурлуудаар төслийн хэрэгжилтийг үнэлж, дүгнэж байна.
5	Үндэсний өв соёл, мэдлэг ухааныг хүүхэд залууст өвлүүлэн үлдээх сургалт	Ханбогд сумын ахмадууд тус сумын 6-9-р ангийн давхардсан тоогоор 2606 хүүхдэд өв соёлын талаар сургалт явуулах	Сүүлийн үе шатны сургалт зохион байгуулж байна	Санхүүжилтийн гэрээний дагуу төслийн үе шат бүрд хяналт, үнэлгээ хийсэн.

№	Төсөл хөтөлбөрийн нэр	Хүрэх үр дүн	Хөтөлбөрийн явц	Хяналт шинжилгээ үнэлгээ
6	Түүх соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтыг сайжруулах	Зорилтот сумдын үл хөдлөх 42 дурсгалт газрыг хамгаалалтанд авч хаягжуулан гэрээт хамгаалагчдыг үнэмлэхжүүлэх ажил хийх	Сүүлийн үе шатны ажил хийж байгаа	Санхүүжилтийн гэрээний дагуу төслийн үе шат бүрд хяналт, үнэлгээ хийсэн
7	Өмнөговь аймгийн жижиг дунд бизнесийг хөгжүүлэх хөтөлбөр	Даланзадгад суманд “Өмнөговь аймгийн жижиг дунд бизнесийг хөгжүүлэх” хөтөлбөрийг 3 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ	Жижиг дунд бизнесийг дэмжих төв байгуулах ажил хийж байна	Санхүүжилтийн гэрээний дагуу төслийн үе шат бүрд хяналт, үнэлгээ хийж байна. Мөн төслийн техникийн ажлын хэсэг, удирдах хорооны хурлуудаар төслийн хэрэгжилтийг үнэлж, дүгнэж байна.
8	Оюу хүлэмж-2	Газар тариалан эрхлэгч иргэд, аж ахуй нэгжид 97 ширхэг ижил загварын нийлэг хүлэмжийг хөнгөлөлттэй үнээр олгох	Өмнөговь аймгийн Хүнс Хөдөө Аж Ахуйн газарт хүлэмжийг нийлүүлсэн байгаа бөгөөд хүлэмж олгох журмыг боловсруулан цаг агаар дулаарахад иргэд, аж ахуй нэгжүүдэд хүлэмж олгож эхэлнэ	1-р үе шатны хяналт хийсэн
9	Ханбогд сумын хог хаягдлын менежмент	Ханбогд суманд хог хаягдлын ландфиллын байгууламж барина	Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийж байгаа	Гэрээ байгуулахаас өмнөх хяналт, шинжилгээ хийсэн
10	Ханбогд сумын өвс тэжээлийн агуулах	Ханбогд сумын малчдад зориулсан өвс тэжээлийн агуулах барина	Гүйцэтгэл 80%-тай байна	1-р үе шатны хяналт хийсэн
11	Ботгон тэшээ бүжгийн багийн хувцас	Ботгон тэшээ бүжгийн багийн 60 ширхэг хувцас хийж нийлүүлнэ	Гүйцэтгэл 90%-тай байна	1-р үе шатны хяналт хийсэн
12	Батмөнх Даян хааныг алдаршуулах-Магтаал	Батмөнх Даян хааны үеийн Монголыг магтан дуулсан 5 минутын клип хийнэ	Гүйцэтгэл 70%-тай байна	1-р үе шатны хяналт хийсэн

№	Төсөл хөтөлбөрийн нэр	Хүрэх үр дүн	Хөтөлбөрийн явц	Хяналт шинжилгээ үнэлгээ
13	Өмнөговь аймгийн цамын бүжгийн хувцас	Өмнөговь аймгийн цамын бүжгийн 78 хувцас, хэрэглэл хийж нийлүүлнэ	Гүйцэтгэл 80%-тай байна	1-р үе шатны хяналт хийсэн
14	Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын баримтат, хөрөг нэвтрүүлэг	20-30 минутын соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын баримтат, хөрөг нэвтрүүлэг хийж олны хүртээл болгоно	Гүйцэтгэгч сонгон шалгаруулж байгаа	
15	Үндэсний өв соёл, мэдлэг ухааныг хүүхэд залууст өвлүүлэн үлдээх сургалт	Ханбогд сумын ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдэд уламжлалт амьдрах ухаан, өв соёлын талаар сургалт хийнэ	Гүйцэтгэл 90%-тай байна	2-р үе шатны хяналт хийсэн
16	Өмнөговь аймгийн хүлэмжийн аж ахуйн цогцолбор хөгжүүлэх хөтөлбөр	Даланзадгад суманд 5 нийлэг хальсан хүлэмж бүрэн усалгааны системийн хамт суурилуулан аймгийн 4 хөдөө аж ахуйн мэргэжилтэнг БНСУ-д сургалтанд явуулж чадавхжуулна	Гүйцэтгэлийн баталгаажуулалт хүлээгдэж байна.	2-р үе шатны хяналт хийсэн
17	Дизайн технологийн кабинетийн тохижилт	Манлай сумын сургуульд дизайн технологийн кабинет байгуулж 36 төрлийн 270 багаж хэрэгсэл нийлүүлнэ	Баталгааны хугацаанд байна	1-р үе шатны хяналт хийсэн
18	Аюулгүй хашаа	Даланзадгад сумын 4-р сургуулийн хашааг хүүхдэд ээлтэй байдлаар засч хяналтын камер суурилуулах	Баталгааны хугацаанд байна	1-р үе шатны хяналт хийсэн
19	Ахмад настанд ээлтэй орчин	Өмнөговь аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний дэргэдэх ахмадын сувилалд 15 төрлийн 27 тоног төхөөрөмж нийлүүлж, Баяндалай суман дахь гадна тохижилтын ажил хийх	Баталгааны хугацаанд байна	1-р үе шатны хяналт хийсэн

»» ХАРИЛЦАГЧ БАЙГУУЛЛАГУУД-2019

№	Харилцагч байгууллагын нэр	Холбоо хамаарал
1	Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газар	Хамтын ажиллагааны гэрээний нэг тал
2	Ханбогд сумын Засаг даргын тамгын газар	Хамтын ажиллагааны гэрээний нэг тал, түншлэгч сум
3	“Оюу толгой” компани	Хамтын ажиллагааны гэрээний нэг тал, хөрөнгө оруулагч байгууллага
4	Даланзадгад сумын засаг даргын тамгын газар	Даланзадгад суманд хэрэгжиж байгаа төслүүдийн захиалагч, түншлэгч сум, квотын санхүүжилт хүлээн авсан сум
5	Манлай сумын Засаг даргын тамгын газар	Манлай суманд хэрэгжиж байгаа төслүүдийн захиалагч, түншлэгч сум, квотын санхүүжилт хүлээн авсан сум
6	Баян-Овоо сумын Засаг даргын тамгын газар	Баян-Овоо суманд хэрэгжиж байгаа төслүүдийн захиалагч, түншлэгч сум, квотын санхүүжилт хүлээн авсан сум
7	Баяндалай сумын Засаг даргын тамгын газар	Баяндалай суманд хэрэгжиж байгаа төслүүдийн захиалагч, уул уурхайгүй сум, квотын санхүүжилт хүлээн авсан сум
8	Сэврэй сумын Засаг даргын тамгын газар	Сэврэй суманд хэрэгжиж байгаа төслүүдийн захиалагч, уул уурхайгүй сум, квотын санхүүжилт хүлээн авсан сум
9	Номгон сумын Засаг даргын тамгын газар	Номгон суманд хэрэгжиж байгаа төслүүдийн захиалагч, уул уурхайгүй сум, квотын санхүүжилт хүлээн авсан сум
10	Булган сумын Засаг даргын тамгын газар	Булган суманд хэрэгжиж байгаа төслүүдийн захиалагч, уул уурхайгүй сум, квотын санхүүжилт хүлээн авсан сум
11	Цогт-Овоо сумын Засаг даргын тамгын газар	Цогт-Овоо суманд хэрэгжиж байгаа төслүүдийн захиалагч, уул уурхайгүй сум, квотын санхүүжилт хүлээн авсан сум
12	Мандал-Овоо сумын Засаг даргын тамгын газар	Мандал-Овоо суманд хэрэгжиж байгаа төслүүдийн захиалагч, уул уурхайгүй сум, квотын санхүүжилт хүлээн авсан сум
13	“Вентана констракшн” ХХК	Манлай сумын цэцэрлэгийн барилгын гүйцэтгэгч байгууллага
14	“Арц суварга” ХХК	Ханбогд сумын үерийн далан, сувгийн ажлын гүйцэтгэгч байгууллага
15	“Шүтээн-Эрдэнэ” ХХК	Баян-Овоо сумын уурын зуухны барилгын гүйцэтгэгч байгууллага
16	“Логмон” ХХК	Ханбогд сумын өвс тэжээлийн агуулахын барилгын гүйцэтгэгч байгууллага

№	Харилцагч байгууллагын нэр	Холбоо хамаарал
17	Өмнөговь аймгийн мал эмнэлгийн газар	Мал угаалга, хашаа хорооны ариутгал, халдваргүйжүүлэлт-2019 хөтөлбөрийн гүйцэтгэгч байгууллага
18	Хөдөө аж ахуйн сургууль, мал аж ахуй, биотехнологийн сургууль	“Ханбогд суман дахь сургууль цэцэрлэгийн цогцолборын менежментийг сайжруулах” төслийн гүйцэтгэгч байгууллага
19	“Мөнх ногоон тал” ХХК	Оюу хүлэмж-2 хөтөлбөрийн гүйцэтгэгч байгууллага
20	“Говь хангайн андууд” ХХК	Ботгон тэшээ бүжгийн хувцас хийх төслийн гүйцэтгэгч байгууллага
21	Монголын баг, сумдын үндэсний холбооны Өмнөговь аймаг дахь салбар	Батмөнх Даян хааныг алдаршуулах төслийн хэрэгжүүлэгч байгууллага
22	“Өвт говь” ТББ	Батмөнх Даян хааныг алдаршуулах төслийн хэрэгжүүлэгч
23	“Өмнөговь цам” Сан	Цамын хувцас багийг иж бүрэн хийх төслийн гүйцэтгэгч
24	“Дүжий хайрхан” ХХК	Өмнөговь аймгийн музейн гадна шугам сүлжээг гүйцэтгэгч байгууллага
25	“Тангад-Араа” ХХК	Өмнөговь аймгийн музейн сан хөмрөгийн өрөөний тоног төхөөрөмжийг нийлүүлэгч байгууллага
26	“Элбэг туулай” ХХК	Манлай сумын цэцэрлэгийн тоног төхөөрөмж
27	“Баянговь ус” ХХК	Бугын худаг төслийн гүйцэтгэгч байгууллага
28	Нэгдсэн үндэстний байгууллагын Хүн амын сан	“Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийг дэмжих хамтарсан хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэгч байгууллага
29	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан	“Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийг дэмжих хамтарсан хөтөлбөр”-ийг хамтран санхүүжүүлэгч байгууллага
30	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага	“Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийг дэмжих хамтарсан хөтөлбөр”-ийг хамтран санхүүжүүлэгч байгууллага
31	Авсралийн Засгийн газар	“Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийг дэмжих хамтарсан хөтөлбөр”-ийг хамтран санхүүжүүлэгч
32	Монгол Улсын Засгийн газар	“Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийг дэмжих хамтарсан хөтөлбөр”-ийг хамтран санхүүжүүлэгч
33	Жи Ай Зэт	“Өмнөговь аймгийн жижиг дунд бизнесийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хамтран санхүүжүүлэгч, хэрэгжүүлэгч
34	“Говийн өгөөж” хоршоо	Ханбогд сумын квотын санхүүжилтээр “Галбын өгөөж” төсөл хэрэгжүүлсэн байгууллага

№	Харилцагч байгууллагын нэр	Холбоо хамаарал
35	Х.Амбаа	Ханбогд сумын квотын санхүүжилтээр “Монгол ардын дуу” төсөл хэрэгжүүлсэн иргэн
36	Д.Ганбат	Ханбогд сумын квотын санхүүжилтээр “Өнө мөнхөд өөдлөн дэвжих өв соёл минь” төсөл хэрэгжүүлсэн иргэн
37	Д.Хүдэрбат	Ханбогд сумын квотын санхүүжилтээр “Өв соёл” төсөл хэрэгжүүлсэн иргэн
38	“Си Ай Ти” ХХК	Ханбогд сумын квотын санхүүжилтээр “Тог баригч” төсөл хэрэгжүүлсэн байгууллага
39	Ханбогд сумын ахмадын хороо	Ханбогд сумын квотын санхүүжилтээр “Эрүүл насжилт” төсөл хэрэгжүүлсэн байгууллага
40	“Мөнх ногоон галба” ТББ	Ханбогд сумын квотын санхүүжилтээр “Задгай театр” төсөл хэрэгжүүлсэн байгууллага
41	“Арц энерги” ХХК	Сэврэй сумын квотын санхүүжилтээр “Автомашин нийлүүлэх” төсөл хэрэгжүүлсэн байгууллага
42	“Агьт говь” ХХК	Сэврэй сумын квотын санхүүжилтээр “Гар урлалын төв” төсөл хэрэгжүүлсэн байгууллага
43	“Натурал морнинг” ХХК	Сэврэй сумын квотын санхүүжилтээр “Аялал жуулчлал мэдээллийн төв тохижуулах” төсөл хэрэгжүүлсэн байгууллага
44	“Саудгоби капитал” ХХК	Баяндалай сумын квотын санхүүжилтээр “Хүүхдийн тоглоомын талбай, сагсны талбай байгуулах” төсөл хэрэгжүүлсэн байгууллага
45	“Эс Жи Эм” ХХК	Баяндалай сумын квотын санхүүжилтээр “Гэрэлтүүлгийн ажил” төсөл хэрэгжүүлсэн байгууллага
46	Манлай сумын үндэсний бөхийн холбоо	Манлай сумын квотын санхүүжилтээр “Сургалтын танхимын фитнес төхөөрөмж нийлүүлэх” төсөл хэрэгжүүлсэн байгууллага
47	“Говийн яруу эгшиглэн” ХХК	Манлай сумын квотын санхүүжилтээр “Жинчид ирлээ” төсөл хэрэгжүүлсэн байгууллага
48	“Эрүүл насжилт” ТББ	Манлай сумын квотын санхүүжилтээр “Эрүүл хүүхэд-2” төсөл хэрэгжүүлсэн байгууллага
49	Х.Содбаяр	Манлай сумын квотын санхүүжилтээр “Дотуур байр, тохилог орчин” төсөл хэрэгжүүлсэн иргэн
50	Б.Бүжидмаа	Манлай сумын квотын санхүүжилтээр “Хөргүүртэй автомашин нийлүүлэх” төсөл хэрэгжүүлсэн иргэн
51	“Говийн гурван баг” хоршоо	Баян-Овоо сумын квотын санхүүжилтээр “Цэвэр усны үйлдвэр” төсөл хэрэгжүүлсэн байгууллага
52	“Дархан төгөлдөр говь” ХХК	Баян-Овоо сумын квотын санхүүжилтээр “Гамшиг, ослын үеийн бэлэн байдал” төсөл хэрэгжүүлсэн байгууллага

№	Харилцагч байгууллагын нэр	Холбоо хамаарал
53	“Тэргүүн суварга” ХХК	Баян-Овоо сумын квотын санхүүжилтээр “Говийн өв” төсөл хэрэгжүүлсэн байгууллага
54	Ц.Бямбажав	Баян-Овоо сумын квотын санхүүжилтээр “Шинэ сонголт” төсөл хэрэгжүүлсэн иргэн
55	Ч.Амартүвшин	Баян-Овоо сумын квотын санхүүжилтээр “Өв эрдэнэ” төсөл хэрэгжүүлсэн иргэн
56	Д.Ганболд	Номгон сумын квотын санхүүжилтээр “Хөвгүүдийн кабинет тохижуулах” төсөл хэрэгжүүлсэн иргэн
57	Б.Далайхүү	Номгон сумын квотын санхүүжилтээр “Эрүүл мэндийн төвд тоног төхөөрөмж нийлүүлэх” төсөл хэрэгжүүлсэн иргэн
58	Б.Бүжин	Номгон сумын квотын санхүүжилтээр “Төхөм багийн худгийн барилга тохижилт” төсөл хэрэгжүүлсэн иргэн
59	А.Ууганбаяр	Номгон сумын квотын санхүүжилтээр “Номгон сумын төвийн гэрэлтүүлэг” төсөл хэрэгжүүлсэн иргэн
60	Б.Амарзаяа	Даланзадгад сумын квотын санхүүжилтээр “Өрхийн санхүү-улсын санхүү” төсөл хэрэгжүүлсэн иргэн
61	Рехтус ХХК	Даланзадгад сумын квотын санхүүжилтээр “Бүгдэд ээлтэй төрийн үйлчилгээ” төсөл хэрэгжүүлсэн байгууллага
62	“Пирамид капитал” ХХК	Даланзадгад сумын квотын санхүүжилтээр “Смарт ДЗ” төсөл хэрэгжүүлсэн байгууллага
63	“Автозамын хөдөлгөөний хөгжлийн гарц” ТББ	Даланзадгад сумын квотын санхүүжилтээр “Гэрлэн дохио” төсөл хэрэгжүүлсэн байгууллага
64	Ж.Баатар	Даланзадгад сумын квотын санхүүжилтээр “Хог ачигч” төсөл хэрэгжүүлсэн иргэн
65	Н.Уртнасан	Даланзадгад сумын квотын санхүүжилтээр “Цахим номын сан” төсөл хэрэгжүүлсэн иргэн
66	“Вишнмежик” ХХК	Цогт-Овоо сумын квотын санхүүжилтээр “Хяналтын камер” төсөл хэрэгжүүлсэн байгууллага
67	“Хайрхан баян бор” ХХК	Цогт-Овоо сумын квотын санхүүжилтээр “Шуурхай мэдээлэл” төсөл хэрэгжүүлсэн байгууллага
68	Ц.Энхтөр	Цогт-Овоо сумын квотын санхүүжилтээр “Замын тэмдэгжүүлэлт” төсөл хэрэгжүүлсэн иргэн
69	Б.Мөнх-Ундрам	Цогт-Овоо сумын квотын санхүүжилтээр “Музей” төсөл хэрэгжүүлсэн иргэн
70	А.Гантөмөр	Цогт-Овоо сумын квотын санхүүжилтээр “Зөөврийн эрчим хүч” төсөл хэрэгжүүлсэн иргэн

№	Харилцагч байгууллагын нэр	Холбоо хамаарал
71	"Аз билэгтэй" ХХК	Цогт-Овоо сумын квотын санхүүжилтээр "Эко орчин-бүтээлч ирээдүй" төсөл хэрэгжүүлсэн байгууллага
72	"Мандал стиль" ХХК	Мандал-Овоо сумын квотын санхүүжилтээр "Ясли-хүүхэд хөгжил" төсөл хэрэгжүүлсэн байгууллага
73	"Хайрхан баян бор" ХХК	Мандал-Овоо сумын квотын санхүүжилтээр "Аюулгүй орчин-хүүхдийн ирээдүй" төсөл хэрэгжүүлсэн байгууллага
74	"Халбас хайрханы хишиг" ХХК	Мандал-Овоо сумын квотын санхүүжилтээр "Ухаалаг худаг" төсөл хэрэгжүүлсэн байгууллага
75	Б.Ичинхорол	Мандал-Овоо сумын квотын санхүүжилтээр "Хогийн цэг" төсөл хэрэгжүүлсэн иргэн
76	"Халбас хайрханы хишиг" ХХК	Мандал-Овоо сумын квотын санхүүжилтээр "Баян төгөл" төсөл хэрэгжүүлсэн байгууллага
77	"Арцат баян өндөр" ХХК	Булган сумын квотын санхүүжилтээр "Урлагийн хувцас нийлүүлэх" төсөл хэрэгжүүлсэн байгууллага
78	"Баянзаг динозавр" ХХК	Булган сумын квотын санхүүжилтээр "Тохилог орчин" төсөл хэрэгжүүлсэн байгууллага
79	"Булган гүртэн" ХХК	Булган сумын квотын санхүүжилтээр "Жишиг гудамж" төсөл хэрэгжүүлсэн байгууллага
80	"Далайван аудит" ХХК	Аудитын үйлчилгээ
81	"Сэтгэшгүй хойч" ХХК	Хэвлэлийн үйлчилгээ
82	Өнөөдөр сонин	Зар мэдээ нийтлэлийн үйлчилгээ
83	Өдрийн сонин	Хэвлэлийн үйлчилгээ
84	"Интерпресс" ХХК	Хэвлэлийн үйлчилгээ

>>> САНХҮҮГИЙН ТАЙЛАН

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

2019 оны 12-р сарын 31
(мян.төгрөг)

Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
Хөрөнгө	0.00	0.00
Эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	6,378,256.57	5,378,787.70
Богино хугацаат хөрөнгө оруулалт	748,433.31	1,130,315.87
Авлага	0.00	0.00
Эргэлтийн хөрөнгийн дүн	7,126,689.87	6,509,103.58
Эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
Үндсэн хөрөнгө	74,797.97	79,197.87
Үндсэн хөрөнгө хуримтлагдсан элэгдэл	18,060.58	32,003.01
Биет бус хөрөнгө	1,790.00	1,790.00
Биет бус хөрөнгө хуримтлагдсан элэгдэл	730.43	1,326.55
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	57,796.96	47,658.31
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	7,184,486.84	6,556,761.88
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө	0.00	0.00
Дансны өглөг	6,649,007.72	2,973,962.26
Богино хугацаат өглөгийн дүн	6,649,007.72	2,973,962.26
Өр төлбөрийн нийт дүн	6,649,007.72	2,973,962.26
Хуримтлагдсан үр дүн	535,479.11	3,582,799.62
Цэвэр хөрөнгийн дүн	535,479.11	3,582,799.62
Өр төлбөр ба цэвэр хөрөнгийн дүн	7,184,486.84	6,556,761.88

ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2019 оны 12-р сарын 31
(мян.төгрөг)

Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
Үндсэн үйл ажиллагааны орлого	0.00	0.00
Бэлэг, хандив, тусламжийн орлого	12,094,300.00	13,162,600.00
Бусад орлого	208,789.09	517,779.91
Үйл ажиллагааны орлогын нийт дүн	12,303,089.09	13,680,379.91
Үндсэн үйл ажиллагааны зардал	0.00	0.00
Бэлэг, хандив ба тусламж	175,412.56	349,088.70
Байгууллагад өгсөн хандив, тусламж	175,412.56	349,088.70
Хөтөлбөр хэрэгжүүлсний зардал	135,471.61	155,557.77
Төсөл хэрэгжүүлсний зардал	16,878,312.46	9,637,287.45
Ерөнхий удирдлагын зардал	541,482.26	491,125.49
Цалин хөлс, шагнал	171,047.98	201,829.65
Нийгмийн даатгалын шимтгэл	20,525.76	25,131.91
Засвар үйлчилгээний зардал	714.60	1,952.79
Ашиглалтын зардал	13,629.51	13,839.59
Түрээсийн зардал	16,988.40	17,038.20
Албан томилолтын зардал	4,267.49	1,600.00
Тээврийн зардал	0.00	0.00
Элэгдлийн зардал	13,566.18	14,538.56
Зар сурталчилгааны зардал	151,070.26	106,167.25
Шуудан, холбооны зардал	3,834.20	4,260.81
Шатахууны зардал	7,097.60	10,883.91
Бусад зардал	138,740.28	93,882.83
Үндсэн үйл ажиллагааны зардлын нийт дүн	17,730,678.88	10,633,059.40
Үндсэн ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	-5,427,589.78	3,047,320.51
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг, алдагдал	148,852.88	0.00
Валютын ханшийн өөрчлөлтөөс үүсэн ашиг (алдагдал)	150,000.00	0.00
Бусад	-1,147.12	0.00
Тайлант үеийн цэвэр үр дүн	-5,278,736.90	3,047,320.51

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2019 оны 12-р сарын 31
(мян.төгрөг)

Үзүүлэлт	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,814,216.01	5,814,216.01
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.	0.
Залруулсан үлдэгдэл	5,814,216.01	5,814,216.01
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт/бууралт	0.	0.
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт/бууралт	0.	0.
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.	0.
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.	0.
Тайлант үеийн цэвэр үр дүн	-5,278,736.9	-5,278,736.9
2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	535,479.11	535,479.11
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.	0.
Залруулсан үлдэгдэл	535,479.11	535,479.11
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт/бууралт	0.	0.
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт/бууралт	0.	0.
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.	0.
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.	0.
Тайлант үеийн цэвэр үр дүн	3,047,320.51	3,047,320.51
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	3,582,799.62	3,582,799.62

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2019 оны 12-р сарын 31
(мян.төгрөг)

Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
Үйл ажиллагааны мөнгөн орлого	12,256,499.70	14,446,439.86
Бэлэг, хандив, тусламж	12,244,300.00	13,162,600.00
Бусад	12,199.70	1,283,839.86
Үйл ажиллагааны мөнгөн зарлага (-)	13,803,946.24	15,576,008.17
Ажиллагчдад олгосон мөнгө	142,099.91	167,162.15
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	34,086.99	42,379.96
Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	228.80	0.00
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	18,397.78	0.00
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	13,991.65	12,840.66
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн бусад мөнгө	13,577,948.14	15,335,549.74
Төлсөн татвар	17,096.44	17,959.83
Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	96.53	115.83
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-1,547,446.54	-1,129,568.31
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
Худалдаж авсан урт хугацаат хөрөнгө	14,454.70	4,399.90
Худалдаж авсан хөрөнгө оруулалт	748,433.31	256,885.00
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	-762,888.01	-261,284.90
Санхүү үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
Хүү ба урамшууллын орлого	208,789.09	391,384.35
Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээ	208,789.09	391,384.35
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-2,101,545.45	-999,468.86
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,479,802.02	6,378,256.57
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,378,256.57	5,378,787.70

»» ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ҮР ШИМ ХҮРТЭГЧДИЙН СЭТГЭГДЭЛ

САНГИЙН САНХҮҮЖИЛТЭЭР ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ҮР ШИМ ХҮРТЭГЧДИЙН СЭТГЭГДЭЛ

МАНДАЛ-ОВОО СУМАНД САНХҮҮЖИЛТИЙН КВОТООР ХЭРЭГЖСЭН “ЯСЛИ-ХҮҮХЭД ХӨГЖИЛ” ХӨТӨЛБӨР

Сэтгэгдэл:

Сэтгэгдэл бичсэн: Б.Одхүүгийн ээж Б.Эрдэнэтуяа



Яслийн бүлэг шинээр нээгдлээ гэхэд үнэхээрийн их баярласан. Харах хүнгүй учраас хүүгээ гэртээ цоожтой үлдээх, аль эсвэл байнга авч явахаас өөр арга замгүй байдаг байлаа. Тэгээд л яслид өгнө гэхэд аав нь “За яах юм бэ? Уйлах юм биш үү? Чадах юм уу? Авах юм уу?” гээд л олон талаас нь бодож, ярилцаж байгаад өгсөн. Миний хүү үнэхээр дуртай байна.

Шинээр 2 ажлын байр нэмэгдсэн. Багш нар нь миний хүүг маш хурдан дасгаж сургасан.

Бид хоёр өглөө эрт гараад орой л гэртээ ирдэг ажилтай. Миний хүүг гэртээ ганцаараа цоожтой байх эрсдэлээс гаргаж, хүүдээ сэтгэл зовохгүй ажлаа хийх нөхцөл боломжоор хангаж, эрүүл аюулгүй орчинд эрүүл ахуйн зөв дадал хэвшилд суралцуулан нийгэмшүүлж, төрөл бүрээр хөгжүүлж байгаад чин сэтгэлээсээ баяртай байна.

Анх 2 хүртэлх насны 15 хүүхэд анх авсан. Одоо бүр 19 хүүхэд болчихсон байгаа. Энэ олон хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, эцэг эхчүүдийн ажлын бүтээмжийг сайжруулсан ийм сайхан төсөл санаачлан хэрэгжүүлж байгаа Ч.Мөнхжаргал эрхлэгчтэй цэцэрлэгийн эвсэг бүтээлч хамт олонд болон төслийг дэмжиж хөрөнгө оруулалт хийсэн “Говийн оюу хөгжлийн сан”-ийн хамт олонд талархал илэрхийлж ажлын амжилт хүсье.

СЭВРЭЙ СУМАНД САНХҮҮЖИЛТИЙН КВОТООР ХЭРЭГЖСЭН “ГАР УРЛАЛЫН ТӨВ” ХӨТӨЛБӨР

Сэтгэгдэл:

Хөтөлбөрийн үр шим хүртэгч Д.Хүрэлбаатар:



төрөл бүрийн гоё зүйлс хийхээр төлөвлөсөн байгаа.

Би гар урлалын сургалтанд хамрагдах гээд чадахгүй, завдахгүй байж байгаад 2020 оны нэгдүгээр сарны 15, 16, 17-нд нэгэн найзынхаа хамт ирж СНАХМэргэжилтэн П.Бямбадэлгэрээр заалган арьсан урлалын бүтээгдэхүүн урлах анхан шатны мэдлэг, дадлагатай боллоо. Би 2006 оноос хоош ажил эрхлээгүй өдий хүрсэн. Гэрээр байдаг, хөдөө малын ажлаас өөр ажил эрхэлж байгаагүй болохоор энд ирээд юм хийгээд суухад тун сонирхолтой байлаа. Цагаа зөв өнгөрөөж, ерхийн орлогоо нэмэгдүүлнэ, төрөл бүрийн чадвар эзэмших олон давуу тал байна. Миний хувьд чөлөөт цагаараа ирж арьсан урлалын бүтээгдэхүүн хийх олон санаа олсон байгаа. Гэрээр байгаа гар доорх бэлэн материал ашиглаж

Хөтөлбөрийн үр шим хүртэгч Д.Булгантамир:



Би 2019 оны тавдугаар сард дөрөв дэх охиноо гаргаж, одоо гэрээр хүүхдээ харж байна. 2019 оны арваннэгдүгээр сараас найз Д.Долгорсүрэнгээр эсгий углааш оёх, арьсаар төрөл бүрийн бэлэг дурсгалын бүтээгдэхүүн хийхийг заалгаж одоо гар урлалын төвөөр ирж төрөл бүрийн бүтээл хамтран хийж байна. Түүнээс хойш эсгий углааш, гар урлалын арьсан бүтээгдэхүүн урлаж 180,000 төгрөг олсон байна. Одоо цагаан сараар ах дүү нартаа өгөх бэлэг дурсгалын зүйлс хийж байгаа. Найз Долгорсүрэнгээс болон энд ирж байгаа хүмүүсээс их юм сурч байна. Цаашдаа хамтран илүү ихийг сурч, бүтээж, зарж борлуулж, ерхийн орлогоо нэмэгдүүлэх байх.

Хөтөлбөрийн үр шим хүртэгч А.Цэвэлмаа:



Би эсгий урлалын сургалтанд хамрагдсанаасаа хойш эсгий бойтог 5ш, эсгий углааш 27 ширхэгийг хийж борлууллаа. Одоо цагаан сарын бэлгэнд өгөхөөр 20 ш углааш оёж байна. Би ХААН банкинд эдийн засагчаар ажилладаг. Чөлөөт цагаараа ирж гар урлалаа хийж байна. Энэ төсөл бидэнд хэрэгтэй сайхан төсөл болсон гэж дүгнэж байгаа. Цахилгаан хөл, оёдлын машин, арьс хээлэгч машин, арьсан оёдлын машин, эсгий сэмлэгч машин дээр ажиллаж сурсан одоо хэнийг ч гуйхгүй, хэнээс ч хараат бус, эндээ ирээд л бүх зүйлээ хийж чадаж байна. Бид иргэдэд зааж сургах ажлыг тасралтгүй хийж хамтран хөгжиж байгаа. Цаашид хэрхэн хөгжүүлэх, өргөжүүлэх, нэгдэж өрхийн орлогоо

нэмэгдүүлэх талаар хэлэлцэж гарц шийдэл эрж, төлөвлөгөөтэй боловсруулсан. 2020 онд гар урлалын төвийн байрыг томруулах, гар урлалын бүтээгдэхүүн борлуулах цэг бий болгох гээд олон зүйлээр сум, орон нутгийн зүгээс биднийг дэмжиж байгаад талархаж байна.

ХАНБОГД СУМАНД САНХҮҮЖИЛТИЙН КВОТООР ХЭРЭГЖСЭН “ЭРҮҮЛ НАСЖИЛТ” ХӨТӨЛБӨР

Сэтгэгдэл:



Хөтөлбөрийн үр шим хүртэгч Д.Чимид:

“Эрүүл насжилт” төслөөр олон сайхан техник хэрэгсэлтэй болсонд Баян багийн ахмадууд баяртай байгаа. Би 89 нас хүрч байна. Эдгээр техник хэрэгслийн тусламжтайгаар даралтаа тогтмол үздэг, хөл, гараа тэнийлгэх дасгалуудыг хүссэн цагтаа ирж хийдэг боллоо. Энэ төвөөр маш олон ахмадууд үйлчлүүлж байгаа гэсэн. Тиймээс хүлээх дараалал жаахан их байдаг.



Хөтөлбөрийн үр шим хүртэгч Ц.Буянтогтох:

“Эрүүл насжилт” төслийн хүрээнд ирсэн техник хэрэгслүүд ахмад настуудад тун ашиг тустай байна. Ялангуяа хуян, шар ус тараах, даралт үзэх, массаж хийх гэх мэт тоног төхөөржмүүдийг түлхүү хэрэглэж байгаа. Даанч энд 400 гаруй ахмад үйлчлүүлдэг учир дараалал ихтэй байдаг.

БАЯНДАЛАЙ СУМАНД САНХҮҮЖИЛТИЙН КВОТООР ХЭРЭГЖСЭН “ГЭРЭЛТҮҮЛГИЙН АЖИЛ” ХӨТӨЛБӨР

Сэтгэгдэл:



Баяндалай сумын ЗДТГ-ын дарга Т.Отгонбаатар:

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”, “Эс Жи Эм” компанитай гэрээ байгуулан сумын төвийн гэрэлтүүлэг, цамхагийн ажлыг 100 хувь бэлэн болгож хүлээлгэн өгсөн.

2019 онд манай сумын бүтээн байгуулалтад улс болон аймаг орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрөөс 14 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулан бүтээн байгуулалтын ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүний нэг нь сумын төвийн гэрэлтүүлэг цамхаг байлаа. Энэхүү цамхагтай болсноор хүүхэд багачууд хичээл сургуульдаа явахдаа айж эмээх зүйлгүй гэрэлтэй гудмаар явах болж, иргэд тав тухтай орчинд амьдрах, болзошгүй аваар осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх боломж бүрдлээ. Иргэдийн нийгмийн хэрэгцээг хангах ихэд ач холбогдолтой, олон нийтэд хүртээмжтэй хөрөнгө оруулалтын ажил болсон. Орчин үеийн технологийн шийдэлтэй 8 цамхаг, 30ш гэрэлтэй гэрэлтүүлэг нь эдийн засгийн хувьд хэмнэлттэй, тусгал сайтай атлаа цахилгаан бага зарцуулдаг юм.

НОМГОН СУМАНД САНХҮҮЖИЛТИЙН КВОТООР ХЭРЭГЖСЭН “ЭРЭГТЭЙ ТЕХНОЛОГИЙН КАБИНЕТ” ХӨТӨЛБӨР

Сэтгэгдэл:

Номгон сумын ЕБС-ийн дизайн технологийн багш Д.Ганболд:



Өмнөговь аймгийн Номгон сумын эрдэмтэн Р.Цэрэндоржийн нэрэмжит ЕБС-ийн хөвгүүдийн кабинетэд тоног төхөөрөмж нийлүүлэх хөтөлбөр төслийг “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-аас санхүүжүүлж, дизайн технологийн хичээлийг заах, зохион байгуулахад шаардлагатай бүхнийг бүрдүүлсэн, сургалт, дадлагын зориулалт бүхий орчин үеийн шийдэлтэй тохилог кабинетийг үлгэр жишээ болохуйцаар тохижууллаа. 15 сая төгрөгийн санхүүжилтээр 65 нэр төрлийн 343 ширхэг багаж тоног төхөөрөмж нийлүүлсэн. Тус төслийн ашиг тусыг 6-9-р ангийн 105 эрэгтэй сурагч хүртээд байна.



Төслийг хэрэгжүүлснээр дизайн технологийн хичээлээр сурагчдад олгох учиртай уламжлалт болон орчин үеийн техникийн дизайн, арга зүйн мэдлэгийг эзэмшиж, мод, металл эдлэлтэй ажиллах арга ажиллагаанд суралцах, багаж, тоног төхөөрөмжтэй зөв харьцах, ахуйн хэрэглээний цахилгаан тоног төхөөрөмжийг ажиллуулж сурах зэрэг дадлагын олон боломж нээгдсэн. Мөн багш, сурагчдын хамтын ажиллагаа сайжирч, хамтран бүтээл хийх, сурагчид өөрсдөө бие даан хөгжих, сэтгэн бодох, бүтээл хийх, үзэсгэлэн гаргах, бусад сургууль цэцэрлэг, хувь хүмүүсийн захиалгаар бүтээгдэхүүн хийх зэргээр хөдөлмөрийн зөв дадал хэвшилд суралцах боломжтой боллоо. Сурагчид маань уламжлалт үндэсний тоглоом, шагайн харвааны хэрэгсэл, оньсон тоглоом, токарьт мод зорох зэрэг бүтээл хийж сурч байгаа. Хөтөлбөрийн үр дүнд сургуулийн нийт эцэг, эх, багш, сурагчид сэтгэл хангалуун байгаа.



Та бүхэндээ ажилд нь амжилт хүсье баярлалаа.

БУЛГАН СУМАНД САНХҮҮЖИЛТИЙН КВОТООР ХЭРЭГЖСЭН “ЖИШИГ ГУДАМЖ” ХӨТӨЛБӨР

Сэтгэгдэл:

Булган сумын иргэн Х.Энэбиш:

Хаалга хашааны тохижилтонд сэтгэл өндөр байгаа. Сайхан хаалга хийж өгсөнд маш их баярлаж байна. Цаашдаа сумын бүх айлын хашааг тохижуулж жигдхэн сайхан болгохыг зорин ажиллаж байгаа та нартаа ажлын амжилт хүсье.



БАЯН-ОВОО СУМАНД САНХҮҮЖИЛТИЙН КВОТООР ХЭРЭГЖСЭН “ШИНЭ СОНГОЛТ” ХӨТӨЛБӨР

Сэтгэгдэл:

Баян-Овоо сумын ЕБС-ийн мэдээлэлзүйн багш Ц.Бямбажав:

Сурагчдад

- Компьютерийн хүчин чадал сайжирснаар сургалтын үйл ажиллагаа хэвийн явуулах боломжтой болж, хичээл төлөвлөгөөний дагуу чанартай явагдаж байна.
- Сурагчдын идэвх нэмэгдсэн нь сургалтын компьютерүүд шинэчлэгдэж, хүртээмжтэй, дагалдах хэрэгсэл нь бүрэн ажиллагаатай болсонтой холбоотой гэж үзэж байна.
- Сургалтын орчин аюулгүй, баталгаатай болсон.
- Хичээлийн бус цагаар дунд ангийн 75 сурагчид мэдээлэл технологийн кабинетэд сууж бие даан хичээллэх, чадвараа хөгжүүлэх боломж бүрдсэн.
- Орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалтын таатай орчин бүрдсэнээр сурагчдын кабинет ашиглалт сайжирсан.



Хамт олонд

- Сургалтын зохист орчин бүрдсэнээр хичээл зааж байгаа багшид ажлын ачаалал багассан
- Кабинетийг багш, ажилчид ашиглах бүрэн боломжтой.
- Ажилчид тайлан мэдээгээ бичих зэрэгт тогтмол ашиглаж байна. Одоогоор 3 ахмад ажилчин компьютерийн хэрэглээний программд суралцаж байна.

МАНЛАЙ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГА БАРИХ ТӨСӨЛ

Манлай сумын цэцэрлэгийн эрхлэгч Н.Хашчулуу:

Тус цэцэрлэг нь анх 1962 онд байгуулагдсан түүхтэй. 1973 онд зориулалтын 50 хүүхдийн цэцэрлэг байранд үйл ажиллагаа зохион байгуулж байгаад 2013 онд 100 хүүхдийн цэцэрлэг болж өргөжсөн. Гэсэн хэдий ч сумын хэмжээнд тойргийн 2-5 настай хүүхэд 260 гаруй болж жилээс жилд хүн амын өсөлт нэмэгдэх хэрээр цэцэрлэгт хамрагдах хүүхдийн тоо нэмэгдэж иргэд хүүхдээ цэцэрлэгт хамруулах хүсэлт удаа дараа тавьж 100 хүүхдийн цэцэрлэгт 120-130 хүүхэд хамруулж байсан ч цаана нь цэцэрлэгт хамрагдах хүсэлтэй хүүхдийн нэрсийн жагсаалт уртын урт цуваа



үүсгэсээр байсан билээ. 2019 онд “Говийн Оюу” хөгжлийг дэмжих сангийн хөрөнгө оруулалтаар 100 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, /тоног төхөөрөмжийн хамт/ баригдаж байгууллага маань өргөжин тэлж нийт 14 орон тоотой байсан бол 30 орон тоотой болж 100 хүүхдийн хүчин чадалтай байсан барилга 200 хүүхдийн хүчин чадалтай болж тус суманд ажиллаж амьдарч байгаа иргэд хөдөлмөрчид малчид хүүхдээ хүссэн үедээ цэцэрлэгт хамруулах өргөн боломж нээгдэж, багш ажилчдын хөдөлмөрлөх аятай тухтай орчин бүрдсэн байгаа явдалд сумын удирдлагууд болоод тус цэцэрлэгийн ажилтан албан хаагчид багш нар маш сэтгэл өндөр байгаа.

Одоогоор тус цэцэрлэгт 190 гаруй хүүхэд сургуулийн өмнөх бололвсролд хамрагдаж байна.

БАЯН-ОВОО СУМЫН УУРЫН ЗУУХНЫ БАРИЛГА БАРИХ ТӨСӨЛ

Долоон шар заг ОНӨААТҮГ-ын дарга Д.Сонинбаяр:



2019 оны 11 дүгээр сард Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн санхүүжилтээр Баян-Овоо суманд ОХУ-ын Барнаулд үйлдвэрлэгдсэн Сталь-20 маркын гангаар үйлдвэрлэсэн хагас автомат 2МВт-ийн 2 ширхэг усан халаалтын тогоотой, шинэ уурын зуухны барилга ашиглалтанд орсон. Манайх хуучин 1,5МВт-ын 2 зуухаар галладаг байсан бөгөөд хүчин чадал нь хүрэлцдэггүй байсан. Энэ жил 10 байгууллага, 40 айл өрхийг дулаанд холбож хэрэглэгчдийн тоогоо нэмэгдүүлсэн. Төслийн үр дүнд сумын дулаан хангамжийн хүчин чадлыг гурав дахин нэмэгдүүлсэн бөгөөд хагас автомат зуух учир ажилчдын хөдөлмөрийг хөнгөвчилж, ажиллах орчныг

сайжруулсан. Манай байгууллагын ажилчид төдийгүй сумын дулааны хэрэглэгч байгууллага, иргэд сэтгэл хангалуун тав тухтай сайхан өвөлжиж байна.

МАНДАЛ-ОВОО СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН БАРИЛГА БАРИХ ТӨСӨЛ

Мандал-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч А.Мөнхтоого:



Мандал-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн хөгжил цэгцлэлтэд үнэтэй хувь нэмэр оруулан шинэ 10 ортой 2 давхар барилгыг барьж ашиглалтанд оруулснаар ажилчид, үйлчлүүлэгчдийн маань ая тав тухтай орчныг бүрдүүлж, тааваараа ажиллах нөхцөлийг бий болгож өгсөнд бид бүхэн баяртай байна.

Танай хамт олонд ажлын өндөр амжилтыг хувиасаа болон Мандал-Овоо сумын эрүүл мэндийн төвийн хамт олныхоо өмнөөс хүсэн ерөөе.